ЕСҮС ХРИСТИЙН ХОЖМЫН ҮЕИЙН ГЭГЭЭНТНҮҮДИЙН СҮМ • 2018 ОНЫ 12-Р САР

Лиахона

Христийн мэндэлсний баярын хамгийн сайхан бэлэг, х. 14

Нэгэн номлогчийн сүүлчийн захиас, х. 18

Бурханлаг чадавхдаа хүрэхийн төлөө өсөж хөгжих нь, х. 20

Хуучин Гэрээнээс Есүс Христийг хэрхэн олж болох вэ, х. 32

ХҮҮХДЭД ЗОРИУЛСАН ХЭСЭГ
АНХ УДАА
1-Р САРЫН ДУГААРТ
ТУСДАА ГАРНА

СҮМ
ЭНД
БИЙ

Ла Пас
Боливи

Цаст Иллимани уул өндөрлөг газарт байрлах, улаан тоосгон барилгатай Ла Пас хотын цаана дүнхийн харагдана. Ла Пас хотод засгийн газрын олон байгууллага байдаг тул Боливигийн засаг захиргааны төв хэмээн нэрлэх нь бий.

Андын нурууны номлолд үйлчилж байсан номлогчид 1964 оны 11-р сард Боливид ирж, 19 хүн оролцсон цуглааныг хийжээ. Сарын дараа тэд анхныхаа хөрвөгчид баптисм хүртээж, гишүүнээр баталсан байна. Өнөөдөр Боливи улс дахь Сүмийн гишүүдийн тоо 203000 гаруй болж, 5 номлол, 255 цуглаанд цугларах болжээ. Хамгийн ойр байрлах ариун сүм нь Ла Пасаас машинаар 7 цаг явж хүрэх газарт буюу 233 километрийн зайд байх Кочабамбад байдаг.

Боливи дахь Сүм орон нутгийн хүмүүнлэгийн төслүүдээрээ, тухайлбал тэргэнцэр болон нярайн эмнэлгийн тоног төхөөрөмж хандивлах; цус хандивлах аянд оролцох; хөдөө аж ахуйг болон гэртээ ногоо тарих, тосгоноо хөгжүүлэх ажлыг дэмжих; хэрэгцээтэй цаг үед тусламжийн үйл ажиллагаа зохион байгуулдаг зэргээрээ олонд танигджээ.

- Ла Пас хотын бүс дэх хожмын үеийн гэгээнтнүүд 40 өөр газар цугладаг.
- Хамгийн түгээмэл хэрэглэдэг хэл нь испани хэл боловч олон хүн кечуа, аймара эсвэл гуарани хэлээр ярьдаг.
- Боливигийн хамгийн анхны бүрэн цагийн номлогч 1967 онд дуудагджээ.
- 2014 оны 12-р сард Боливи улсад Сүм байгуулагдсаны 50 жилийн ой тохиосон. Ла Пас дахь гишүүд 2015 оны 1-р сард уг ойн баярыг орон нутагтаа тэмдэглэжээ.

“Сүмийн удирдагчид **биднийг** юуг хийгээсэй хэмээн хүсдэг вэ?”

Сургалтын хөтөлбөр боловсруулах баг 2019 оны *Ирээд, Намайг дага* шинэ сургалтын материалыг туршиж үзэхийг гишүүдээс хүсэхэд бид энэ хүсэлтийг “Эхлээд би ‘Энэ материал бол шал дэмий тэнэг зүйл!’ гэж бодон, Бүтэлтэй болно гэдэгт эргэлзэж байлаа” мэтийн тайлбарын хамт ахин дахин сонссон билээ. Гэвч эхэн үеийн эдгээр асуудал “судраас суралцах үйл явц маань бүрэн өөрчлөгдсөн” эсвэл “болж байна” зэрэг нотолгоогоор аажимдаа солигдсон юм.

Яагаад тэдний туршлага танд хамаатай вэ? Яагаад гэвэл, энэ шинэ сургалтын материал зөвхөн сүм дэх багшид тань төдийгүй танд болон танай гэрт байгаа гэр бүлийнхэнд тань зориулагдсан юм.

Тэргүүн Зөвлөлийн санал болгосноор, *Ирээд, Намайг дага* сургалтын материалын шинэ үе шатны ард байх зарчмуудыг энэ дугаарт авч үзсэн. Энэ нь 2013 онд танилцуулсан, өсвөр үеийнхэнд зориулан дахин боловсруулан гаргасан сургалтын хөтөлбөр, 2016 оны *Аврагчийн арга барилаар заах нь* товхимол, 2018 онд нэвтрүүлсэн Мелкизедек санваар болон Халамжийн нийгэмлэгийн хичээлийн хөтөлбөрийн дараа гарч буй сургалтын материал юм.

Сургалтын хөтөлбөр боловсруулах ажилд зааварчилгаа өгсөн ахлагч Жэффри Р.Холланд, хэрэв хэрэгжүүлэх юм бол биднийг агуу бөгөөд мөнхийн арга замаар өөрчилж чадах зөвлөгөөг 20-р хуудаснаас эхлэн бидэнд өгсөн. Энэ нь зөвхөн сургалтын материал биш, харин өдөр тутам сайн мэдээнээс суралцаж, үүний дагуу амьдрах арга зам юм.

Би бошиглогч, үзмэрч, илчлэгчид энэхүү гэр төвтэй, Сүмийн дэмжлэгтэй шинэ сургалтын хөтөлбөрийг боловсруулах ажлыг хэрхэн удирдахыг харахдаа уг сургалтын материал нь сайн мэдээний дагуу амьдрах явцдаа зааварчилгаанд тулгуурлах хандлагыг багасгах талаарх Сүмийн шилжилт өөрчлөлтөд хэрхэн нийцэж мөн сүнслэг өсөлт хөгжлийнхөө төлөө өөрсдөө илүү үүрэг хариуцлагатай хандахад биднийг урьж байгаа нь намайг гайхшируулсан билээ. Бид ийнхүү үйлдсэнээр илүү агуу гэрэл болон үнэнийг хүлээн авах ба Есүс Христийг дагаж, хилэнцэт нэгнийг орхих чадвар маань өсөн нэмэгдэж (С ба Г 93:29–40-ийг үзнэ үү), бидний амьдралд амар амгалан, энэ дэлхийд сайн сайхныг авчрах болно гэдэгт би бүрэн итгэлтэй байна.

Майкл Маглби
Сургалтын хөтөлбөр боловсруулах албаны захирал

Онцлох өгүүллүүд

8 Тохинууллын зарчмууд: Санаа тавьдаг болохоо ойлгуул
Та тохинуулдаг хүмүүстээ хайраа харуулж болох хэд хэдэн аргаас суралц.

14 Аврагчийн амар амгалангийн бэлэг
Ахлагч Л.Витни Клэйтон
Есүс Христ хүнд хэцүү цаг үед амар амгаланг хэрхэн олохыг бидэнд заасан.

20 Амьдралаа хувийн өсөлт хөгжлийн сэтгэл хөдөлгөм аялал болгох нь
Ахлагч Жэффри Р.Холланд
Ирээд, Намайг дага шинэ хөтөлбөр нь бидэнд бурханлаг чадавхдаа хүрэхийн төлөө өсөж хөгжихөд тусална.

32 “Би бол Би байдаг”: Хуучин Гэрээн дээрх Есүс Христийн бэлгэдлүүд
Стивэн П.Шанк
Аврагчийн үүргийг болон бидний Түүнтэй харилцах харилцааны чухал хэсгүүдийг заадаг эртний бэлгэдлүүд



Өсвөр үеийнхэнд зориулав

46 Нэг бай: Баяр тэмдэглэх шалтгаан
Ерөнхийлөгч Даллин Х.Өүкс
1978 оны санваарын талаарх илчлэлтийн хамгийн чухал үр нөлөөнүүдийн нэг бол гадуурхлыг үгүй хийх бурханлаг дуудлага юм.

51 Нэг бай: Гүүр барих нь
Ерөнхийлөгч Рассэлл М.Нэлсон
Соёл, хэл яриа, хүйс, яс үндэсний ялгаа нь гэрээт замд чухал биш.

52 Аврагчийн адил тохинуулах нь
Эрик Б.Мөрдок
Есүс Христ хувь хүн бүрийг хэрхэн хайрлаж мөн тэдэнд үйлчлэх төгс загварыг өгсөн.

56 Христийн мэндэлсний баярын сүнсийг мэдрэх 7 арга зам
Шарлотт Ларкэбэл

60 Христийн мэндэлсний баярын бэлгийн жагсаалт-даа Сүнсний бэлгүүдийг нэмэх нь
Дэвид Диксон
Хэрэв бид Сүнсний бэлгүүдийг хүсэх хүсэлтэй байх юм бол тэдгээр нь бидэнд өгөгдөхөд бэлэн байдаг.

62 Асуулт, хариулт
Би Аврагчийн хайрыг хүртэх эрхгүй мэт надад санагддаг. Би хэрхэн энэ мэдрэмжээсээ салж, өөрийн үнэ цэнийг мэдэрч болох вэ?

64 Зурагт хуудас: Үүнийг боломжтой болгодог бэлэг

65 Бошиглогчийн урилга: Дэлхийг өөрчлөхөд туслахын тулд таны хийж чадах 5 зүйл
Ерөнхийлөгч Рассэлл М.Нэлсон

ХАВТСАН ДЭЭР
Ариун шөнө, Майкл Малм.

Хүүхдүүдэд зориулав

66 Карлын Христийн мэндэлсний баярын бэлэг
Жулиан Тэннэй Домэн
Карл Христийн мэндэлсний баярын өглөө эрт гэрийнхэндээ өгөх төгс бэлгийг олов.

68 Кэйти, Квинси хоёр
Эван Валентайн, Марисса Виддисон
Квинси найзыгаа хэрхэн тайтгаруулахаа мэдэж байв.

70 Хүндэтгэл бол хайр
Луайпоу В.
Бишрэл хүндэтгэлтэй байхыг санасан маань надад сандрахгүй байхад тусалсан.

Богино өгүүллүүд

5 Анхны Христийн мэндэлсний баярын аялал
Кристина Кросланд

6 Итгэлийн хөрөг: Бланка Солис—Парагвай, Асунсион

12 Гэрийн болон айлчлагч багш нар маань хаана байгаа юм бол?
Жийн Б.Бингам

18 Өчигдрийнхөөс арай илүү бай
Луис Омар Кардозо

30 Индэр дээр: Шийдвэрүүд болон гайхамшгууд: Би одоо харж байна
Ирина В.Крацэр

36 Эргэн дурсахуй: Ганц улаан чийдэнгийн шил
Лори Риэс

37 Сүмд үйлчлэх нь: Үйлчлэлээс ирэх өсөлт хөгжил
По Ниэн (Филип) Чоу болон Пэтра Чоу нар

38 Хожмын үеийн гэгээнтнүүдийн дуу хоолой

80 Биднийг дахин уулзах хүртэл: Иосеф Смитээр дамжуулан Христийг таньж мэдэх нь
Ахлагч Брус Р.Макконки

Залуучуудад зориулав

42 Том шийдвэрүүдийн дундах намуухан зөөлөн дуу хоолой
М.Жозэф Браф
Сүнслэг өдөөлтүүдийг анхааралтай сонсож, Их Эзэнд итгэх юм бол Тэр таны замыг удирдан чиглүүлнэ.

71 Шавар шавхайнаас аварсан нь
Ахлагч Адилсон дэ Паула Паррэлла
Хөршүүдийн маань гэр орон шаварт сүйдэхэд бид тэдэнд тусалж чадах юм байна гэдгээ мэдсэн.

72 Төлөөлөгчид Христийн талаар гэрчилдэг
Ахлагч Квинтин Л.Кук

73 Бидний хуудас

74 Гэрлээ гэрэлтүүл: Дэлхийг гэрэлтүүлдэг ах нар
Ганагийн эдгээр ах өөрсдийн эргэн тойрон дахь хүмүүсийг гэрэлтүүлдэг.

76 Судрын түүхүүд: Иона ба халим
Ким Вэбб Рэйд

79 Будах хуудас

Энэ дугаарт нуусан Лиахонаг олоорой. Сэжүүр: “_____чимээгүй суухаас илүү зүйл.”

ИЛҮҮ ИХИЙГ ОЛЖ МЭД

Та Gospel Library аппликэйшн болон comefollowme.lds.org вэбсайт дээр дараах үйлдлийг хийж болно.

- Энэ дугаарыг ол.
- Зөвхөн цахим хувилбараар гарах агуулгыг унш.
- Өмнөх дугааруудыг хай.
- Өөрийн түүх, санал зөвлөмжийг илгээ.
- Сэтгүүл захиал эсвэл бусдад захиалж өгч, бэлэглэ.
- Цахим хэрэгслийн тусламжтайгаар хувийн сургалтаа сайжруул.
- Таалагдсан нийтлэл, видео бичлэгээ хуваалц.
- Нийтлэлүүдийг татаж ав эсвэл хэвлэ.
- Дуртай нийтлэлүүдээ сонс.

БИДЭНТЭЙ ХОЛБОО БАРИХ

Асуулт, санал зөвлөмжөө liahona@ldschurch.org хаяг руу э-мэйлээр илгээнэ үү.

Итгэлийг тань хүчирхэгжүүлсэн түүхийг liahona.lds.org вэбсайтад илгээ эсвэл доорх хаягаар шуудангаар ирүүлнэ үү:

Liahona, fl. 23
50 E. North Temple Street
Salt Lake City, UT, 84150-0023, USA

ЗӨВХӨН ЦАХИМ ХУВИЛБАРААР ГАРАХ НИЙТЛЭЛҮҮД

ГЭРЭЛ ЗУРГИЙГ NEONBRAND/UNSPLASH

Та өөрийгөө хангалтгүй гэж мэдрэх үедээ санах 3 зүйл

Лиа Бартон

Хөгжихгүй байгаа мэт санагдаж байна уу? Та хэрхэн асуудлаа амжилттай шийдэж, дахин өсөж хөгжиж эхлэх вэ?

Ахыгаа нас барсны дараа би "Яагаад?" гэж асуухаа больсон шалтгаан

Зимэна Кардозо Корбалан

Ах нь номлолд байхдаа нас барсны дараа Зимэна амар амгаланг хэрхэн олж авснаа тайлбарлав. Эцгийнх нь ярьсан түүх энэ дугаарын 18-р хуудсан дээр бий.

December 2018 оны 12-р сар, 19, №7
ЛИАХОНА 14797 363

Есус Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн олон улсын сэтгүүл

Тэргүүн Зөвлөл: Рассэлл М.Нэлсон, Даллин Х.Өүкс, Хэнри Б.Айринг

Арван хоёр Төлөөлөгчийн Чуулга: М.Рассэлл Баллард, Жэффри Р.Холланд, Дийтр Ф.Угдорф, Дэвид А.Бэднар, Квинтин Л.Кук, Д.Тодд Кристоффэрсон, Нийл Л.Андэрсэн, Роналд А.Расбанд, Гари И.Стивэнсон, Дэйл Г.Рэнланд, Гэррит В.Гонг, Улиссэс Соарэс

Эрхлэгч: Хюго И.Мартинэз

Зөвлөхүүд: Бриэн К.Эштон, Рэндэлл К.Бэннэтт, Бэкки Крэйвэн, Шэрон Юбанк, Кристина Б.Франко, Доналд Л.Холлстром, Эрих В.Копишкэ, Линн Г.Роббинс

Гүйцэтгэх захирал: Ричард И.Хийтон

Сүмийн сэтгүүлийн захирал: Аллан Р.Лойборг

Бизнесийн менежер: Гарфф Каннон

Гүйцэтгэх редактор: Адам С.Олсон

Гүйцэтгэх захирлын туслах: Раян Карр

Хэвлэлийн туслах: Фрэнсиска Олсон

Редакцийн баг: Мэрисса Дэннис, Дэвид Диксон, Дэвид А.Эдвардс, Маттью Д.Флиттон, Лори Фуллэр, Гаррэтт Х.Гарфф, Ларин Портэр Гаунт, Жон Райн Жэнсэн, Шарлотт Ларкэбэл, Майкл Р.Моррис, Эрик Б.Мөрдок, Салли Жонсон Одкөрк, Жошуа Ж. Пэркий, Жан Пинбороу, Ричард М.Ромни, Минди Сэлу, Чакэлл Вардлэй, Марисса Виддисон

Зураглал чимэглэлийн удирдагч менежер: Ж.Скотт Кнудсэн

Зургийн дарга: Тадд Р.Пэтэрсон

Уран бүтээлийн ажилтнууд: Жинэтт Эндрьюс, Фэй П.Андрус, Мэндийн Бэнтли, С.Кимбалл Ботт, Томас Чайлд, Дэвид Грийн, Коллийн Хинкли, Эрик П.Жонсэн, Сюзан Лофгрэн, Скотт М.Моой, Эмили Чиэко Эмингтон, Марк В.Робисон, Брэд Тиэри, К.Никол Вокэнорст

Оюуны эмчийн зохицуулагч: Коллэтт Нэбэкэр Аун

Хэвлэлийн менежер: Жэйн Анн Пэтэрс

Хэвлэх баг: Ира Глэн Адэйр, Жюли Бөрдэтт, Томас Ж.Кронин, Брайн В.Гайги, Жинни Ж. Нилсон, Дэрик Ричардсон

Хэвлэлийн эх бэлтгэгч: Жошуа Дэннис, Аммон Харрис

Хэвлэлийн захирал: Стивэн Т.Льюис

Хуваарилалт хариуцсан захирал: Трой Р.Баркэр

Нэгдсэн Улс, Канадаас бусад орон дахь захиалга болон үнийн талаар орон нутгийн сүмийн хангамжийн төв болон тойрог, салбарынхаа удирдагчтай холбоо барина уу.

Гар бичмэл болон асуултаа интернэт вэбсайт liahona.lds.org руу, шуудангаар Liahona, Rm. 2420, 50 E. North Temple St., Salt Lake City, UT 84150-0024, USA хаягаар; эсвэл э-мэйлийн: liahona@ldschurch.org хаягаар ирүүлнэ үү.

Лиахона (Мормоны Номон дахь уттаараа бол "луужин" бүюу "залагч") нь албани, англи, армен, бислам, болгар, вьетнам, гайти, герман, грек, дани, индонез, ирланд, испани, итали, камбож, кирибати, латви, литов, малагаш, маршалл, монгол, нидерланд, норвеги, орос, польш, португаль, румын, свахили, самоа, себу, словени, солонгос, сингал, тагалог, тай, тамил, тахити, телуг, тонга, украйн, унгар, урду, фижи, фин, франц, хинди, хорват, хятад, хятад (хялбаршуулсан), чех, швед, эстони, япон хэлээр нийтлэгддэг. (Жилд нийтлэгдэх дугаарын тоо улс бүрд өөр байна.)

© 2018 by Intellectual Reserve, Inc. Бүх эрх хамгаалагдсан. Америкийн Нэгдсэн Улсад хэвлэв.

Зохиогчийн эрхийн талаарх мэдээлэл: Өөрөөр заагаагүй бол хувь хүмүүс арилжааны бус зорилгоор (Сүмийн дуудлага зэрэг) хувийн хэрэгцээндээ *Лиахона* гаас материал хувилан авч, ашиглаж болно. Энэ эрх ямар ч үед өөрчлөгдөхгүй. Хэрэв зураг чимэглэлийн тухайд ямар нэг хязгаарлалт тогтоосон бол үүүлэнгийн материалыг хуулбарлаж болохгүй. Зохиогчийн эрхийн талаар асуух зүйл байвал дараах хаягаар хандана уу. Intellectual Property Office, 50 E. North Temple St., FL 13, Salt Lake City, UT 84150, USA хаягаар; эсвэл электрон шуудангийн cor-intellectualproperty@ldschurch.org хаягаар ирүүлнэ үү.

For Readers in the United States and Canada: December 2018 Vol.19, No. 7. LIAHONA (USPS 311-480) Mongolian (ISSN 1525-7584) is published six times a year (January, April, June, July, October, and December) by The Church of Jesus Christ of Latter-day Saints, 50 E. North Temple St., Salt Lake City, UT 84150. USA subscription price is $5.00 per year; Canada, $6.00 plus applicable taxes. Periodicals Postage Paid at Salt Lake City, Utah. Sixty days' notice required for change of address. Include address label from a recent issue; old and new address must be included. Send USA and Canadian subscriptions to Salt Lake Distribution Center at address below. Subscription help line: 1-800-537-5971. Credit card orders (American Express, Discover, MasterCard, Visa) may be taken by phone or at store.lds.org. (Canada Post Information: Publication Agreement #40017431)

POSTMASTER: Send all UAA to CFS (see DMM 507.1.5.2). NONPOSTAL AND MILITARY FACILITIES: Send address changes to Distribution Services, Church Magazines, P.O. Box 26368, Salt Lake City, UT 84126-0368, USA.

Кристина Кросланд
Сүмийн сэтгүүлүүд

АНХНЫ ХРИСТИЙН МЭНДЭЛСНИЙ БАЯРЫН АЯЛАЛ

Бид Христийн мэндэлсний баярын түүхийг жил бүр ярьдаг ч Мари, Иосеф хоёрын хийсэн аяллыг хэчнээн удаа төсөөлөн бодож байсан бол? Тэдний итгэл, золиослол энэ түүхийн чухал хэсэг юм.

1. Лук 1:26–27, 30–31

Мари 400–500 хүнтэй Назар хэмээх тосгоных байв.[1] Дэлхийнхний хувьд тэрээр энгийн нэгэн тариачин охин байсан. Гэсэн ч тэр Иосефын хамт Бурханы Хүүг өсгөх дуудлагаа хүлээн авсан билээ.

2. Лук 2:4–5

Бетлехем рүү аялахад дор хаяж 4–5 өдөр болдог байсан[2] бөгөөд хадат толгодоор илжигтэй явсан тухай сударт гардаггүй. Мари хэдий "хүүхэдтэй болсон" байсан ч Иосефын хамт аялж, Мессиа Бетлехемд төрөх болно гэсэн бошиглолыг гүйцэлдүүлсэн юм (Мика 5:2-ыг үзнэ үү).

3. Лук 2:7–11

Бетлехемд Иосеф, Мари хоёрт өөрсдийн гэсэн гэр орон эсвэл хаадын Хааныг тавих хүүхдийн ор байсангүй. Энгийн байдалд төрсөн энэ хүүхдийн Бурханы хүү болох тодорхой тэмдгийг гэрчлэхдээ тэд ихэд дарууссан нь тодорхой.



4. Матай 2:13–14

Хэнд ч хэлэлгүйгээр энэ жижиг гэр бүл хот, улсаа орхин явах хэрэгтэй болов.

Христ хүүг хоёр нас ч хүрээгүй байхад Түүний амь насанд аюул учирсан (Матай 2:16-г үзнэ үү). Гэвч Аврагчаа гэх үнэнч сэтгэл болон хайр нь Мари, Иосеф хоёрыг Египет рүү урт аялалд гарахад хүргэсэн юм.

5. Матай 2:19–23

Иосеф, Мари хоёр танил биш газар нутагт хэсэг хугацааг өнгөрүүлсний дараа амьдралынхаа хамгийн урт аяллыг хийжээ. Гэхдээ энэ удаа тэд гэртээ харьж байсан тул туулах зам нь ойрхон мэт санагдсан нь лавтай. Тэд гэртээ эргэж ирснийхээ дараа Бурханд итгэж, "Назарынх гэж дуудагдах" Түүнийг өсгөжээ (Матай 2:23).

Мари, Иосеф хоёрын адил, **БИД Ч ГЭСЭН ЕСҮС ХРИСТТЭЙ ХАМТ АЯЛЖ БАЙГАА.**

Аялал маань урт удаан, хүнд бэрх байж болох ч итгэлийн алхам бүр мөнх амьдралд буюу Өөрийн аяллаар авралыг боломжтой болгосон хайрт Аврагчийн маань өгсөн бэлэгт ойртуулдаг. ■

ЭШЛЭЛҮҮД

1. James E. Strange, "Nazareth," *Anchor Bible Dictionary* -ийг үзнэ үү.
2. D. Kelly Ogden, "The Road to Bethlehem," *Tambuli,* Dec. 1993, 41-ийг үзнэ үү.

ГАЗРЫН ЗУРАГ БОЛОН ХӨШӨӨНИЙ ЗУРГИЙГ GETTY IMAGES-ЭЭС АВАВ МӨН КАРП ХЭЙНРИХ БЛОХЫН *ЗАРЛАЛ* ЗУРГААС ХЭСЭГЧЛЭН АВАВ; РӨҮЗ ДАТОК ДОЛП, *ЗУТСАН НЬ.*

Нөхөр, эх хоёр нь өвдөж, өөрсдийгөө харж хандах чадваргүй болоход Бланка тэднийг бүтэн цагаар асрахын тулд ажлаасаа гарчээ. Бланка Их Эзэнд итгэж найдсанаар өөрт байхаасаа илүү их хүч чадлыг олж авсан байна.

КОДИ БЭЛЛ, ГЭРЭЛ ЗУРАГЧИН

Бланка Солис

Парагвай, Асунсион

Би үргэлжлүүлэн урагшлах хүч чадлыг Их Эзэнээс гуйн залбирахаас залхдаггүй. Би Түүнд цаг үргэлж залбирдаг. Гэр бүлд минь тохиолдсон зүйлс Их Эзэн надтай хамт энэ бүхнийг туулсан гэдгийг ойлгоход надад тусалсан. Тэр надад дахин өндийн босох боломжийг өгдөг. Их Эзэний надад өгдөг хүч чадал юутай агуу вэ!

Би хэзээ ч өөрөөсөө "Яагаад би гэж?" хэмээн асуудаггүй. Энэ бүхэн учир шалтгаантай гэж би үргэлж боддог. Би Их Эзэнд итгэн, Түүний над руу илгээх зүйлсийг хүлээн авдаг. Туйлын хүнд хэцүү цаг үеийг даван гарахад Тэр надад тусалж, хүчирхэгжүүлсэн.

ИЛҮҮ ИХИЙГ ОЛЖ МЭД

Асран халамжлагчийн хувьд танд тусламж хэрэгтэй юу? **lds.org/go/12186** руу орно уу.

Ахмад настай хайрт хүмүүсээ асран халамжлах талаар илүү ихийг **lds.org/go/12187** вэбсайтаас сурч мэднэ үү.

Итгэлийн өөр хөргийг **lds.org/go/18** вэбсайтаас үзнэ үү.

Тохинууллын зарчмууд:

САНАА ТАВЬДАГ БОЛОХОО ОЙЛГУУЛ

Санаа тавьдаг болохоо харуулах, ялангуяа үүнийг Христийн мэндэлсний баярын үеэр харуулах олон арга зам бидэнд бий. Бид үүнийг хэлэх, мессеж илгээх, бичих, өгөх, хуваалцах, залбирах, жигнэх, дуулах, тэврэх, тоглох, тарьж ургуулах эсвэл цэвэрлэх зэргээр хийж болно. Зүгээр л оролдоод үз.

Бусдад хайраа үзүүлэх нь тохинууллын хамгийн чухал хэсэг юм. Халамжийн нийгэмлэгийн ерөнхий ерөнхийлөгч Жийн Б.Бингам: “Учир шалтгаан нь хайр байснаар л жинхэнэ тохинуулал нэг нэгээрээ гүйцэлддэг. . . . Хайр байснаар л гайхамшгууд тохиолдох ба бид “сүмдээ ирэхээ больсон” эгч, ах нараа буцаан авчрах арга замуудыг олоход үүний учир шалтгаан оршино. Ингэснээр тэд Есүс Христийн сайн мэдээний бүхий л адислалыг хүлээн авах болно”[1] гэж хэлсэн.

Санаа тавьж байгаагаа бусдад мэдэгдэх нь хувийн харилцаа холбоог хөгжүүлэхийн салшгүй хэсэг юм. Гэвч хүн бүр үүнийг өөр өөр арга замаар мэдэрдэг. Тэгэхээр бид бусдыг хайрлах хайраа ойлгомжтой, баярлаж талархахуйц арга замаар хэрхэн тэдэнд зүй зохистой илэрхийлж болох вэ? Санаа тавьдаг болохоо ойлгуулах зарим аргыг өөрөө бодож олоход тань туслах цөөн хэдэн санааг доор дурдав.

“Тохинууллын зарчмууд” сэдэвтэй нийтлэлүүд нь бидэнд айлчлан очихдоо захиас болгон хуваалцахад биш, харин нэг нэгнээ хэрхэн халамжилж сурахад туслах зорилготой. Үйлчилж байгаа хүмүүсээ таньж мэдэх үед тэдэнд халамж энэрлээс гадна ямар захиас хэрэгтэй байгааг Ариун Сүнс бидэнд шивнэн хэлэх болно.

Санаа тавьдгаа хэл

Заримдаа хэн нэгний талаарх мэдрэмжээ хэлэхээс өөр сайхан арга байдаггүй. Тухайлбал, хэн нэгэнд хайртай гэдгээ хэлэхээс гадна тэдний юу нь танд таалагддагийг хуваалцах эсвэл чин сэтгэлээсээ магтах зэрэг нь энд багтдаг. Энэ төрлийн урмын үгс харилцаа холбоог бэхжүүлэхэд тусална. (Ефес 4:29-ийг үзнэ үү.)

- Тухайн хүнд түүний нэг сайн зан чанарыг ямар их биширдэг болохоо мэдэгдэх боломжийг хайж ол.
- Тухайн хүний талаар юу гэж боддогоо зочлон очих, утсаар ярих, э-мэйл, мессеж, ил захидал илгээх зэргээр илэрхийл.



Очиж уулз

Хэн нэгэнтэй ярилцах, сонсоход цаг гаргах нь тухайн хүнийг та хэр их үнэлдгээ харуулах хүчирхэг арга зам юм. Гэрт нь болон сүмд эсвэл өөр газарт гээд хаана уулзахаас үл хамааран ярилцах хүн хэрэгтэй байгаа олон хүн байдаг. (Мозая 4:26; С ба Г 20:47-г үзнэ үү.)

- Тухайн хүний хэрэгцээнд тааруулан, очиж уулзах хуваарь гарга. Түүний нөхцөл байдлыг чин сэтгэлээсээ сонсож, ойлгоход цаг зарцуул.
- Газрын хол ойр, соёлын хэм хэмжээ эсвэл бусад нөхцөлөөс үүдэн гэрт нь очиж уулзахад хүндрэлтэй бол Сүмийн цуглааны дараа уулзах цаг гаргахыг бод.

Зорилготой үйлчил

Тухайн хувь хүн, гэр бүлд юу хэрэгтэй байгаад анхаар. Утга учиртай үйлчлэл үзүүлэх нь санаа тавьдаг болохыг тань харуулдаг. Энд цаг хугацаа болон сайтар бодож гаргасан хүчин чармайлтын үнэт бэлгүүдийг нэгтгэсэн байдаг юм. "Үйлчлэлийн энгийн үйлдлүүд бусдад хүчирхгээр нөлөөлж чадна" хэмээн Бингам эгч хэлсэн.[2]

- Хувь хүн эсвэл тэдний гэр бүлийг хүчирхэгжүүлэх үйлчлэлийг санал болго. Жишээ нь, хүүхдүүдийг нь харж өгснөөр эцэг эхэд нь ариун сүм рүү явах боломж олгох гэх мэт.
- Амьдрал хэт их ачаалалтай болох үед цонхыг нь угаах, нохойг нь салхилуулах, гадна талбайн ажилд нь туслах гэх мэт ачааг нь хөнгөлөх арга замыг эрж хай.

Бусдыг сонсох нь тэдэнд санаа тавьдаг болохоо харуулах арга замуудыг олж мэдэхэд бидэнд тусална. 2018 оны 6-р сарын *Лиахона* сэтгүүл дээрх "Сайн сонсогчдын хийдэг таван зүйл" гэсэн тохинууллын зарчмуудын нийтлэлийг үзнэ үү.

Аливааг хамт хий

Гүнзгий сэдвээр ярилцах замаар харилцаа холбоо тогтоодоггүй хүмүүс байдаг. Зарим хүний хувьд ижил төстэй сонирхолтойгоо мэдэж авч, уг зүйлээ хийхэд цагийг хамтдаа өнгөрүүлэх замаар харилцаа холбоо тогтоодог. Их Эзэн бидэнд ах, эгч нартайгаа "хамт байж мөн бэхжүүлэх" (С ба Г 20:53) хэрэгтэйг уриалсан.

- Алхах, тоглоомын үдшийг төлөвлөх эсвэл хамт дасгал хийх тогтсон цаг гарга.
- Орон нутгийн юм уу Сүмийн төсөл дээр хамтдаа үйлчил.

Бэлэг өг

Заримдаа бусадтай харилцах цаг эсвэл боломж хязгаарлагдмал байдаг. Олон оронд бэлэг өгөхийг санаа тавьж байгаа, бусдыг ойлгож байгаагийн илэрхийлэл гэж үздэг. Тэр ч бүү хэл, гэнэтийн, энгийн бэлэг ч гэсэн илүү сайн харилцаа тогтоох гэсэн таны сонирхлыг харуулдаг. (Сургаалт үгс 21:14-ийг үзнэ үү.)

- Тэдэнд дуртай амттанг нь авчирч өг.
- Тэдэнд тус болно гэж бодсон эшлэл, судар эсвэл өөр захиасыг хуваалц.

Хайрын хөдөлмөр

Та өөрийн тохинуулдаг эсвэл сүнслэг өдөөлт эрэлхийлж буй хүмүүсээ сайн таньж мэддэг болсноор тэдний хүн нэг бүрийг хайрлаж, санаа тавьдаг болохоо хэрхэн ойлгуулахаа илүү тодорхой мэддэг болно.

АНУ-ын Орегон мужийн Кимбэрли Сэйболд сүнслэг өдөөлт эрэлхийлж, хайраа үзүүлэхийн тулд бэлэг өгөх талаар нэгэн түүх хуваалцсан.

"Сэтгэлээр унах зүйл амьдралд тохиолдоход би босож, хулууны талх хийдэг. Ихэнхдээ найман ширхэг талх барьдаг. Талх барьж байхдаа хэнд талх хэрэгтэйг мэдэхээр дотроо залбирдаг ба энэ нь миний онцгой орц юм. Хулууны халуун талх минь эргэн тойрныхоо хөршүүдийн гэр орон болон амьдралд орох миний урилга болсноор би тэднийг илүү сайн мэддэг болсон.

Зуны нэгэн дулаахан өдөр би замын хажуу талд жижиг савтай бөөрөлзгөнө зарж буй гэр бүлийг хараад, дэргэд нь очиж машинаа зогсоов. Надад бөөрөлзгөнө хэрэггүй байсан ч лангууны ард байсан бага насны туранхай хүү намайг хараад, дараагийн үйлчлүүлэгчээ гэж бодон баярлав. Би жоохон бөөрөлзгөнө худалдан авсан ч надад бас түүнд өгөх бэлэг байлаа. Би тэр хүүд хоёр талх өгөв. Тэр аав руугаа зөвшөөрөл авахаар хараад, 'Аав аа хар даа. Бид өнөөдөр идэх юмтай боллоо' гэж хэлэв. Энгийн аргаар хайраа үзүүлэх энэ боломжиндоо би ихэд талархаж билээ."

Арван хоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Жэффри Р.Холланд "Эрэгтэй, эмэгтэй хүн бүр мөн манай залуу эрэгтэй, эмэгтэйчүүдийн томууд нь . . . нэг нэгнээ халамжлахаар чин сэтгэлээсээ баттай шийдэж, Христийн цэвэр хайраар ийн үйлдэх урам аваасай хэмээн бид залбирч байна. . . . Бид Бурхан Эцэгтээ залбиралд хариулах, тайтгаруулах, нулимс хатаах, тамирдсан өвдөгнүүдийг хүчирхэгжүүлэх агуу том даалгавраа гүйцэтгэхэд нь тусламжийн гараа сунган, усан үзмийн талбайн Их Эзэнтэй мөр зэрэгцэн хөдөлмөрлөх болтугай"[3] хэмээн гуйсан.

Есүс Христ санаа тавьдаг

Есүс Христ Лазарыг үхэгсдээс босгохынхоо өмнө, "Есүс уйлав.

Тэгтэл иудейчүүд—Тэр түүнд ямар хайртай байсныг хараач гэцгээж байлаа" (Иохан 11:35–36).

"Та нарыг өрөвдөх сэтгэл надад байна" гэж Христ нифайчуудад хэлээд, өвдсөн, зовсон, доголон, хараагүй хүмүүсийг дуудаж авчран, "тэднийг эдгээсэн" (3 Нифай 17:7–9-ийг үзнэ үү).

Аврагч бусдад санаа тавьснаар бидэнд үлгэр жишээ үзүүлсэн. Тэр бидэнд:

"Чи бүх зүрх, бүх сэтгэл, бүх оюунаараа өөрийн Бурхан Эзэнээ хайрла.

Энэ бол агуу нь бөгөөд хамгийн чухал тушаал мөн.

Удаах нь Чи хөршөө өөрийн адил хайрла гэсэнтэй адил юм" (Матай 22:37–39) хэмээн заажээ.

Таны анхаарал халамж хэнд хэрэгтэй байна вэ?
Та санаа тавьдгаа тэдэнд хэрхэн харуулж болох вэ? ■

ЭШЛЭЛҮҮД

1. Жийн Б.Бингам, "Аврагчийн адил тохинуулах нь," *2018 оны 4-р сарын Ерөнхий чуулган,* 132.
2. Жийн Б.Бингам, "Аврагчийн адил тохинуулах нь," 130.
3. Жэффри Р.Холланд, "Тэдэнтэй хамт байж мөн бэхжүүл," *2018 оны 4-р сарын Ерөнхий чуулган,* 128.



Халамжийн нийгэмлэгийн ерөнхий ерөнхийлөгч
Жийн Б.Бингам

Гэрийн болон айлчлагч багш нар маань хаана байгаа юм бол?

Тохинууллын ажлын уян хатан байдал биднийг санаа амарч тайвшрахын оронд илүү их халамж анхаарал үзүүлэхэд урамшуулах ёстой.

Саяхан нэг найз маань гайхсан байдалтайгаар надаас "Айлчлагч багш нар маань хаана байгаа юм бол?" гэж асуусан. Нөхрийг нь нас барсан цагаас эхлэн тэд маш их санаа тавьж, анхаардаг байсан боловч 2018 оны 4-р сарын Ерөнхий чуулган дээр шинэ тохинууллын хөтөлбөрийг зарласнаас хойш тэр тэднийг огт хараагүй ажээ.

Бид бүгдээрээ шинэ арга замд дасахыг хичээж байгаа бөгөөд гэрээр зочлох нь тохинуулах цорын ганц арга биш ч энэ нь хайр, чин сэтгэлээсээ анхаарал тавьж байгаагаа харуулах гайхалтай арга зам бөгөөд олон гишүүнд энэ нь хэрэгтэй хэвээр байгааг зарим тохинуулагч ах, эгч ойлгоогүй бололтой.

Яагаад гэдгийг *хэрхэн* гэсэн асуултаас илүү чухалчлан үзэх

Зарим хүн энэхүү өөрчлөлтийн зорилгыг буруу ойлгосон нь асуудал болж байж болох юм. Гэрийн болон айлчлагч багш нарыг тохинууллаар сольсны зорилго нь зөвхөн нэг нэгнээ *хэрхэн* харж халамжилдаг аргаа өөрчилсөн хэрэг биш, харин *яагаад* гэсэн асуултад илүү удирдагдахад бидэнд туслахад оршино.

Тохинууллын эцсийн зорилго бол Аврагч Есүс Христэд илүү гүн гүнзгий хөрвөгдөж, бурханлаг чадавхдаа хүрэхийн төлөө өсөж хөгжихөд нь бусдад туслах явдал юм. Энэ хөтөлбөрийн илүү уян хатан байдал нь хүчин чармайлтаа сулруулахад биш, харин хүчин чармайлтаа Сүнсээр удирдуулах илүү агуу боломжийг бидэнд олгох зорилготой.

Тиймээс өнөөдөр хэн нэгнийд очих хэрэгтэй эсэх нь Тэнгэрлэг Эцэгийн тэдэнд зориулсан зам дээр урагшлахад туслах уу үгүй юу гэдэг илүү том хэсэгт ихэвчлэн тулгуурласан байх ёстой.

Хамтдаа суралцах

Хэдийгээр бидний тохинууллаас хүсэн хүлээж байгаа зүйл эхэндээ тодорхой бус байгаа ч ах, эгч нар маань нэг нэгэндээ хүрч үйлчилж байна. Миний аялсан газар бүрд тоолж баршгүй олон эмэгтэй (бас олон эрэгтэй) өөрсдийнх нь тохинуулсан ажил эсвэл өөрсдөд нь тохинуулсан ажил харилцаа холбоо, хувийн өсөлт хөгжилд нь эерэг нөлөө үзүүлсэн тухай түүхээ хуваалцахыг сонсоход ихээхэн таатай байсан.

Би саяхан АНУ-ын Хойд Каролина мужид очоод ирсэн бөгөөд тэндхийн нэгэн тойргийн Халамжийн нийгэмлэгийн ерөнхийлөгч гадасны удирдагчдаасаа хүлээн авсан зарим санаагаа хуваалцсан юм. Бага хэмжээний тодруулга хийснээр, тэдгээр санаа оновчтой болсон бөгөөд хуваалцах нь зүйтэй гэж надад бодогдсон.

“ИЛҮҮ ШИНЭ, ИЛҮҮ АРИУН НАНДИН ХАНДЛАГА”

Доорх хүснэгтэд хуучин хөтөлбөрийг зарим гишүүн хэрхэн хардаг байсныг мөн тохинуулах гэдэг нь ямар утгатай болохыг бүгд ийнхүү ойлгодог болно гэсэн бидний хүсэлтэй харьцуулан харуулав.

ХУУЧИН	ШИНЭ
Гэрийн ба айлчлагч багшлалт	Тохинуулал
Үүргээр өдөөгдсөн	Хайраар өдөөгдсөн
Хайрцаг*	Сувд
Би *юу* хийх вэ?	Би *яагаад* үүнийг хийх вэ?
Үйл явц	Үр дүн
ХИЙСЭН ГЭЖ ТЭМДЭГЛЭХ	ҮРГЭЛЖЛҮҮЛЭН ХОЛБОГДОХ
Даалгавартаа анхаарал төвлөрүүлэх	Хүндээ анхаарал төвлөрүүлэх
Сард нэг удаа айлчлах	Энгийн, уян хатан байдлаар холбогдох
Тогтсон захиасыг хүргэх	Сүнсээр хөтлөгдөн сайн мэдээнээс хуваалцах
Юуг айлчлал гэж үзэх	Сүнслэг байдлыг нь хариуцах
Ах, эгч нарыг хариуцахаар томилогдох	Ах, эгч нарыг хариуцаж авах
Хийснээ тайлагнах	Зүрх сэтгэлийг өөрчлөх

* Нэгэн үнэт эдлэлийн дархан асар үнэт сувдтай байсан бөгөөд хүмүүс сувдыг нь биш, харин сувдыг байрлуулсан үзэсгэлэнт хайрцагт анхаарлаа илүү хандуулсанд харамссан тухай сургаалт зүйрлэл. Үүнтэй адил, бид гэрийн ба айлчлагч багшлалтаас тохинуулал руу шилжихдээ дүрэм журам, үйл явцын “хайрцгаас” илүү утга учиртай тохинууллын “сувданд” анхаарлаа хандуулах нь зүйтэй.

ТОХИНУУЛЛЫН ЯРИЛЦЛАГУУДЫГ ХЭРХЭН АМЖИЛТТАЙ ХИЙХ

Энэхүү өгүүллийн цахим хувилбар дээр Бингам эгч тохинууллын ярилцлагуудыг хийхэд тус болох таван зааварчилгааг өгөв. **lds.org/go/121813** руу орж үзнэ үү.

Үргэлжлүүлэн хий

Бид бүгдээрээ “илүү шинэ, илүү ариун нандин” байдлаар тохинуулах хандлагыг хүлээн авч, хамтдаа суралцаж байна.[1] Магадгүй зарим нь цочирдож эсвэл айж байж болох юм. “Илүү шинэ мөн илүү ариун нандин” гэдэг нь “алдаа дутагдалгүй мөн биелүүлэхийн аргагүй” гэсэн үг биш гэдгийг санах нь зүйтэй.

Тохинууллын зорилгын талаар юм уу энэ нь хэрхэн явагддагийг сайн мэддэг эсэхээс тань үл хамааран би таныг **ministering.lds.org** дээрх эх сурвалжуудыг үзэж, уншин, *Лиахона* сэтгүүл дээр сар бүр гарсан тохинууллын зарчмын тухай нийтлэлүүдийг (энэ дугаарын 8-р хуудсыг үзнэ үү) судлахад урьж байна. Эдгээр материал нь Аврагчийн ажилтай өөрсдийн тохинууллын хүчин чармайлтыг нийцүүлэхэд тусална.

Гайхамшигтай ах, эгч нар аа, хайрлаж, халамжилж, тусламжийн гараа сунгаж, өөрсдийгөө зориулж байгаад тань баярлалаа. Та нар үнэхээр гайхалтай бөгөөд та нарын тохинуулал “ер бусын зүйл” байх болно![2] ■

ЭШЛЭЛҮҮД

1. Рассэлл М.Нэлсон, “Тохинуулах нь,” 2018 оны 4-р сарын Ерөнхий чуулган, 125.
2. Emma Smith, in *Daughters in My Kingdom: The History and Work of Relief Society* (2011), 14.

Далын ерөн-
хийлөгчийн
зөвлөлийн
**Ахлагч Л.Витни
Клэйтон**

АВРАГЧИЙН АМАР АМГАЛАНГИЙН БЭЛЭГ

Бидний нөхцөл байдлаас үл хамааран амар амгалан байх аргагүй мэт дэлхийд хүртэл Аврагчийн амар амгалангийн бэлэг зүрх сэтгэлд маань оршиж чадна.

Христийн мэндэлсний баярын уянгалаг сайхан хөгжим хийгээд магтуунууд, гэр бүл болон найз нөхдийн Христийн мэндэлсний баярын цугларалт, инээмсэглэсэн царай, хүүхдүүдийн баяр хөөрөөс илүү сайхан зүйл байдаг гэж үү? Христийн мэндэлсний баяр биднийг гэр бүл, найз нөхөдтэйгөө болон нийтээр нь цуглуулах бурханлаг хүчтэй. Бид бэлэг солилцож, баяр ёслолын зоогоо таалан идэхийг тэсэн ядан хүлээдэг.

Английн зохиолч Чарльз Диккенсийн бичсэн *Зул сарын магтуу* зохиолд Эбинэзэр Скрүүжийн үеэл жилийн энэ нандин цаг үеийн ид шидэд сэтгэл татагддаг. Тэрээр "Би Христийн мэндэлсний баяр болоход . . . үүнийг үргэлж хамгийн сайхан цаг үе, нинжин сэтгэлтэй, өршөөнгүй, өгөөмөр байх цаг мөч гэж боддог бөгөөд энэ нь бүтэн жилийн туршид эрэгтэй, эмэгтэй хүмүүс сэтгэл нэгдэж, зүрх сэтгэлээ бусдад чөлөөтэй нээж, [бусад] хүмүүсийн талаар боддог цорын ганц үе юм. Хэдийгээр би халаасандаа алт, мөнгөний үртэс ч хийж үзээгүй ч энэ нь надад сайныг *хийсэн* мөн сайныг хийх *болно* гэдэгт итгэдэг. Тиймээс Бурхан адислаг!"[1] хэмээн хэлдэг.

Би эцэг эхийн хувьд мөн одоо өвөө эмээгийн хувьд хүүхдүүдээ төдийгүй тэдний хүүхдүүдийг хэрхэн Аврагчийн төрөлтийг тэмдэглэж, гэр бүлээрээ цугласан үедээ бие биетэйгээ цагийг хөгжилтэй сайхан өнгөрүүлж байгааг харахдаа, энэ нь надад Христийн мэндэлсний баярын ид шидийг сануулдаг. Та ч бас миний адил энэ онцгой баярыг хүүхдүүд хэрхэн баяр хөөр, цагаан цайлган сэтгэлээр тэсэн ядан хүлээж, таашаал авч байгааг анзаарсан гэдэгт би итгэлтэй байна. Тэдний баяр баясгалан бидний хүн нэг бүрд улирч одсон Христийн мэндэлсний баярын баяр баясгалантай цаг үеийг санагдуулдаг. "Заримдаа хүүхэдтэй адил байх сайхан байдаг. Харин агуу Үндэслэгч Өөрөө хүүхэд байсныг тэмдэглэдэг Христийн мэндэлсний баяр бол хүүхэд адил байх хамгийн тохиромжтой цаг үе юм"[2] гэдгийг ч бас Диккенс олж харсан юм.

Би АНУ-ын Калифорни мужийн Лос Анжелос хотын ойролцоо жүржийн ойгоор хүрээлэгдсэн гэрт өссөн. Христийн мэндэлсний баяр болгоны нэгэн үдэш эцэг эх маань гэр бүлийнхэн, найз нөхөд болон хөршүүдээ Христийн мэндэлсний баярын магтууг дуулан, зууш идэж, хөгжилдөн өнгөрүүлэхээр гэртээ урьдаг байлаа. Энэ нь бидний хувьд гайхалтай сайхан уламжлал байсан бөгөөд зогсолтгүй үргэлжлүүлэн дуулсаар байгаа мэт санагддаг байв. Хүүхдүүд бид дуулах ёстой гэж бодсон хэсгээ дуулчихаад, жүржийн төгөл рүү орж тоглохоор сэмхэн явдаг байлаа.

Мөн би эхнэр Катитайгаа хамт гэр бүлээ далайн эрэгтэй харьцангуй ойрхон байдаг Өмнөд Калифорнид өсгөсөн.

ХРИСТИЙН МЭНДЭЛСНИЙ БАЯРЫН ӨӨРЧЛӨН ШИНЭЧЛЭГЧ СҮНС БИДНИЙ АМЬДРАЛЫГ САЙЖРУУЛАН ӨӨРЧЛӨХ ЕСҮС ХРИСТИЙН ГЭТЭЛГЭГЧ ХҮЧИН ДЭЭР СУУРИЛДАГ ЮМ.

Энд Христийн мэндэлсний баярыг салхинд найгаж буй дал модоор онцолж болно. Жил бүр хүүхдүүд маань доошоо боомт руу явж, Христийн мэндэлсний баярын завины жагсаалыг үзэхийг хүсэн хүлээдэг байв. Олон зуун үзэсгэлэнтэй дарвуулт онгоцнууд, бүхий л өнгийн гэрлэн цацраг боомтыг тойрон хөвөхийг харах үнэхээр гайхалтай.

Одоо бид АНУ-ын Юта мужийн Солт Лэйк Ситид амьдардаг бөгөөд эхнэр бид хоёр хүүхдүүд болон ач хүүхдүүдээ аван *Зул сарын магтуу* орон нутгийн тоглолтыг үзэх уламжлалтай болсон. Скрүүж хатуу сэтгэлтэй зожиг хүн байснаа Христийн мэндэлсний баярын баяр хөөрөөр дүүрэн аз жаргалтай хөрш болж гайхамшигтайгаар өөрчлөгдөхийг бид жил бүр харснаар өөрсдийн доторх Скрүүжийг тавьж явуул гэхийг мэдэрдэг. Бид Аврагчийн энэрлийн үлгэр жишээг илүү сайн дага гэсэн сүнслэг өдөөлтийг мөн мэдэрдэг.

Есүс Христийн Гэтэлгэгч хүч

Христийн мэндэлсний баярын өдрүүдийн өөрчлөн шинэчлэгч сүнс бидний амьдралыг сайжруулан өөрчлөх Есүс Христийн гэтэлгэгч хүчин дээр суурилдаг юм. Бетлехемд 2000 жилийн тэртээ Бурханы Хүү төрсөн тухай бидний дуртай түүх Лукийн номон дээр ийнхүү цэдэглэгдсэн байдаг.

"Тэр өдрүүдэд газар бүрд хүн амын тооллого явуулах тухай Цезарь Августын зарлиг гарчээ. . . .

Тооллогод бүртгүүлэхээр бүгд өөр өөрийн төрөлх хот уруу явцгаав.

Иосеф Давидын удмын хүн байсан тул бас Галилын Назар хотоос Иудейг зорин Бетлехем гэгддэг Давидын хот уруу

хүүхэдтэй болсон сүйт бүсгүй Мариагийнхаа хамт бүртгүүлэхээр явав.

Тэднийг тэнд байх үед Мариагийн нярайлах өдөр нь болж,

Тэр ууган хүүгээ төрүүлж, Түүнийг даавуунд ороож, тэжээлийн тэвшин дотор тавив. Учир нь дэн буудалд тэднийг хоноглуулах өрөө байсангүй.

Тэр газар хэдэн хоньчид сүргээ манаад шөнө хээр хоноглож байжээ.

Гэнэт Эзэний тэнгэр элч тэдний өмнө зогсож, Эзэний цог жавхлан тэдний эргэн тойронд гийсэнд хоньчид үлэмжийн айдаст автжээ.

Тэнгэр элч тэдэнд—Бүү айгтун, харагтун, би бүх ард түмнийг үлэмж баярлуулах сайн мэдээг та нарт авчирлаа.

Өнөөдөр Давидын хотод Аврагч, Эзэн Христ та нарын төлөө мэндэллээ.

Тэжээлийн тэвшинд байх даавуунд өлгийдсөн нялх хүүхдийг та нар олж харна. Энэ нь та нарт тэмдэг болно гэлээ.

Гэнэт өнөөх тэнгэр элчийн хамт олон тооны тэнгэрлэг дайчид үзэгдэж, Бурханыг магтан,—

Дээр өндөрт алдар нь Бурханд байх болтугай, доор газарт амар тайван нь Түүний тааллыг олсон хүмүүст байх болтугай гэцгээв" (Лук 2:1, 3–14).

Бүү ай

Тэнгэр элч хоньчдод үзэгдэхдээ айдсыг нь мэдрээд, тэдэнд "бүү ай" гэж хэлсэн. Гэнэт

ХОНЬЧИД, КӨРК РИЧАРДСЫН ХИЛИЙН ЧАНАДАД ТАНИГДСАН БҮТЭЭЛ

ирсэн тэнгэрийн элчээс цацрах Бурханы гайхам алдар суу тэдний зүрх сэтгэлд үнэхээр айдас төрүүлжээ. Харин тэнгэр элчийн хуваалцах гэж ирсэн мэдээ аймшигтай байсангүй. Тэр гайхамшгийг зарлаж, туйлын сайн мэдээг авчирч, хүн төрөлхтний гэтэлгэл улиран тохиолдсоныг тунхаглахаар ирсэн билээ. Өөр ямар ч элч үүнээс өмнө нь ч, үүнээс хожим нь ч ийм аз жаргалын мэндчилгээг авчирч байсангүй.

Эцэгийн Заяасан Ганц мөнх бус оршихуйд хийх Өөрийн аяллыг эхлүүлж байв. "Өнөөдөр Давидын хотод Аврагч, Эзэн Христ та нарын төлөө мэндэллээ." Эдгээр нь үнэхээр үлэмж баярлуулах сайн мэдээ байсан.

Тэнгэр элчийн амласан агуу баяр баясгалан бодит бус, хол мэт санагдах үе бидний хүн нэг бүрийн амьдралд тохиолдож байсан. Бид бүгдээрээ өвчин зовлон, бүтэлгүйтэл, бэрхшээл, урам хугаралт, эцэст нь үхэл зэрэг амьдралын сул тал болон зовлон бэрхшээлд өртдөг. Өнөөдөр олон хүн биеийн хувьд аюулгүй орчинд амьдрах боломжоор адислагдсан байхад заримд нь ийм боломж байдаггүй. Олон хүн амьдралынхаа хэрэгцээг хангаж чаддаггүй бөгөөд эдгээр хэрэгцээ шаардлага нь тэднийг биеийн болон сэтгэл санааны дарамтад оруулдаг.

Гэхдээ амьдралын зовлон бэрхшээлийг үл харгалзан, 2000 жилийн тэртээ хоньчдод өгсөн "Бүү ай" гэх Их Эзэний захиас өнөөдөр ч бидний хүн нэг бүрийн хувьд хэвээр. Христийн мэндэлсний баярын анхны шөнө хоньчдын айдсыг дарж, тайвшруулах гэж хэлсэн тэнгэр элчийн үгс өнөөгийн бидэнд илүү ач холбогдолтой байж болох юм. Тэр бас Аврагч байгаа учраас айдас хэзээ ч ялан дийлэхгүй гэдгийг бидэнд ойлгуулахын тулд хэлсэн байж болох уу? Уг айдас хэзээ ч зөвтгөгдөхгүй, дэлхийн ямар ч асуудал үүрд байх шаардлагагүй, мөн бидний дунд гэтэлгэгдэхгүй хүн гэж байхгүй гэсэн бодит үнэнийг бататгах гэсэн юм болов уу?

Христийн мэндэлсний баярын хамгийн тансаг бэлэг бол үргэлж Аврагчийн Өөрийн биеэр өгсөн "Түүний төгс амар амгалан" байх болно. Тэрээр: "Амар амгаланг Би та нарт үлдээнэ. Би Өөрийн амар амгалангаа та нарт өгнө. Ертөнцийн өгдгөөс өөр юмыг Би та нарт өгч байна. Та нар зүрхээ бүү зовоо. Бүү ай" (Иохан 14:27) хэмээн хэлсэн.

Бидний нөхцөл байдлаас үл хамааран амар амгалан байхын аргагүй дэлхийд хүртэл Аврагчийн амар амгалангийн бэлэг зүрх сэтгэлд маань оршиж чадна. Хэрэв бид Аврагчийн Өөрийг нь дага гэсэн урилгыг хүлээн авбал айдас тань үүрд алга болно. Бид ирээдүйдээ санаа зовох хэрэггүй. Эдгээр нь "бүх ард түмнийг үлэмж баярлуулах сайн мэдээ" юм.

"Би чамтай хамт байгаа тул бүү ай! Өөрийнхөө талаар бүү санаа зов. Учир нь Би чиний Бурхан. Би чамайг тэнхрүүлж, үнэхээр чамд тусална. Би заавал Өөрийн зөв баруун мутраар чамайг хамгаална" (Исаиа 41:10) хэмээн бошиглогч Исаиа бидэнд сануулсан.

Аврагчид найдах нь

Аврагч 2000 жилийн өмнө Бетлехемд төрсөн учир итгэл найдвар төдийгүй үүнээс ч олон зүйл боломжтой болсон билээ. Гэтэлгэл, чөлөөлөлт, ялалт мөн ялалтын баяр хөөр бий. "Буруутангууд унаж, зөвтөнгүүд давамгайлна."[3]

Тэнгэр элч Аврагчийн төрснийг зарласны дараа тэнгэр элчүүд гэнэт гарч ирэн, "Дээр өндөрт алдар нь Бурханд байх болтугай, доор газарт амар тайван нь Түүний тааллыг олсон хүмүүст байх болтугай гэцгээв" хэмээн хоршин дуу алдсанд гайхах хэрэггүй биз ээ. Үүнээс илүү урам өгсөн захиас байхгүй л болов уу. Өөр ямар ч захиас хүмүүнийг илүү сайнаар ингэтлээ дүүргэхгүй.

"Өнөөдөр Давидын хотод Аврагч, Эзэн Христ [бидний] төлөө мэндэл[сэн]" тул энэ баярын өдрүүд амар амгалан болон баяр хөөрөөр дүүрэн байх болтугай. ■

2015 оны 12-р сарын 6-ны өдөр Чуулганы төвд болсон Тэргүүн Зөвлөлийн Христийн мэндэлсний баярын онцгой цугларалт дээр хэлсэн "Бүү ай" үгнээс авав.

ЭШЛЭЛҮҮД

1. Чарльз Диккенс, *Зул сарын магтуу* (1858), 5–6.
2. *Зул сарын магтуу,* 67.
3. "I Heard the Bells on Christmas Day," *Hymns,* no. 214.

Өчигдрийнхөөс арай илүү бай

Луис Омар Кардозо

Номлолынх нь ерөнхийлөгчийг залгахад Сэржио номлолдоо яваад бараг нэг жил болсон байв. Тэр бидний цорын ганц хүү байсан бөгөөд бүрэн цагийн номлолд үйлчилсэн анхны хүүхэд маань байлаа. Миний эхнэр Лилиана бид хоёр хүүгээрээ мөн эгч дүү хоёртоо үзүүлсэн үлгэр жишээгээр нь бахархдаг байв.

Сэржио байгаа байдлаараа сайн номлогч болно гэдгээ бидэнд харуулдаг байсан юм. Тэр төрөлхийн удирдагч байсан ба аз жаргалтай, чин сэтгэлээсээ ханддаг, бусдыг урамшуулж чаддаг хүү байв.

Түүнд тухайн хүн Сүмийн гишүүн байх эсэх нь огт хамаагүй байсан бөгөөд тэр бүгдтэй нь найзалдаг байлаа. Хэрэв хэн нэг нь түүнийг хожмын үеийн гэгээнтэн гэдгээр нь доогловол тэр үүнийг шог хошин зүйл мэт хүлээн авч, барагтай бол гомддоггүй байв.

Сэржиог Перугийн Чиклаяа номлолд үйлчлэх дуудлагаа хүлээн авахад бид ямар их баярласан гээч. Тэр 2013 оны 11-р сарын 20-оос эхлэн номлолд үйлчилсэн. Тэр номлолдоо хайртай байлаа. Эхлээд түүнд захиа бичихэд амар байв. Гэвч цаг хугацаа өнгөрөх тусам, түүний явуулсан захианууудыг сайтар бодох, сүнслэг өсөлтөд нь тохируулан хариулах зэрэгт илүү их цаг гаргах хэрэгтэй болов.

Бид Сэржиодоо огт санаа зовдоггүй байлаа. Бид номлолын талбар бол түүний байж болох хамгийн аюулгүй газар гэж бодож байв. Түүний номлолын ерөнхийлөгч 2014 оны 10-р сарын 7-ны өдөр бидэнтэй утсаар ярьсан юм.

Бид хэзээ ч ганцаардаж байгаагүй

Номлолын ерөнхийлөгч бидэнд Сэржиог хамтрагчтайгаа хамт сонирхогчдодоо ариун сүм болон мөнхийн гэр бүлийн тухай зааж байсныг хэлэв. Дараа нь Сэржио хаалтын залбирал хийхдээ түр зогсоод, гэнэт ухаан алдан газар унасан гэж хэллээ. Түүнд адислал хүртээж, эмнэлэг рүү яаралтай хүргэсэн байна. Эмч нар түүний тархины судас цулхэнтэй байж байгаад хагарсан болохыг тогтоожээ. Тэд түүнийг сэргээх гэж хичээсэн ч чадсангүй.

Энэ мэдээ бидэнд уй гашуу авчрав. Лилиана бид хоёр эмгэнэн гашуудахаас гадна Перу руу явж Сэржиогийнхоо шарил, хувийн эд зүйлсийг авчрах

ЗУРАГ ЧИМЭГЛЭЛИЙГ СЮЗАНЬ СИММОНС

Сэржиогийн эгч Зимэна түүний нас барсан талаарх өөрийн бодлыг **lds.org/go/121819** дээр хуваалцсан.

хэрэгтэй болов. Бидэнд бүхнийг тодорхой бодоход хэцүү байсан тул биднийг гэрээсээ явсан цагаас эхлэн эргэж ирэх хүртэл Сүмээс бидэнд туслах хүн байсанд бид талархдаг. Бид бас биднийг тайвшруулж мөн уй гашуугаа даван гарахад тусалдаг Ариун Сүнсний тусламжийг хүлээн авч байлаа. Бид хэзээ ч ганцаардаж байгаагүй.

Эмгэнэлт явдлын үед талархахад хэцүү ч гэсэн, би Сэржиогийн үхэлтэй Их Эзэний эрхэм их нигүүлсэл холбогдсонд талархдаг. Түүнийг нас барахад би бишопоор, Лилиана семинарын багшаар, Зимэна охин маань тойргийн Залуу эмэгтэйчүүдийн ерөнхийлөгчөөр тус тус үйлчилж байлаа. Бид бусдад үйлчилж, тэднийг хайрлаж, завгүй байсан маань биднийг сайн мэдээнд хүчирхэгжүүлсэн юм. Хэрэв Сэржио биднийг орхих хэрэгтэй байсан юм бол биднийг итгэлдээ хүчтэй байх үед түүнийг авсанд би Тэнгэрлэг Эцэгт үргэлж талархах болно.

Би бас Сэржиог Их Эзэний үйлчлэлд мөн "бусдадаа үйлчилж" (Мозая 2:17) байхдаа энэ амьдралаас халин одсонд талархдаг. Их Эзэн "надад нас нөгчсөн тэд үхлийг үл амсана, учир нь энэ нь тэдэнд тааламжтай байх болно" (С ба Г 42:46) хэмээн тунхагласан.

Түүний Заяасан Ганц бидний төлөө үхэх үед Тэнгэрлэг Эцэгт юу мэдрэгдэж байсныг Ариун Сүнс надад цухас харуулсан. Бурханд уурлах ямар ч эрх надад байхгүй гэдгийг би ойлгож билээ. Тэнгэр дэх Эцэг минь надад ямар байгааг мэдэж байсан. Түүний хүслийг мөн Сэржио бага залуудаа нас барсан явдлыг хүлээн зөвшөөрөх боломжийг олгосон амар амгаланг би мэдэрсэн. Лилианад ч бас энэ бүхэн тохиолдож, үүнтэй адил мэдрэмжийг мэдэрсэн юм.

Тайтгаруулах үгс

Манай гэр бүл 2005 онд Сэржио, Зимэна хоёрыг жаахан байхад ариун сүмд лацдан холбуулсан. Рут үүнээс хойш удалгүй гэрээнд төрсөн юм. Сэржио номлолд явахаасаа өмнө түүнд баптисм хүртээсэн билээ.

Сэржиог нас барснаас хойш гурван хоногийн дараа Рут нэгэн зүүд зүүдэлсэн. Энэ түүний есөн насны төрсөн өдрийн шөнө байв. Рут зүүдэндээ түүнтэй гар гараасаа хөтлөлцөн, бүтэн өдрийн турш хамт алхаж мөн түүнийг тайтгаруулж байсан гэв.

> Бид сайн мэдээний дагуу үргэлжлүүлэн амьдрах ёстой. Тэгснээр Сэржио эргээд биднийх болж чадна.

Рут, Зимэна хоёр Сэржиотой маш дотно байсан бөгөөд түүнийг маш ихээр санаж байлаа. Рут зүүдээ санаж, одоо ч гэсэн тайтгарлыг олж авдаг.

Нэгэн өдөр Лилиана бид хоёр Сэржиогийн эд зүйлсийг үзэж байхдаа түүний номлолын өдрийн төлөвлөгөөг олсон юм. Өдөр бүр хуудас болгон дээрээ Сэржио "Өчигдрийнхөөс арай илүү бай" гэсэн үгийг бичсэн байхыг бид анзаарав.

Тэр үг миний сэтгэлд хоногшсон. Энэ нь надад сайн мэдээний дагуу үргэлжлүүлэн амьдрах ёстой болохыг сануулдаг. Тэгснээр бид энэ амьдралын дараа гэр бүлээрээ хамтдаа байх боломжтой. Тэгснээр Сэржио эргээд биднийх болж чадна.

Хүнд хэцүү цаг үед Аврагч биднийг дэмжих болно. Энэ нь үнэн гэдгийг би Түүний амлалтууд гарцаагүй биелнэ гэдгийг мэддэгийн адил мэддэг. Тиймээс бид сайн мэдээнээс зууран барьж, Сэржиогийн үлгэр жишээг дагах болно. Бид өдөр бүр арай илүү дээр байхыг хичээх болно. ■

Зохиогч нь Аргентины Салтад амьдардаг.

Амьдралаа хувийн өсөлт

ХӨГЖЛИЙН СЭТГЭЛ ХӨДӨЛГӨМ АЯЛАЛ БОЛГОХ НЬ

Арван хоёр Төлөөлөгчийн Чуулгын
Ахлагч Жэффри Р.Холланд

Бурханлаг чадавхдаа хүрэхийн тулд сайн мэдээнээс суралцаж, үүний дагуу амьдарч, заах ёстой.

Эрхлэгчийн тайлбар: *Лиахона* сэтгүүлд зориулан бичсэн энэ нийтлэлдээ ахлагч Холланд *Ирээд, Намайг дага* Сүмийн шинэ сургалтын материалын суурь болох хөрвөлтийн хүчирхэг зарчмуудыг хуваалцсан юм.

Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн гишүүн байна гэдэг ямар сайхан цаг үе вэ! Их Эзэний хаант улс дахь саяхнаас өрнөж буй өөрчлөлт шинчлэлтийн талаар бодоход, Бурхан биднийг арай өндөрт гарч харахгүй л бол өмнө байгаагаа ч олж харах боломжгүй тийм гайхалтай уул толгод, нуга хөндий, ойн төгөлөөр сэтгэл хөдөлгөм аялалд дагуулан явж байгаа нь илт байна.

Зөвхөн өнгөрсөн жил л гэхэд бид хайрт бошиглогчтойгоо салах ёс гүйцэтгэж, шинэ бошиглогчоо хайраар дэмжин баталсан. Бид Их Эзэний ажлыг гүйцэлдүүлэхийн тулд Халамжийн нийгэмлэг болон Мелкизедик санваарын чуулгын цуглаануудад хамтдаа зөвлөлдөхөд илүү онцгой анхаарах шинэ арга замыг ашиглах болсон. Үүнтэй адил, бид Их Эзэн дээд пристүүд болон ахлагчдыг нэг чуулгад нэгтгэхийг

© GETTY IMAGES-ИЙН ГЭРЭЛ ЗУРАГ

харж, санваартнууд болон эгч нарын Бурханы хүүхдүүдэд тохинуулах арга замд томоохон өөрчлөлт гарахыг гэрчиллээ. Хэрэв энэ нь та нарыг хангалттай гайхшируулахгүй байвал, Тэргүүн Зөвлөлийн саяхан зарласан хувиараа болон гэр бүлээрээ судраас суралцах үйл ажиллагааны явцыг дэмжих шинэ эх сурвалжууд мөн үүнтэй холбоотойгоор Хүүхдийн хэсэг болон Ням гаргийн ангийн материалуудад хийгдэж буй өөрчлөлтийг бодож үзнэ үү. Харин дахин боловсруулан гаргасан гарын авлагуудаас илүү их зүйлийг олж харна байх гэж найдаж байна. Их Эзэний ажлын эцсийн зорилго бол хөтөлбөр биш, харин хүмүүс байсаар ирсэн. Тэрээр байгууллага, хуваарь эсвэл сургалтын хөтөлбөрүүдэд ямар ч өөрчлөлт хийсэн бай, үнэндээ Түүний өөрчлөхийг хүсэж буй зүйл бол та бид юм. Тэр бидний зүрх сэтгэлийг өөрчилж, ирээдүйг маань сайжруулахыг хүсдэг.

Сайн мэдээг заах, суралцах, үүний дагуу амьдрах нь бурханлаг чадавхдаа хүрч, Тэнгэрлэг Эцэг Эхтэйгээ адилхан болохын тулд өсөж хөгжих үйл явцын түлхүүр зарчмууд юм.

номлогчийн ажил, гэр бүлийн түүхийн судалгаа, ариун сүмийн ажилд гарч буй ахиц дэвшлийн талаар бүр дурдах ч хэрэггүй байх.

Өөр олон өөрчлөлт гарах нь гарцаагүй. Манай итгэлийн ес дэх тунхагт орсноор "Бурханы илчилсэн бүгдэд бид итгэ[х]" нь хийхэд хамгийн амархан хэсэг нь юм. "Бурханы хаант улсад хамаарах олон агуу хийгээд чухал зүйлийг Тэрээр цаашид илчлэх болно гэдэгт [итгэж]," юу ч байсан хүлээн авахад бэлэн байхад онцгой итгэл шаардагддаг. Хэрэв бид хүсвэл мөрөөдөл маань хэчнээн том байсан ч Бурхан биднийг очно гэж мөрөөдөж ч байгаагүй газар руу аваачих болно. Түүний бодол болон зам яаж ч бодсон биднийхээс хавьгүй өндөр билээ (Исаиа 55:8–9). Нэг талаараа, бид бошиглогч Иосеф Смитийн "Та нар эхийнхээ өвөр дээрх нялх хүүхэд лүгээ адил энэ Сүм болон хаант улсын хувь тавилангийн талаар их зүйлийг мэдэхгүй" гэж хандан хэлсэн Көртланд дахь хүмүүсээс өөр.[1]

Тэр бидний зүрх сэтгэлийг өөрчлөхийг хүсдэг

Тийм ч гэлээ, бид байсан газраа эргэн хараад, өөрчлөгдсөн журам, шинэ хөтөлбөр,

Тийм ээ, бид сорилтын дараа цаана нь байх агуу бөгөөд чухал зүйлсийг одоохондоо харж чадахгүй. Гэхдээ бид хүрэх газрынхаа талаар зарим зүйлийг мэднэ.

"Бидний ямар байх нь хараахан үзэгдээгүй. Түүнийг үзэгдэх үед бид Түүнтэй адил болно гэдгийг мэднэ. Учир нь бид Түүнийг яг байгаагаар нь харах болно" (1 Иохан 3:2).

"Та нар ямархуу маягийн хүмүүс байвал зохих билээ? Үнэнээр би та нарт хэлье, бүр миний адил буюу" (3 Нифай 27:27).

"Та нар түүний бүрэн байдлыг хүлээн авч, мөн би Эцэгт байдаг лугаа адил надаар алдарших болно; тиймийн тул, би та нарт хэлдэг, та нар ач ивээл дээр ач ивээлийг хүлээж авах болно" (С ба Г 93:20).

Та нарт ямар байгааг би мэдэхгүй ч надад бол энэ нь урт удаан боловч баяр хөөрт аялал мэт санагдаж байна. Ийм агуу зорилго нь хэдий том байсан ч гэлээ сайн мэдээг сэтгэл татам, урам зориг төрүүлэгч болгодог гол шалтгаан юм. Сэтгэлийн маань гүнд бидний яагаад дэлхийд ирсэн гэдгийг хэлдэг дуу хоолой, ой санамж байдаг. Бид хамгийн түрүүнд Тэнгэрлэг Эцэгтэй адилхан болохыг хүссэн тул

Түүний төлөвлөгөөг хүлээн зөвшөөрсөн. Энэ бол хүрэхэд амар бус, хэцүү зорилго гэдгийг бид мэдэж байсан. Гэхдээ бидэнд үүнээс доогуур ямар ч зүйл хангалтгүй юм. Бидний бодгаль өсөж хөгжихийн тулд бүтээгдсэн ба бид мөнх бус оршихуйн өмнөх амьдралдаа болон энд аялахад сүнслэгээр өдөөгдсөн.

Суралцахуй ба болохуй

Сайн мэдээг заах, суралцах, үүний дагуу амьдрах нь бурханлаг чадавхдаа хүрч, Тэнгэрлэг Эцэг, Эхтэйгээ адилхан болохын тулд өсөж хөгжих үйл явцын түлхүүр зарчмууд юм. Заримдаа бид энэ үйл явцыг *мөнхийн өсөлт хөгжил* гэж нэрлэдэг. Заримдаа бид бас үүнийг *хөрвөлт* гэдэг. Харин заримдаа бид зүгээр л *наманчлал* гэж нэрлэдэг. Бид үүнийг юу гэж ч нэрлэсэн бай, энэ нь суралцах үйл явцтай холбоотой. Бошиглогч Иосеф Смит "Та нар өөрсдөө нэгэн жижигхэн хэмжээнээс арай илүү хэмжээнд, багаахан чадвараас илүү дээд чадварт хүрэх замаар . . . бурхад, хаад болон Бурханы санваартнууд болохыг мэдэх шаардлагатай. . . .

Та шатаар өгсөх боллоо гэхэд доороос нь эхэлж, дээд талд нь гартал алхам алхмаар өгсдөг биз дээ? Сайн мэдээний зарчмуудыг эзэмших нь үүн лүгээ адил бөгөөд та нар өргөмжлөлийн анхдагч зарчмаас эхэлж, улмаар бүгдийг нь мэдэж авах ёстой" хэмээн хэлсэн.[2]

Тиймээс, одоо суралцахуйн талаар ярья. Багшлах дуртай надад энэ үг болон санаа таалагддаг боловч би энэ үгийг бидний хэлж заншсанаас арай илүү тодорхой болгох ёстой гэж боддог. Сайн мэдээний зорилгын хувьд мэдлэг хуримтлуулах нь үүний нэг хэсэг боловч энэ нь зөвхөн үүнээс бүрддэггүй. Энэ нь бас зүгээр л идэвхгүйгээр лекц сонсох эсвэл мэдээлэл цээжлэхийг хэлэхгүй. Миний ярьж буй суралцахуй нь өсөлт хөгжил, өөрчлөлт, сайжруулалтад хүргэдэг ойлголт, үнэнийг мэдэхэд хөтөлдөг ба энэ нь эргээд биднийг бүх үнэний Бурханд улам бүр ойртуулдаг юм.

Ерөнхийлөгч Рассэлл М.Нэлсон "Ариун Сүнс үнэнийг чин сэтгэлээсээ эрэлхийлэгчид итгэл үнэмшлийг өгдөг," энэ нь "Бурханы зарлигуудын дагуу наманчилж, дуулгавартай байх байдлыг дэмжих" итгэлийг хөгжүүлдэг талаар заахдаа суралцахуй болон зүрх сэтгэлийн өөрчлөлтийг авчирдаг хөрвөхүйг хоорондь нь холбосон. Хөрвөхүйн эдгээр чухал бүрэлдэхүүн хэсэг биднийг "дэлхийн *замуудаас* "зүрх сэтгэлийн агуу өөрчлөлтийг авчрагч" Их Эзэний замууд *руу* . . . эргүүлдэг."[3]

Хэдийгээр, Израилийн арван хоёр овгийн нэрийг мэдэх эсвэл чидун модны ёгтлолын бүдүүвч зургийг зурж чадах хэрэгтэй байж болох ч энэ тухай биш юм. Энэ төрлийн суралцахуй нь бид Бурханы мэддэг зүйлсийн талаар ихийг мэддэг учраас өөрсдийгөө өөрчлөх, өөр байх (илүү сайн байх) тухай юм.

Миний ярьж буй төрлийн суралцахуй нь ангид эсвэл 45 минутын хичээлд багтахгүй тийм өргөн ойлголт юм. Гарцаагүй “бүх зүйл [Түүний] тухай гэрчилдэг” тул судар, бошиглогч, эцэг эх, нарны гэрэл, бороотой өдөр, сүнслэг өдөөлт мөн өдөр тутмын амьдралын сургалтын хөтөлбөрүүд бүгдээрээ бидэнд Бурхан болон Түүний төлөвлөгөөний талаар суралцах боломжийг олгодог (Мосе 6:63). Яваандаа Тэрээр бидэнд зөвхөн сүмд биш, харин хаана ч, хэзээ ч өөрсдийн хүүхдүүд болон найз нөхөдтэйгөө, хөршүүд эсвэл ажлынхантайгаа, автобусан дотор тааралдсан хүн

Гэр орон бол сайн мэдээнээс суралцах, үүний дагуу амьдрах хоёрыг хооронд нь өө сэвгүй, төгс хослуулдаг анги, лаборатори хоёрын аль аль нь юм.

эсвэл дэлгүүрт бидэнд тусалсан ажилтан гээд ердийн цаг үед буюу сурахыг хүссэн аль ч газар, аль ч цагт заахад бэлэн байдаг болохыг бид мэдэж авдаг.

Гэвч өдөр бүр Бурханы бидэнд заахыг оролддог эдгээр бүх үнэн чулуурхаг хөрсөнд эсвэл хогийн ургамлын дунд унаж, хорчийн хатаж эсвэл тэдэнд баригддаг үртэй адил тул бид Алмагийн зөвлөгөөг дагаж, үгсийг турших эсвэл Иаковын хэлснээр зүгээр нэг сонсогчид биш, үгийг хэрэгжүүлэгчид болох хэрэгтэй (Марк 4:1–20; Иаков 1:22; Алма 32:27–43-ыг үзнэ үү). Үнэнд суралцаж, түүнийхээ дагуу үйлдэхийг сонгосноор бидний гэрчлэл өсдөг (Иохан 7:17-г үзнэ үү). Харин дараа нь, бид сорилт бэрхшээлтэй үед ч үүнийхээ дагуу амьдарч, үнэнийг өөрсдийн нэг хэсэг болгох үед энэ нь биднийг өөрчилж, үнэний Эцэгтэй илүү адилхан болгодог.[4]

Сайн мэдээний суралцахуй гэр төвтэй

Тийм учраас бид сайн мэдээг заах, суралцах, үүний дагуу амьдрах нь “гэр төвтэй бөгөөд Сүмийн дэмжлэгтэй” байх хэрэгтэй гэж үздэг.[5] Нэгдүгээрт, гэр орон бол бидний цагаа хамгийн их өнгөрүүлдэг газар юм. Бид сүмд өнгөрүүлдэг цагаасаа илүү их хугацааг гэртээ зарцуулдаг нь үнэн (хэт их ачаалалтай ажилладаг бишопуудыг эс тооцвол). Хэчнээн сайн тэжээллэг хоол ч гэлээ, долоо хоногт ганцхан удаа хооллосноор амиа зогоох боломжгүй. Үүнтэй адил, Сүмийн нэг цагийн анги онцгой сайн анги байсан ч “Христийн үгнээс [зооглох]” (2 Нифай 31:20) үндсэн орчин маань байсан ч бид сүнслэг хоол тэжээлийн дутагдалд орох аюултай.

Хоёрдугаарт, гэр орон бол сайн мэдээнээс суралцах, үүний дагуу амьдрах хоёрыг хооронд нь өө сэвгүй, төгс хослуулдаг анги, лаборатори хоёрын аль аль нь юм. Энэхүү амьдралын лабораторийн туршлагыг зөвхөн ангид давтан хийх боломжгүй.

Магадгүй хамгийн чухал нь, гэр орон бол энд гүйцэлдүүлэхээр ирсэн мөнхийн зорилгыг сануулдаг тэнгэрийн цуурай буюу ийм цуурай байж болно. Тэргүүн Зөвлөлийн хоёрдугаар зөвлөх, ерөнхийлөгч Хэнри Б.Айринг энэ талаар ийн хэлсэн. “Дэлхий дээрх гэр бүлүүд төгс биш

ч энэ нь тэнгэрт мэдэрч байсан хайртай нь хамгийн ойр дөхөж очих эцэг эхийн хайраар Бурханы хүүхдүүдийг дэлхийд угтан авах хамгийн сайхан боломжийг өгдөг. Түүнээс гадна гэр бүл нь Бурханы оршихуйд эргэн очиход хөтлөх ёс суртахууны үнэт зүйлс, үнэн зарчмуудыг хадгалж, уламжлуулан үлдээх хамгийн сайн арга зам юм"[6] гэжээ.

Эцэг эхчүүд та нарыг би айлгачихав уу даа? Тэгээгүй гэж найдаж байна. Гэр орондоо зааж, суралцаж, амьдрахыг ийнхүү онцолж байгаа нь хувь хүн болон гэр бүлүүдэд нэмэлт ачаа дарамт өгөхийг хүссэндээ биш юм. Үнэндээ энэ нь үүний эсрэг буюу бид гэр орондоо гаргаж буй хүчин чармайлтыг хүлээн зөвшөөрч, дэмжин тусалснаар та нарын үүрч буй ачаа дарамтыг ямар нэгэн хэмжээгээр хөнгөлж чадна. Эсвэл бүр түүнээс дээр, бид "[үүнийг] амархан дааж чадахын тулд" (Мозая 24:15) та нарыг хүчирхэгжүүлж болох юм.

Сүмд сайн мэдээнээс суралцах үйл явцыг дэмжих нь

Сайн мэдээг ангиас гадуур хүлээн авах энэхүү өргөн ойлголт нь ангид суралцахыг чухал биш гэж байгаа юм биш ээ. Мэдээж, утга учиртай суралцах үйл явц сүм дээр цаашид явагдсан хэвээр байгаасай гэж бид найддаг. Үнэндээ гэр төвтэй суралцах үйл явцад Сүмийн хичээлийн туслах үүрэг маш чухал. Гэхдээ амьдралыг өөрчлөхөд туслахын тулд сүм дээр заах үйл явц тэр хүмүүсийн амьдралд болж буй зүйлээс салангид байж болохгүй. Энэ нь багш, суралцагч хоёрын аль алиных нь туршлагатай холбоотой бөгөөд тэдгээрт тулгуурласан байх ёстой.

Тиймээс гарын авлага, самбар эсвэл сандлуудын байрлалд юм уу харилцан ярианы зарим сайн асуултад анхаарлаа төвлөрүүлэх нь буруу гэдэг нь тодорхой. Тухайн хүн Бурханы хүүхэд бөгөөд түүний мөнхийн өсөлт хөгжил бидний хичээл зүтгэл, хайр халамжийн төвд байх ёстой. Бид хүмүүсийн амьдралд хүрэхийг хичээж байгаа бөгөөд сандал, шохой эсвэл дуу бичлэгийн тоног төхөөрөмж нь зөвхөн тэдний амьдралд хүрэхэд туслах үед л тэр зорилгодоо хүрнэ. Аврагчийн хэлснийг дахин хэлье. Багш

ГЭР ОРОНДОО САЙН МЭДЭЭНЭЭС СУРАЛЦАЖ, ҮҮНИЙ ДАГУУ АМЬДРАХ НЬ

Хожмын үеийн гэгээнтэн болон гэгээнтэн бус судлаачдын аль аль нь гэр төвтэй шашны үйл хүүхдүүдэд хүчтэй бөгөөд ур удаан хугацааны нөлөө үзүүлдэг гэдгийг нотолжээ. Хүүхдүүд өсөж том болж, насанд хүрэхээрээ бага насандаа тавигдсан шашны итгэл үнэмшил, хэв маягийг ихэвчлэн хадгалан авч үлддэг байна.

"Гэр бүл: Дэлхий дахинаа өргөх тунхаг"-т байх зөв шударга ёсны зарчим дээр гэр бүлээ үндэслэн бий болгосон эцэг эхчүүд хүүхдүүддээ цаг хугацааны явцад хуримтлагддаг давуу талуудыг өгч, сүнслэг бөгөөд материаллаг адислалуудыг авчирдаг.

Мөн АНУ-д хийгдсэн Сүмийн судалгаагаар өдөр бүр гэр бүлээрээ залбирч, долоо хоногт дор хаяж хэдэн удаа судраас суралцаж, долоо хоног бүр гэр бүлийн үдэш хийдэг хожмын үеийн гэгээнтэн гэр бүлийн хүүхдүүд, өсвөр үеийнхэн насанд хүрэхээрээ долоо хоног бүр сүмд очиж, хишиг хүртэн, ариун сүмд гэрлэх магадлал бусдаас 20 орчим хувиар илүү байдгийг тогтоожээ.

Мэдээж, хүүхдүүд өөрсдөө сонгох эрхтэй тул гэр бүлээрээ тогтмол залбирах, судраас суралцах зэрэг эцэг эхийнх нь гэртээ хийдэг шашны итгэлт зан үйлийн үр дүнд хүүхдүүд нь эцэг эхийнхээ үнэт зүйлсийг хүлээн зөвшөөрнө гэсэн үг биш юм. Эцэг эхчүүд сайн үлгэр жишээ үзүүлэн, хүүхдүүдээ хайрладаг ойр дотно харилцаатай бөгөөд шашны сэдвээр нээлттэй ярилцдаг бол шашны итгэл үнэмшил, зан байдлыг дараагийн үедээ дамжуулан үлдээх магадлал өсдөг байна. Тухайн хүний шашны зан үйлд гэр бүл үнэхээр хүчтэй нөлөө үзүүлдэг тул эцэст нь "үрэлгэн" хүүхдүүдийн ихэнх нь мөнх бус амьдралынхаа хугацаанд сүрэгтээ эргэж ирдэг.

Энэ судалгаагаар гэр төвтэй сайн мэдээнээс суралцах үйл явц сайн байх нь эерэг үр дүнтэй гэдгийг харуулсан ч, тэдгээр нь мөн Сүмийн тусламж дэмжлэг шинэ хөрвөгчдөд юм уу сайн мэдээний зан үйлийг сайн дагадаггүй гэр оронд амьдардаг бусад гишүүнд чухал болохыг мөн адил харуулсан. Өөр гэр бүлтэй хамт гэр бүлийн үдшийг хэрхэн хийх, гэр бүлээрээ хэрхэн тогтмол залбирах, гэр орондоо шашны талаар эерэг арга замаар хэрхэн ярилцах, илүү туршлагатай гишүүдтэй хамт тохинуулал хийх зэргийг үлгэр жишээгээр үзүүлж, зааж зөвлөх нь энэ гишүүдэд илүү ач тустай байж болно.

эсвэл анги нь дэлхийн хамгийн агуу сургаалын толилуулгыг танилцуулж байгаа ч аль ч сургаал гишүүний буюу Бурханы аварч, өргөмжлөхийг ихэд хүсэж буй тэр хүний амьдралд мөн хайранд болон бодол санаа, мэдрэмжинд илрэхгүй бол ямар ашиг тустай байх билээ?

Хичээл хэр сайхан явагдсан, цагийг хэр сайн ашигласан, хичээлийн дараа багш хэр их магтаал сайшаал хүртсэн эсвэл хэдэн ангийн гишүүн хичээлд оролцсон зэрэг нь амжилтын жинхэнэ хэмжүүр биш юм. Амжилт нь тухайн суралцагчийн амьдралд юу болж байгаагаас хамаарна. Хэррэро ах тулгараад байсан асуудлаа шийдвэрлэхэд өөрт нь тусалсан ямар зүйлийг өнгөрсөн долоо хоногийн хичээлийнхээ судраас олсон бэ? Эсвэл ангид тохиолдсон ямар нэгэн явдал өөрт хэрэгтэй хариултаа долоо хоногийн явцад олох чадварыг нь сайжруулсан уу? Түүнийг өөрийн тэрхүү туршлагыг энэ долоо хоногт хуваалцахад Шмидт эгч Бурхан өөрт нь ч гэсэн тусална гэдэгт итгэхэд хэрэгтэй итгэл найдвараа олж авсан уу? (“Бусдыг харснаар та чийрэг болохгүй”-г үзнэ үү.)

Хэрэв та багш бол манай аль нэгэн шинэ сургалтын материалууд дээрээс харах зүйлс тань манай хуучин гарын авлагаас хардаг байсан зүйлээс тань арай өөр байгааг олж харах болно. Та юу хийх мөн хэрхэн хийх талаар тодорхой бус ерөнхий зааврыг олох болно. Энэ нь таныг өөрийн болон зааж буй хүмүүсийнхээ туршлага, сүнслэг өдөөлтийн талаар залбирч, эрж хайх, ашиглахад уриалах зорилготой юм. (“Та найрал дуунд гоцолж байна уу эсвэл удирдаж байна уу?”-г үзнэ үү)

Тэгэхээр, суралцах хичээл нь Шинэ Гэрээ бөгөөд өөрийгөө Ням гаргийн ангийн багш гэж бодъё. Би Матай 5-ын түүхэн цаг үеийн тухай бөөн баримт мэдээлэл, Уулан дээрх номлолын талаар мэргэдийн хэлсэн сүнслэг эшлэл мөн хэрхэн амар тайвныг тогтоогч байх талаар бүтээлч үйл ажиллагаатай ирж, бүгдийг нь хичээл эхлэхээс тав ч хүрэхгүй минутад эмхэлж цэгцлэх шаардлагагүй. Харин үүний оронд би суралцагчдын хийх ёстой зүйлийг буюу Матай 5 дээрх зарчмуудыг судалж, тэдгээрийн дагуу амьдрах ёстой. Цорын ганц ялгаа нь би үүнийг хийхдээ ангийн гишүүн нэг бүрийн талаар, мөн эдгээр зарчим тэдний хувьд ямар утга учиртай байж болох талаар илүү сайн бодож, залбирахад оршино. Дараа нь би ангид, Сүнсний нөлөөн доор, тэднийг Матай 5-ыг судалж, үүний дагуу амьдрахад нэг нэгнээ сэнхрүүлж, дэмжихэд уриална. Би тэдэнд амьдрал, судар дээрх үнэт сургаалуудын хоорондох холбоог харахад тусална. Юуны түрүүнд, би баримт мэдээг итгэл, асуултыг эрэл хайгуул болгохын тулд тухайн цаг мөчид сүнслэг өдөөлт хүлээн авахаар залбирна.

БУСДЫГ ХАРСНААР ТА ЧИЙРЭГ БОЛДОГГҮЙ

Арван хоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Нийл Л.Андэрсэн сайн мэдээнээс суралцахыг фитнес төвтэй харьцуулсан. Түүний хэлснээр, суралцагчид “хэн нэгний дасгал хийж байгааг харснаар хүчтэй болдоггүй. Тэд суралцдаг, тэгээд өөрсдөө оролцдог. Сүнслэг хүч өсөхийн хэрээр тэдний өөртөө итгэх итгэл өсөн нэмэгдэж, өөрсдийнхөө амьдралд илүү ихээр хэрэгжүүлэх болно” [evening with a General Authority, broadcast for Church Educational System religious educators, Feb. 28, 2014], broadcasts.lds.org).

ТА НАЙРАЛ ДУУНД ГОЦОЛЖ БАЙНА УУ ЭСВЭЛ УДИРДАЖ БАЙНА УУ?

Багш нарт ихэнхдээ бүх зүйл өөрсдөөс нь хамаардаг бас гоцлон дуулаач мэт санагддаг. Үүний оронд тэд өөрсдийгөө найрал дууны удирдаач гэж харж болно. Багшийн үүрэг өөрмөц бөгөөд эрэлт хэрэгцээтэй. Тэд ярилцлагыг хөтөлж, сайн мэдээний дагуу амьдрахад сүнслэгээр өдөөж, цэвэр сургаал руу бүгдийг чиглүүлдэг. Гэвч хөгжим биднээс төрөн гардаг. Багш нар биднийг судраас суралцах өөрийн гэсэн туршлагатай болоход урьж, сүнслэгээр нөлөөлөх замаар бидний хүн нэг бүрийн дотор байх сайн мэдээний дуу хоолойг олоход тусалдаг. Харин дараа нь бид ангидаа ирээд, хувийн бодол санаа, олж мэдсэн зүйлсээ хуваалцдаг. Энэ нь дууны дахилтан дээр нэмэгддэг.

Мэдээж, Хүүхдийн хэсэгт гүйцэтгэх миний үүрэг арай өөр байна. Гэхдээ миний зорилго бол багачуудыг 45 минутын турш зугаацуулах эсвэл хэлэх зүйлээ тасалдуулалгүй хэлэхийн тулд тэднийг чимээгүй байлгах явдал биш юм. Миний зорилго бол тэднийг суралцагч гэдэг үүднээс биеийг нь даалгаж, амьдрал нь сайн мэдээний үнэнүүдээр хэрхэн баяжиж байгааг олж харахад тусалж, тэдний хамгийн чухал сайн мэдээний багш нар болох эцэг эхийг нь дэмжиж туслах явдал юм.

Одоо би эцэг эхчүүдийг гайхшируулсныхаа дараа багш нарыг айлгасан байж магадгүй. Хэрэв тийм бол, би та нарт хоёр зүйлийг батлан хэлье. (1) Та нар хүмүүст зааж байгаа бөгөөд та хүмүүсийг ямар ч хичээлийн гарын авлагаас илүү сайн мэддэг. (2) Сайн мэдээнээс суралцаж, үүнийхээ дагуу

Амжилт нь тухайн суралцагчийн амьдралд юу болохоос хамаарна.

амьдрахын тулд гаргаж буй хувийн хүчин чармайлт тань бусдад сайн мэдээг заахад бэлтгэх хамгийн сайн арга зам юм. Амьдралдаа болон заах үйл явцдаа Сүнсийг урин авчрах хамгийн шилдэг арга бол өөрсдөө сайн мэдээнээс суралцаж, үүний дагуу амьдрах явдал гэдгийг сана. Сүнс бол энэ Сүмийн гол багш бөгөөд аз болоход тэр нөлөөнд хязгаар гэж үгүй.

Тэрээр замыг тавьж, зааж чиглүүлсэн

Их Эзэн биднийг сайн мэдээнээс суралцаж, үүний дагуу амьдрах шинэ арга замаар дамжуулан сүнслэг байдлын хувьд өсөлт хөгжлийн шинэ түвшинд өргөн гаргаасай хэмээн бид хүсдэг билээ. Түүний тусламжтайгаар бид сайн мэдээг найз нөхөдтэйгөө хуваалцах болно. Бид үүнийг заавал биелүүлэх үүргийн хувьд биш, харин сайн мэдээ бидний өдөр тутмын амьдралын нэг хэсэг бөгөөд сайн мэдээний зарим үнэнийг хуваалцалгүйгээр амаа нээж чадахгүйдээ хийнэ. Үнэндээ, өөр шашин шүтлэгтэй найзууд маань бидний амьдралд өсөн нэмэгдэх гэрлийг хараад, харсан зүйлсийнхээ заримыг нь ч болов гэр бүлдээ олж авахын тулд номлогчдыг өөрсдийг нь олохоос өмнө өөрсдөө тэднийг олж очих болно. Ариун сүмийн гэрлэлт, гэр бүлийн түүхийн ажил, санваарын хүч болон ёслолууд, ёс суртахууны цэвэр ариун байдал, ядуусыг асран халамжлах зэрэг нь бүгд Христийн гүн гүнзгий хөрвөгдсөн шавь нар Ням гаргийн ангийн бүрэн дүүрэн, зохистой, тогтмол дэмжлэгтэйгээр сайн мэдээнээс өдөр бүр суралцаж, үүнийхээ дагуу амьдарсны үр дүн байх болно. Их Эзэн биднийг үүн рүү удирдан чиглүүлж байгаа бөгөөд энэ нь үнэхээр сэтгэл хөдөлгөм аялал билээ!

Бид Түүний тааллаас суралцан, гэрэл ба үнэнийг цуглуулж, өдөр бүр өөрсдийн нэгэн хэсэг болгох юм бол тэрхүү гэрэл бидэн дотор өсөх болно гэдгийг би гэрчилж байна.

Бид “Аврагчийн арга барилаар заах нь” гэдэг хэллэгийг хэрэглэдэг боловч энэ нь улиг домог болсон, нэгэн хэвийн хэллэг хэзээ ч битгий болоосой гэж би найддаг. Үнэндээ бид багш, суралцагчдын хувьд Христтэй адил болж, Түүний заасан арга барилаар сайн мэдээг хуваалцахыг хичээх хэрэгтэй гэдгийг үүгээр дамжуулан илэрхийлж байгаа юм. Энэ бол шавь нартай нэгдэн, Есүстэй хамт том болон жижиг замаар явж, алдагдсан нэгнийг хайж олох боломж. Энэ нь Бийтитудс уул руу олны хамт авиран гарч, Галилейн эрэг дээр бүгдтэй хамт суух боломж. Энэ нь бидний хүн нэг бүрийн хувьд Эзэний хувцасны захад хүрч, эдгээгдэх боломж юм.

Сүмийн хамгийн сэтгэл хөдөлгөм дууллын нэг болох Элэйза Р.Снөүгийн үзэглэсэн дараах шүлгийн үгс надад үргэлж таалагдсаар ирсэн.

Тэр замыг тавьж, зааж чиглүүлэн,
Бүхнийг тодорхойлж,
Бурхны оршихуй бүрэн гэрэлтэх тэнд
Гэрэл, амьдрал, эцэс төгсгөлгүй өдрүүдийг өгнө.[7]

Ах, эгч нар аа, Тэнгэрлэг Эцэгийн бидэнд бэлдсэн алдар суут ирээдүй рүү та нартай хамт алхаж байгаа нь миний хувьд нэр төрийн хэрэг. Би та нарын зүрх сэтгэлийг мэднэ. Та нар Их Эзэнд хайртай мөн Түүний хүслийг гүйцэлдүүлэхийг хүсдэг гэдгийг би мэднэ. Бид Түүний тааллын талаар суралцан, гэрэл ба үнэнийг цуглуулж, өдөр бүр өөрсдийн нэгэн хэсэг болгох юм бол тэрхүү гэрэл бидэн дотор “*төгс* өдрийг хүртэл улам улам хурц” (С ба Г 50:24; тодотгол нэмэгдсэн) болон өсөн нэмэгдсээр бид Их Эзэнтэй адилхан болсон байх учир Түүнтэй хамт байх боломжтой болно гэдгийг гэрчилж байна. ■

ЭШЛЭЛҮҮД

1. *Сүмийн ерөнхийлөгчдийн сургаалаас: Иосеф Смит* (2007), 157.
2. *Сүмийн ерөнхийлөгчдийн сургаалаас: Иосеф Смит* (2007), 250, 303.
3. Russell M. Nelson, “Jesus Christ—the Master Healer,” *Liahona,* Nov. 2005, 86.
4. Dallin H. Oaks, “The Challenge to Become,” *Liahona,* Jan. 2001, 40–43; мөн Дэвид А.Бэднар, “Их Эзэнд хөрвүүлэгдэв,” *2012 оны 10-р сарын Ерөнхий чуулган,* 130–133.
5. *Гарын авлага 2: Сүмийг удирдах нь* (2010), 1.4.
6. Хэнри Б.Айринг, “Бурханы гэр бүлийг цуглуулах нь,” *2017 оны 4-р сарын Ерөнхий чуулган,* 3.
7. “How Great the Wisdom and the Love,” *Hymns,* no. 195.

ШИНЭ ОЙЛГОЛТУУД ТӨРӨХ БОЛНО

“Таныг сургаалын зарчмуудын талаар тунгаан бодож, залбирахад Ариун Сүнс таны оюун бодол, зүрх сэтгэлд ярих болно. Сударт гардаг үйл явдлуудаас шинэ ойлголтууд төрж, таны нөхцөл байдалтай холбоотой зарчмууд зүрх сэтгэлд аажмаар буух болно.

Аль хэдийн өгөгдсөн гэрлийнхээ дагуу амьдарч, судруудыг цэвэр ариун зорилгоор, ‘Христэд ирэх’ чин сэтгэлийн хүсэлтэйгээр судалснаар ийм илчлэлтийн туршлагыг та хуримтлуулна. Таныг тийн үйлдэхэд өөртөө итгэх итгэл тань ‘Бурханы оршихуйд хүчтэй болох болно’ мөн Ариун Сүнс таны байнгын хамтрагч байх болно.”

President Russell M. Nelson, “Living by Scriptural Guidance,” *Liahona,* Jan. 2001, 21.

БИ *ИРЭЭД, НАМАЙГ ДАГА* ШИНЭ ЭХ СУРВАЛЖИЙГ ХЭРХЭН АШИГЛАХ ВЭ?

Хувь хүн ба гэр бүлүүд, Ням гаргийн анги болон Хүүхдийн хэсэгт зориулсан *Ирээд, Намайг дага* шинэ эх сурвалжууд нь бидэнд гэр орондоо болон сүмд судраас суралцах учир утгатай туршлагуудтай байхад туслахаар зориулагдсан. Тэгэхээр эдгээр *Ирээд, Намайг дага* шинэ эх сурвалжууд хэрхэн хамтдаа ажиллах вэ?

- 2019 онд та нарыг Шинэ Гэрээг судлахад урина. *Ирээд, Намайг дага—Хувь хүн, гэр бүлүүдэд зориулав* гарын авлага нь хувиараа болон гэр орондоо гэр бүлээрээ суралцах үйл явцыг дэмжих санаануудыг өгнө. Үүнийг өөртөө тустай ямар ч арга замаар ашиглаж болно.
- Долоо хоног бүр насанд хүрэгчид, өсвөр үеийнхэн болон хүүхдүүд Сүм даяар Шинэ Гэрээний яг нэг ижил бүлгийг судалж, ярилцах болно.
- Хэрэв та Ням гаргийн ангийн асвэл Хүүхдийн хэсгийн багш бол *Ирээд, Намайг дага—Хувь хүн, гэр бүлүүдэд зориулав* гарын авлагыг хувиараа болон гэр бүлээрээ суралцах үйл явцаа сайжруулахад ашигла. Та мөн ангийн гишүүдийн гэртээ хийж буй судраас суралцах үйл явцыг дэмжих мөн сонирхол татах ангийн үйл ажиллагааг хийхэд туслах багшийн гарын авлагыг авах болно.

Ирээд, Намайг дага шинэ эх сурвалжуудын талаар илүү дэлгэрэнгүй мэдээллийг **comefollowme.lds.org** вэбсайтаас үзнэ үү.

Шийдвэрүүд болон гайхамшгууд: Би одоо харж байна

Ирина В.Крацэр

Энэхүү шинэ цуврал сүсэг бишрэлтэй эмэгтэйчүүдийн амьдрал, захиасаас онцлон нийтлэх бөгөөд *At the Pulpit: 185 Years of Discourses by Latter-day Saint Women* (2017) номноос хэсэгчлэн авав. Уг ном англи, португаль, испани хэлээр хэвлэгдсэн.

Нэгэн цагт Христийн гэрэл болон хайр миний амьдралд ирсэн. Тэр үеэс хойш амьдрал минь үүрд өөрчлөгдсөн юм.

Сургаалгүй амьдрал ямар байдгийг би мэднэ. Би тийм амьдралаар 30 жил амьдарсан. Би Орос улсад буянт сайн эцэг эхээс мэндэлсэн. . . . Би өсөж том болж, гэрлээд, хөөрхөн охин төрүүлсэн. Удалгүй би их сургуулиа амжилттай төгсөж, дуртай ажилдаа ч орсон. Гэхдээ л би аз жаргалаас асар хол байлаа.

. . . Гэрлэлт минь . . . яваандаа нурж унав. . . . Би охиноо ч, өөрийгөө ч наад захын хоол хүнсээр хангаж чадахгүй байв. Би нүгэл үйлдэж, олон буруу сонголтыг ар араас нь хийсэн. Өлсгөлөн, сэтгэлийн хямрал, буруу шийдвэрүүд амьдралыг минь зовлон болгож хувиргав. Би үйлдсэн нүглийнхээ үр нөлөөний улмаас ингэж зовж байгаагаа ойлголгүй, золгүй заянд төрсөндөө [буруугаа тохож байлаа]. Гэвч би үүнийг хэрхэн мэдэх билээ дээ? Надад зааснаар бол нүгэл гэж байдаггүй байв. . . .

1917 оны Коммунист хувьсгалын дараа Зөвлөлт Холбоот Улсад шашныг хориглосон. Цэцэрлэгт байх цагаас эхлэн надад Бурхан гэж байдаггүй, зөвхөн Коммунист нам, Ленин өвөө л оросуудад аз жаргалыг авчирна гэж заадаг байсан юм. Манай нийгэмд шашин шүтлэгтэй хүмүүсийг маш ихээр хавчин дарамталдаг байв. Итгэгчид ажлаа алдаж, сургуульд явахыг нь хориглож, тэднийг "галзуу" гэж нэрлэдэг байлаа. Хүн бүр их сургуульд байхдаа Бурхан байдаггүй гэдгийг нотолдог шашингүй үзлийн тухай хичээлд заавал суудаг байв. Би Бурханы талаар зүгээр л бодоогүй байлаа. Гэсэн ч би буруу сонголтынхоо өвдөлтийг зүрх сэтгэлдээ мэдэрч байсан юм. Хожим нь надад мэдрэгдсэн тэр өвдөлт зөв бурууг дотоод сэтгэлд минь мэдрүүлдэг Христийн гэрэл байсныг би ойлгосон. . . .

. . . Амьдрал яг л төгсгөлд нь үхэл намайг хүлээж буй харанхуй хонгил мэт надад санагддаг байлаа. Би аажим аажмаар үхэж байна гэдгээ мэддэг байв. . . . Би яаж залбирахаа мэддэггүй байсан тул зүгээр л мөрөөддөг байсан юм. . . . Би нэгэн өдөр амьдралынхаа бүх зовлон зүдгүүрээс зугтаж, дахин нэг удаа эхнээс нь аз жаргал, гэрэл

КРАЦЭР ЭГЧИЙН ТУХАЙ

Ирина Валентиновна Крацэр (1965 онд төрсөн) Сибирийн Барнаулд амьдарч байсан бөгөөд тэнд байхдаа Анагаахын их сургуульд суралцан, зүрхний эмч болжээ. Анагаахын салбарт ажиллах нь цалин багатай байсан ба эмнэлэг олон сараар цалингаа өгөхгүй байдаг байв. 1996 онд хүчирхийлэгч нөхрөөсөө салсныхаа дараа Ирина бага цалингаараа ээж, охин хоёроо тэжээхийн тулд шөнийн ээлжинд илүү цагаар ажилласнаасаа болж ядарч туйлдан, итгэл найдвараа алдсан байв.

Ирина шашингүй орчинд өссөн бөгөөд Бурханд итгэдэггүй нэгэн байлаа. Гэсэн ч нэгэн шөнө тэрээр: "За, Бурхан минь, Та байдаг л юм бол надад мэдэгдээч. Учир нь та намайг огт тоодоггүй бололтой. Би таны хувьд хэн юм бэ? Энд амиа зогоох төдий хичээж байгаа өчүүхэн зүйл юм уу?" гэсэн хүсэлт тавьжээ.

Хэдэн долоо хоногийн дараа, 1996 оны 8-р сард Ирина нэгэн эрэгтэйтэй танилцсан бөгөөд тэр түүнийг Сүмтэй танилцуулж, түүнийг англи хэл сурахаар Америкийн Нэгдсэн Улс руу явахад туслав. Ирина 1998 оны 4-р сард, АНУ-ын Юта мужид ирснээсээ хойш найман сарын дараа Тэй Крацэртай гэрлэжээ.

Крацэр эгчийг Юта мужийн Орем хотын Халамжийн нийгэмлэгийн багш байхад Бригам Янгийн Их Сургуулийн Эмэгтэйчүүдийн чуулган дээр үг хэлүүлэхээр урьжээ. [Цэг тэмдэг болон том үсэг хэрэглэх дүрмийн стандартын дагуу засварлав.]

гэгээтэйгээр эхлүүлнэ дээ гэж мөрөөддөг байв. Би охиноо надаас илүү сайхан амьдралтай байгаасай гэж их хүсдэг байсан.

[Тэгтэл] Мормоны Ном амьдралд минь орж ирэв. Би өглөө бүр ажилдаа явахаасаа өмнө нэг бүлэг уншдаг байлаа. Энэ номыг уншсанаар би Бурхан амьд, Есүс бол Түүний Хүү бөгөөд надтай адил нүгэлтнүүдэд туслахын тулд энэ дэлхийд ирсэн гэдгийг олж мэдэв. Уг номыг уншихын хэрээр би Христийн сургаал болон өөрийн минь амьдардаг байдал хоорондоо ямар их ялгаатай болохыг улам сайн хардаг болов. Би бас яагаад миний амьдрал тийм зовлонтой байсныг ойлгосон. . . .

. . . Би эрс өөрчлөлт хийхэд бэлэн болсон байлаа. Би шөнөжин уйлж, буруу амьдарч байснаа мөн миний хийсэн буруу шийдвэрүүд хамгийн их хайрладаг хүмүүсийг минь зовлонд унагааж байсныг ухааран ойлгосон. . . . Энэ шөнийг би огт мартдаггүй. Энэ нь миний амьдралын хамгийн хүнд хэцүү үйл явдал байв. Би шөнөжингөө уйлж, гуйж билээ. . . . Шөнө дуусахын алдад би эцэж ядран, уйлах нулимс ч үгүй болсон байв. Үүр цайхад, амар амгалан, тайтгарал надад ирсэн юм. Би "Энэ миний мутар. Би чамайг хөтөлж, замыг чинь заана. Гэхдээ чи надад өөрчлөгдөнө гэдгээ амлах хэрэгтэй" гэсэн үгсийг сонссон. Би ч амласан. Би тэр удирдамж, тусламжийг юу юунаас илүү хүсэж байлаа. . . .

Орост өнгөрүүлсэн тэр хэцүү бөгөөд баярт шөнө Христийн амлалтууд ямар агуу болохыг би мэдээгүй юм. Тэр үед би хэдхэн сарын дараа Америк явж, сайн мэдээний талаар илүү ихийг сурч, тун удалгүй баптисм хүртэнэ гэдгээ мэдээгүй. Би бас охин минь Америкт ирж, аз жаргалтайгаар бидэнтэй нэгдэнэ гэдгийг ч мэдээгүй. . . .

. . . Христ надад маш олон гайхамшгийг өгсөн бөгөөд Түүний тэнгэрлэг мутар миний амьдралд байгаа эсэхэд өчүүхэн төдий ч эргэлзэх үе гарч байсангүй. . . .

Христтэй хамт алх! Түүний мутраас барь! Түүний үгэн дээр найрла. Түүний гэрлийг бүх нүх сүвээрээ, бүх бодгалиараа өөртөө шингээ. Хүнд хэцүү үед Тэр таныг харанхуй хонгилд орхихгүй. Харин таны өмнө улам бүр тодрон гэрэлтэх Түүний хайрын гэрэлд байх болно. ■

GETTY IMAGES-ИЙН ХҮРЭЭ БОЛОН ГЭРЭЛ ЗУРАГ

“Би бол Би байдаг”

Хуучин Гэрээн дээрх Есүс Христийн бэлгэдлүүд

Ялангуяа энэ эртний бичээс дээр Есүс Христийг хайх хэрэгтэй ба Түүнийг олохгүй байж ч болох юм.

Стивэн П.Шанк

Сүмийн санваарын болон гэр бүлийн хэлтэс

Мосег нүүрээ нуухад дүрэлзэн асах бутнаас Их Эзэний энэрэлт үгс мөнхийн цуурай адил: "Өөрийн ард түмний зовлонг Би сайтар харж, . . . Би тэдний зовлонг мэдсэн.

Тиймээс тэднийг . . . чөлөөлж, аваачихаар Би бууж ирлээ.

Тэгэхэд Мосе Бурханд—Хараач. Би Израилийн хөвгүүд уруу очиж, тэдэнд Та нарын өвөг дээдсийн Бурхан намайг та нар уруу илгээв гэж хэлэхэд, тэд надаас "Түүний нэр хэн бэ?" гэж асуувал, би тэдэнд юу гэж хэлэх вэ? гэв.

Бурхан Мосед—Би бол Би байдаг гэв. Тэгээд Тэр—Израилийн хөвгүүдэд чи «Би байдаг» намайг та нар уруу илгээв" гэж хэлэх нь дуулдсан аж (Египетээс гарсан нь 3:7–8, 13–14).

Эртний израильчуудад Эзэн Иехова гэдэг нэрээр танил байсан мөнх бус байдлын өмнөх амьдрал дахь Есүс Христ гэтэлгэлийг олж авахын тулд харах ёстой эх сурвалж бол Өөрийгөө хэмээн хүмүүстээ тодорхойлж өгсөн. Хэдэн мянган жилийн дараа, амилсан Есүс Христ чөлөөлөлтийн амлалтаа өнөөгийн Израильд дараах үгсээр дахин баталжээ. Тэрээр: "Иймийн тул, зоригтой байгтун, мөн бүү эмээ, учир нь Их Эзэн бибээр та нартай хамт байна, мөн та нарын дэргэд зогсч байх болно; мөн та нар миний тухай бүр Есүс Христийг, *би бол* амьд Бурханы Хүү, *би байсныг, би байгааг, би байх болно* гэдгийг гэрчлэх ёстой" хэмээн хэлсэн (С ба Г 68:6; тодотгол нэмэгдсэн).

Амийн үгс болох судрууд нь үе үеийн Бурханы хүүхдүүд биднийг нүгэл, үхэл хийгээд дэлхийн бүх асуудлаасаа чөлөөлөгдөхийн тулд Есүс Христэд хандуулах зорилготой байдаг. Хуучин Гэрээ ч үүнээс гажаагүй. Судрын боть бүр нь бидний зүрх сэтгэл, оюун ухааныг Чөлөөлөгч, Их Эзэн Есүс Христ рүү хандуулах зорилготой. Хэдий тийм ч, ялангуяа энэ эртний бичээс дээр Түүнийг хайх хэрэгтэй буюу Түүнийг олохгүй байж магадгүй.

Судрын аль ч номоос Христийг эрж хайхдаа, юу хайж байгаагаа өөрсдөдөө тогтмол сануулж байх нь их тусалдаг. Есүс Христ *бол* амьдралын эх ундарга мөн! Уналт болсноор гарч ирсэн сүнслэг болон бие махбодын үхлийн хор хөнөөлт асуудлуудын хувьд Христ *бол* Израилийн мөнхийн шийдэл билээ. Лихай "хуулийн шаардлагуудыг *хангаж*, . . . тэрээр өөрийгөө өргөх ажгуу" хэмээн тунхагласан (2 Нифай 2:7; тодотгол нэмэгдсэн). Бид судруудаас судлахдаа яг энэ хариултыг буюу Агуу "Би бол" хэмээх Израилийн Цагаатгагчийг эрж хайдаг. Гэхдээ Хуучин Гэрээний яруу найргийн, ихэвчлэн эртний үг хэллэгээс болоод мөнхийн асуудлуудыг, тухайлбал шийдэл нь болох Есүс Христийг тодорхойлоход амаргүй. Гэсэн ч далд, эртний өгүүллэгүүдээс Есүс Христийг олж авахад бэлэн байж байдаг.

Мосетэй Синай уулан дээр хуваалцсан Их Эзэний "Би бол" гэснийг дотроо санаад, Есүс Христэд итгэл найдвараа тавьдаг хүмүүсийн хувьд Тэр хэн *байж* болох талаар олон зүйлийг бодож үзнэ үү. Дараах жишээнүүд нь чөлөөлөгдөхийн тулд Их Эзэн Есүс Христэд зүрх сэтгэл, оюун ухааныг маань хандуулахад зориулагдсан Хуучин Гэрээний бэлгэдэл бүхий сургаалууд юм.

ХУУЧИН ГЭРЭЭНЭЭС ЕСҮС ХРИСТИЙГ ЭРЭЛХИЙЛЭХ

Хуучин Гэрээн дэх бошиглогчдыг оролцуулан бошиглогчдыг "Мессиагийн төлөөлөгч болон сүүдэр" хэмээн харж болно гэж Арван хоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Брүс Р.Макконки (1915–1985) бичсэн. "Христтэй адил зүйлсийг бүх газраас эрж хайн, Түүнийг болон Түүний хуулиудыг оюун ухааныхаа гүнд хадгалахын тулд тэдгээрийг ахин дахин ашиглах нь тустай бөгөөд зүй ёсны хэрэг юм" (*The Promised Messiah* [1985], 453).

Хуучин Гэрээ нь зөвхөн Бурханы гэрээт хүмүүсийн хүүрнэл түүхийг хадгалахад зориулагдаагүй. Христийн шавь нарын хувьд түүхүүд нь дангаараа, дагалдах өнгөцхөн захиас, сургамжуудтайгаа хамт хоёрдогч ач холбогдолтой. Тиймээс бошиглогчдын бичвэрийн сэдэв бөгөөд судалбал зохих хамгийн чухал зүйл бол Есүс Христ мөн!

Хуучин Гэрээнээс Есүс Христийн тухай үнэнүүдийг эрэлхийлэхдээ санаж байвал зохих хэдэн зарчмыг өгье.

1. Хүн төрөлхтөнд Бурханаас өгөгдөх бүх зүйл Есүс Христийг бэлгэддэг (2 Нифай 11:4-ийг үзнэ үү; Мосе 6:63-ыг үзнэ үү).
2. Бүх бошиглогч Есүс Христийн төлөөлөгч эсвэл бэлгэдлүүд юм (Bruce R. McConkie, *The Promised Messiah* [1978], 451-ийг үзнэ үү).
3. Наманчлал төлөөлөгчдөөр нь дамжуулан Есүс Христийн талаар суралцах үүд хаалгыг нээдэг (Алма 26:21–22-ыг үзнэ үү).

БИ БОЛ . . . ТА НАРЫН ТӨЛӨӨ НЯДЛАГДСАН ХОНЬ

Амьтны золиослол болон арьсан дээл

Адам, Ева хоёрыг Едений цэцэрлэгээс хөөхөөс өмнө Их Эзэн тэдэнд зориулан арьсан дээл хийж өгч, өмсгөжээ. Хуучин Гэрээн дээр *цагаатгал* гэдэг үг янз бүрийн хэлбэрээр 81 удаа гардаг. 73 тохиолдолд эх хувилбар нь шууд утгаараа "далдлах" гэсэн санаа бүхий *кафар* гэсэн еврей үг юм.

Адам, Ева хоёрыг цэцэрлэгээс хөөгдсөний дараа мал сүргийнхээ ууган төлүүдийг Их Эзэнд өргөхийг зарлиглажээ. Тэнгэр элч хожим нь энэ үйлийг "Эцэгийн Төрсөн Ганцын золиослолтой төстэй" (Мосе 5:7) болохыг заасан.

Амьтны золиослолыг санваарын ёслолуудад оролцож байгаа тэдгээрийн зан үйлтэй хамт Мосегийн хуулийн доор үргэлжлүүлэн хийж байв.

Биднийг Их Эзэнтэй гэрээ байгуулж, ёслолуудыг нь хүлээн авахад Түүний Цагаатгал биднийг хамгаалдаг бөгөөд ингэснээр бид Адамын уналтын бүрэн нөлөөнд өртөхөө больдог. Есүс Христ бол биднийг нүгэл хийгээд үхлийн нөлөөнд дахин хэзээ ч оруулахгүйн тулд бидний өмнөөс золиослогдсон жинхэнэ Бурханы Хурга юм.

Эхлэл 3:21; 37:3; Египетээс гарсан нь 40:14–15; Езекиел 16:1–12; Матай 22:11–12; Галат 3:26–29; 1 Нифай 11:21, 32–33; Алма 34:14–16; Мосе 5:5–8; 7:47

БИ БОЛ . . . АМИЙН ТАЛХ

Манна

Мосе болон Израилийн хүүхдүүд Египетээс амлагдсан нутгийн зүг аялж байхдаа өдөр тутмынхаа талхны төлөө Их Эзэний ивээл хишигт найдаж байв. Их Эзэн тэдэнд хүмүүсийн нэрлэснээр "Манна" (орчуулбал "Энэ юу вэ?" гэгдэх) "тэнгэрийн амтат талх" өгөв. Өдөр бүр талхаа цуглуулан, Их Эзэн болон Түүний бошиглогчид итгэлтэй хэвээр үлдсэн тэр хүмүүс аглаг буйд дахь аяллынхаа турш амь хүртэж байсан билээ.

Есүс Христ бол амийн талх юм. Тэрээр мөнх бус амьдрал дахь аяллын өдөр бүр бидэнд амь хүртээхээр тэнгэрээс дэлхий дээр бууж ирсэн. Бид Түүний үгсийг өдөр бүр цуглуулснаар мөнх бус амьдрал дахь аяллынхаа туршид Түүгээр дамжуулан хүртэж болох амт, тамир тэнхээг мэдрэх боломжтой.

Египетээс гарсан нь 16:4, 12–21, 31; Дэд хууль 8:2–3; Иохан 6:26–35, 48–58, 66–68; 3 Нифай 20:8

БИ БОЛ . . . АМЬД УСНЫ ЭХ УНДАРГА

Хоребын хаднаас гарсан ус

Израилийн хүүхдүүдийг цөлд цангах үед Мосе Их Эзэнд хандав. Мосед Хоребын (Синай уул) тодорхой нэг хадан дээр Их Эзэний өгсөн таягаар цохихыг зааварласан. Түүнийг цохиход хаднаас ус олгойдон гарч, аялж явсан мянга мянган израильчуудын амийг тэтгэсэн билээ.

Есүс Христ бол Израилийн хад юм. Калваригийн толгод дээр түүнийг ташуурдахад Түүний биенээс цус шүүрэн гарсан. Христийн цус бидэнд амь авчирдаг. Бид Есүс Христээс амийн усыг авчрах түлхүүрүүдийг атгадаг бошиглогчдыг дагаснаар Түүний цагаатгагч цусанд байх амиас хүртэх боломжтой.

Египетээс гарсан нь 17:1–6; Тооллого 20:8, 11; Иохан 4:10–15; 1 Коринт 10:1–4; С ба Г 28:2

БИ БОЛ . . . ТА НАРЫН ЭДГЭЭГЧ

Шургаагны оройд өлгөгдсөн могой

Аяллын явцад тохиолдсон зовлон бэрхшээлийнхээ улмаас Израилийн хүүхдүүд бошиглогч болон Их Эзэний эсрэг гомдоллож, үглэх болов. Үүнээс болж Их Эзэн олныг нь үхэлд хүргэсэн хорт могойнуудад тэднийг хатгахыг зөвшөөрчээ. Мосе Их Эзэнд хандан могойнуудыг авахыг хүсэн залбирсан боловч оронд нь хүмүүс хазуулсан ч үхлээс хэлтэрч болох тийм арга замыг Их Эзэн өгсөн юм. Эдгээгдэхийн тулд тэдний хийх ёстой үйлдэл зөвхөн шургаагны оройд өлгөгдсөн могойг харах явдал байв.

Биднийг зовлон зүдгүүртээ ялагдалгүй, Есүс Христ рүү харуулахын тулд Тэрээр шургааг буюу загалмай—дээр хадагдсан билээ. Есүс Христ бидний сорилтыг үргэлж аваад байдаггүй, харин Эдгээгчийн хувьд Цагаатгалынхаа адислалуудаар дамжуулан хорыг нь авч чадна.

Тооллого 21:4–9; Иохан 3:14–16; 1 Петр 2:24; Алма 33:18–22; Хиламан 8:14–15; 3 Нифай 27:13–15

Ганц улаан чийдэнгийн шил

Лори Риэс

Христийн мэндэлсний баярын модны энгийн нэгэн чимэглэл надад Христийн мэндэлсний баярын жинхэнэ утга учрыг сануулсан билээ.

Христийн мэндэлсний баяр Христийн мэндэлсний баяр шиг санагдахгүй байв. Хэдийгээр би Христийн мэндэлсний баярын дууг дуулан, хөгжилтэй байх гэж оролдсон ч юм хадгалдаг хайрцгуудаа гунигтайгаар гаргаж ирлээ. Цасан хүний хэлбэртэй жигнэмгийн сав надад хамтдаа хайрч жигнэх хүн байхгүй гэдгийг сануулав. Сантагийн баримал оймснуудаа өлгөх шалтгаан байхгүйг мөн гаатай чихрийн, судалтай, бэлэг боодог цаас тэр өглөө хүүхдүүдийн хөөрөлдөн хөгжилдөх дуу сонсогдохгүй гэдгийг сануулж байлаа.

Энэ жил манай хамгийн бага хүүхэд коллежид явж, гэр маань эзгүйрч, нам жим санагдах болсон юм. Би зөвхөн Сантагаас өөр төрлийн чимэглэлүүдийг сонгоод, бусдыг нь хайрцганд эргүүлэн хийв.

Нөхөр маань гадагшаа ажлаар явсан тул би модоо ганцаараа чимэглэлээ. Бэр минь ач хүүхдүүдийн маань модоо чимэглэж байгаа зургийг нийтийн сүлжээнд тавихад надад өнгөрсөн цаг үе рүүгээ буцаж очмоор санагдав. Би цаг хугацаа ямар хурдан өнгөрөн одсоныг гайхаж байлаа. Хүүхдүүд маань ямар хурдан том болцгоогоо вэ? Би бодолд автсаар, гартаа барьсан чийдэнгийн шил рүүгээ доош харлаа. Энэ нь ганц улаан чийдэнгийн шил байв.

Өнгийг нь сайтар харвал гүн улаан өнгөтэй байлаа. Улаан хүрэн өнгө. Би үлдсэн чимэглэлүүдийг тойруулан харлаа. Христийн төрөлтийг харуулсан цөөн хэдэн баримал, мөсөн мөхөөлдөсний савхаар хийсэн тэвш, алтан үсгээр НОЕЛ гэж бичсэн чимэглэл л байв. Нүдэнд маань нулимс цийлэгнээд ирэв. Чийдэнгийн шил Аврагчийн цагаатгагч цусны улаан өнгө шиг улаан байлаа.

Би чимэглэл, төрөл бүрийн хэлбэртэй жигнэмэг, Христийн мэндэлсний баярын өглөө баярлан хөөрөх хүүхдүүдийг Христийн мэндэлсний баяр гэж боддог байснаа санав. Дараа нь би хүүхдүүдээ мөн тэдний мөнхийн гэр бүлүүдийн талаар бодлоо. Би гэр бүлтэйгээ ямар их баяр баясгаланг мэдэрснээ мөн хүүхдүүд маань өөр өөрсдийн гэр бүлтэйгээ ямар их хөөр баярыг мэдэрсэн тухай бодов. Би мөн тэвшинд хэвтэх хүү үүнийг хэрхэн боломжтой болгосон талаар эргэцүүлэн бодлоо. Аврагчийн бэлэг зөвхөн надад биш, харин бүх хүн төрөлхтөнд зориулагдсаныг тунгаан бодоход зүрх сэтгэлд минь халуун дулаан сайхан мэдрэмж төрөв.

"Тэнгэр элч тэдэнд—Бүү айгтун, харагтун, би *бүх ард түмнийг* үлэмж баярлуулах сайн мэдээг та нарт авчирлаа" гэсэн (Лук 2:10; тодотгол нэмэгдсэн).

Би модоо үргэлжлүүлэн чимж байхдаа Есүс Христийн даруухан төрөлт хийгээд амьдралын тухай тунгаан бодсон юм. Тэрээр шархадсаныг эдгээж, дарамтлагдсаныг босгож, ганцаардсаныг тайтгаруулж, төгс бус хүмүүст амар амгаланг авчирч, зовж зүдэрснийг энэрч хайрлахаар ирсэн. Бидэнд Эцэгийнхээ хаант улсад Эцэгтэйгээ дахин амьдрах боломж олгохын тулд Тэрээр төрж, бас амиа өгсөн юм. Тэрээр хүмүүнд жинхэнэ аз жаргалыг амсуулж болохын тулд ирсэн. Христ бол Христийн мэндэлсний баярын утга учир тул би Христэд баяр баясгаланг олж, сэтгэл уужирч билээ. ■

Зохиогч нь АНУ-ын Орегон мужид амьдардаг.

GETTY IMAGES-ИЙН ГЭРЭЛ ЗУРАГ

Үйлчлэлээс ирэх өсөлт хөгжил

По Ниэн (Филиппин) Чоу, Петра Чоу нар

Салбарынхаа шинэ гишүүдэд үйлчлэлээр дамжуулан өсөж хөгжих боломж олгохын тулд дуудлага хурдан өгөх ёстой гэсэн мэдрэмж бидэнд төрөв.

Каошунын 7-р салбар 2001 оны 12-р сард Тайванийн Тайпей ариун сүм дээр байгаа нь.

2000 онд бид Тайванийн Каошун гадасны хамгийн жижигхэн нэгжид салбарын ерөнхийлөгч болон Хүүхдийн хэсгийн ерөнхийлөгчөөр үйлчлэхээр тус тус дуудагдав. Ариун ёслолын цуглаанд манай гэр бүл, дөрвөн идэвхтэй ахлагч болон номлогчдыг оролцуулаад ойролцоогоор 20 хүн ирдэг байлаа. Бид хожим нь Их Эзэн салбарыг маань дүүргэх болно гэсэн найдлага тээн хоёр ахлагчийг номлолд явуулав.

Бид салбарынхантайгаа ажиллаж байхдаа ерөнхийлөгч Гордон Б.Хинклигийн (1910–2008) хөрвөгч бүр "найз нөхөр, дуудлагат ажил, мөн 'Бурханы сайн үгээр тэжээгдэж байх'"[1] хэрэгтэй хэмээн хэлсэн зөвлөгөөг саналаа. Шинэ гишүүдэд үйлчлэлээр дамжуулан өсөж хөгжих боломж олгохын тулд дуудлага хурдан өгөх ёстой гэсэн мэдрэмж бидэнд төрөв. Номлогчид сонирхогч бүртэйгээ биднийг танилцуулж, баптисм хүртсэнээс нь хойш хоёр долоо хоногийн дотор тэдэнд дуудлага өгч байв. Тэд бусад гишүүнтэй хамт үйлчилж байхдаа найзалж нөхөрлөдөг байсан.

Шинээр баптисм хүртсэн ах бүр сарын дотор Аароны санваараа хүртэж, бүгд ариун ёслол адисалж, түгээдэг байлаа. Бид мөн тэднийг дараагийн гадасны чуулганаар Мелкизедек санваар авахад нь бэлтгэдэг байв.

Шинэ ахлагчдад ёслолуудыг хэрхэн хийж гүйцэтгэхийг зааж, харин дараа нь тэд шинэ ахлагчдадаа заадаг байлаа. Бид үйлдсэнээр суралцаж, зааснаар сурч мэдсэнээ хадгалж үлддэг гэдэгт итгэдэг. Салбарын гишүүд бие биендээ үлгэрлэн зөвлөж, зааж бас сургаж, мөн дэмжиж туслах үүрэгтэй байв.

Бид гэрийн болон айлчлагч багшлалт, гэр бүлийн үдэш, тойргийн үйл ажиллагаа, хамтдаа хоол идэх зэргийг ашиглан шинэ хөрвөгчидтэй нөхөрлөдөг байсан. Тэд ням гарагт болон ажлын өдрүүдэд шашны зааварчилгаагаар дамжуулан Бурханы сайн үгээр тэжээгддэг байв. Институт хоёр оюутнаас 25 болтлоо өссөн. Бяцхан салбараа тэтгэх зорилгоор бид Тайванийн Тайпей ариун сүмд сар бүр орж мөн үйлчлэхийн тулд автобусаар ирж очиход 10 цаг зарцуулдаг байв. Ихэвчлэн гадас маань ариун сүм явах хоёр дахь автобусаа дүүргэх гэж хичээдэг байж билээ. Салбар маань өсөж, гэр бүлүүд маань ариун сүмийн адислалаас хүртэхээр бэлдэж эхлэх үед бид өөрсдийн автобусыг дүүргэх зорилт тавьсан юм. Гадасны бусад гишүүн ариун сүмийн нэг автобусыг дүүргэж байхад манай жижиг салбар хоёр дахь автобусыг нь эхний жил хоёр удаа дүүргэв. Удалгүй тойрог бүрийг жилд ядаж нэг удаа ариун сүмийн автобусыг дүүргэхийг гадаснаас хүсэх болсон юм.

Хоёр дахь жилдээ хөрвөгчдийн сүмдээ идэвхтэй үлдэх үзүүлэлт 30 хувиас 90 гаруй хувь болтлоо өсөж, ариун ёслолын цуглаан маань 25 идэвхтэй ахлагчийг оролцуулан 100 орчим хүнтэй болтлоо өсөв. Салбар маань тойрог болж, хуучин байрыг маань засварлаж, шинэ цуглааны байр болгосон юм.

Хөрвөгч бүр найз нөхөдтэй болж, дуудлага авч, Бурханы сайн үгээр тэжээгдэж адислагдсан тул хамгийн жижигхэн салбар маань гадасныхаа хамгийн хүчтэй тойрог болсон билээ. ■

Зохиогчид нь АНУ-ын Ютад амьдардаг.

ЭШЛЭЛ

1. Gordon B. Hinckley, "Converts and Young Men," *Ensign,* May 1997, 47.

ГЭРЭЛ ЗҮРГИЙГ ЗОХИОГЧИЙН ЗӨВШӨӨРЛӨӨР НИЙТЛЭВ

Амт мэдрүүлсэн Христийн мэндэлсний баяр

Гэр бүл маань Христийн мэндэлсний баярыг дурсамжтай үйл явдал болгодог байсныг би ухаан орсон цагаасаа л санадаг. Би Бразилын Порто Алегре Өмнөд номлолд үйлчлэхээр явахдаа Христийн мэндэлсний баярыг анх удаа тэднээсээ хол өнгөрүүлэх нь надад ямар хэцүү байхыг ухаараагүй юм.

Номлолын талбар дахь анхны Христийн мэндэлсний баярын үеэр би гэр бүлийнхэнтэйгээ байхыг хүссэн ч хамтрагчтайгаа хоёулхнаа байв. Би өөрийгөө ихэд өрөвдөж, уйтгар гунигт автаж билээ.

Христийн мэндэлсний баярын өмнөх орой танил гэр бүл маань хамтрагч бид хоёрыг оройн хоолонд урив. Бид үдшийг сайхан өнгөрүүлсэн ч тэдний аз жаргал намайг гэр бүлээсээ хол байгааг маань сануулав. Тэр орой бид гэртээ харьсны дараа би унтаж, маргааш Христийн мэндэлсний баярын өдөр гэдгийг мартахыг хичээсэн юм. Би амьдралдаа анх удаа Христийн мэндэлсний баяр дуусанд сэтгэл уужирч билээ.

Жилийн дараа би өнгөрсөн жилийн Христийн мэндэлсний баяраа эргэн санаж, номлолын талбарт Христийн мэндэлсний баярыг илүү сайхан тэмдэглэхийн тулд юу хийж болох талаар бодов. Өнгөрсөн жилийн уйтгарт мэдрэмжүүд Аврагч дээр биш, өөр дээрээ төвлөрснөөс ирсэн болохыг би ухаарч, Христийн мэндэлсний баяр бол Аврагчийн төрөлтийг дурсан санах цаг мөч бөгөөд Түүний төлөөлөгчийн хувьд Түүнд үйлчилж байгаадаа баярлах ёстойгоо бас ойлгосон.

Номлолын талбартаа Христийн мэндэлсний баярыг илүү сайхан болгохын тулд хамтрагч бид хоёр Христийн мэндэлсний баярын өдөр таарсан хүн бүрд өгөхөөр иштэй чихэр авахаар шийдэв.

Хамтрагчтайгаа ярилцаад, бид гишүүд, сонирхогчид, хүүхдүүд болон Христийн мэндэлсний баярын өдөр таарсан хүн бүрд өгөхөөр иштэй чихэр авахаар шийдэв. Бид мөн Христийн мэндэлсний баярын дуулуудыг дуулахаар бэлтгэлээ. Христийн мэндэлсний баярын өдөр хүмүүстэй уулзаж, дуулал дуулж, иштэй чихэр тарааж явахдаа миний зүрх сэтгэл баяр хөөрөөр бялхсан.

Тэр оройдоо гэр рүүгээ явж байх замдаа бид явган хүний зам дээр сууж байгаа настай эрэгтэйтэй тааралдав. Бид түүнээс тэр өдөр Христийн мэндэлсний баярын бэлэг авсан эсэхийг лавлатал тэр тийм гэж хариулаад, хол амьдардаг хүүхдүүдтэйгээ утсаар ярьснаа хэлсэн.

"Танд өгөх бас нэгэн бэлэг бидэнд байна" гэж бид хэлээд, иштэй чихрээ түүнд өглөө.

"Энэ чихэр идэхэд амттай байгаад зогсохгүй, миний сүнсийг ч бас амттанаар дайлах болно" гэж тэр хэлэв.

Би номлолдоо байхдаа зөвхөн өөртөө анхаарсны улмаас хамгийн онцгүй Христийн мэндэлсний баярыг тэмдэглэсэн байлаа. Гэхдээ би бас тэнд байхдаа өөр дээрээ биш, Аврагч дээр анхаарлаа төвлөрүүлснээр хамгийн сайхан Христийн мэндэлсний баярыг өнгөрүүлсэн юм. Бид Түүнд анхаарлаа төвлөрүүлэхэд Тэрээр Христийн мэндэлсний баяраар мөн жилийн өдөр бүр бидний сүнсийг амттанаар дайлна гэдгийг би мэднэ. ■

Вилсон Коррэа дос Сантос, Бразилын Пернамбуку

ЗУРАГ ЧИМЭГЛЭЛИЙГ ЭНИА ТОДД

Надад түүнтэй уулзах хэрэгтэй гэсэн мэдрэмж төрөв. Би түүнд ойртон, гараа сунгаж, нэрийг нь асуув.

“Та нар Надад хийсэн хэрэг”

Манай гэр бүл Христийн мэндэлсний баяраар ууттай хоол хүнс, бээлий, малгай болон бусад хэрэгцээт зүйлийг тусламж хэрэгтэй хүмүүст өгдөг уламжлалтай. 2016 оны Христийн мэндэлсний баярын өмнөх орой бидний амьдардаг бүс нутаг болох АНУ-ын Калифорни мужид онцгой хүйтэн байв. Бид дулаан хувцсаа давхарлан өмссөн ч дагжин чичирч байлаа!

Бид гэрийнхээ ойролцоох орон гэргүй олон хүн байдаг цэцэрлэгт хүрээлэн рүү машинаараа явж байгаад, автобусны буудлын тарчиг саравчинд хуучин хөнжил нөмрөн атиралдан хэвтэх нэгэн эрийг харав. Миний нөхөр Дэннис машинаа зогсоон, хүү Жонатанаа дагуулан тэр эрэгтэйд ууттай бэлэг өгөхөөр явав. Би охин Аббитайгаа хамт машиндаа үлдээд, тэднийг харж байлаа.

Дэннис тэр эрэгтэйд ууттай зүйлээ өгөхөд тэрээр толгойгоо өндийлгөн, нүүр дүүрэн инээмсэглэв. Тэд гар барилцаад, ярилцаж эхлэв. Ер нь иймэрхүү үед хүмүүс хоорондоо яриа өрнүүлээд байдаггүй учраас энэ нь их хачирхалтай байлаа.

Хэдэн минутын дараа Дэннис машин руу эргэж ирээд, тээшний хэсгийг нээв.

“Бүх юм зүгээр үү?” гэж би асуулаа.

Тэр “Тийм ээ. Би түүнд малгайтай хүрмээ өгье гэж бодлоо. Энэ хүрэм надаас илүү түүнд хэрэгтэй” гэв.

Би юу хэлэхээ мэдэхгүй байв. Уг хүрэм үнэхээр сайхан хүрэм байсан бөгөөд Дэннис хэдхэн удаа өмссөн байсан гээч! Дэннис тэр эрэгтэй рүү буцаж очоод, түүнд дулаан хүрэм өмсөхөд нь тусаллаа. Тэр эрэгтэйн царай гэрэлтэж байв. Дэннис тэр эрэгтэйтэй үргэлжлүүлэн ярилцсаар байв.

Түүнтэй уулзах хэрэгтэй гэсэн мэдрэмж төрсөн тул би машиныхаа хаалгыг онгойлгон буув. Абби ч гэсэн намайг дагалаа. Биднийг дөхөж очиход Дэннис инээмсэглээд, тэр эрд биднийг танилцуулав. Би гараа сунгаж, түүний нэрийг асуухад тэр миний гарыг атгаад, дотно инээмсэглэн, “Есүс” гэж хариулав.

Гэр бүлийнхэн маань яриагаа цааш үргэлжлүүлсэн ч би юу ярьсныг нь бараг сонссонгүй. Би тэр нөхөрсөг эрийн Есүс хэмээх нэрийг буюу Аврагчийнхаа нэрийн ач холбогдлын талаар бодсоор байв. Яг тэр мөчид Аврагчийн заасан “Та нар эдгээр ах дүүсийн маань нэгэнд нь, тэр байтугай хамгийн дордод нь тийнхүү хандсан бол Надад хийсэн хэрэг” (Матай 25: 40) гэх үгс санаанд минь орж ирж билээ. Энэ үйл явдал намайг үүрд өөрчилсөн юм. ■

Шаннон Найт, АНУ-ын Калифорни

ЗУРАГ ЧИМЭГТЭЛИЙГ АЛЛЕН ГАРНС

Би таягаа бэлгийн цаасаар ороогоод, надад санваарын адислал өгсөн тэр ахад Христийн мэндэлсний баярын бэлэг болгон өгөв.

ЗУРАГ ЧИМЭГЛЭЛИЙГ КЭРОЛИН ВИББЭРТ

Бид хоёр хоёулаа адислагдсан

Ачааны тэрэг намайг унадаг дугуйтай явж байхад мөргөж унагааснаас болж би хараагаа хэсэгчлэн алдсан юм. Дөрвөн жил орчмын дараа, 2011 оны Христийн мэндэлсний баярын үеэр би өмнөх тойргийнхоо нэгэн ахаас санваарын адислал өгөхийг хүсэх өдөөлтийг мэдрэв. Би тэр ахыг хааяа л хардаг байсан тул яагаад түүнээс асуух ёстойгоо ойлгохгүй л байлаа. Түүний оронд асууж болох өөр зохистой санваартнууд байгаа гэдгийг би мэдэж байв.

Дараагийн хэдэн долоо хоног өнгөрч, надад адислал хэрэгтэй гэсэн мэдрэмж маань улам нэмэгдэв. Би Германы Франкфурт ариун сүмийн ажилтнаар үйлчилж байсан учраас тэнд байдаг ах нарын нэгээс адислал өгөхийг хүсэхээр шийдэв.

Яг энэ шийдвэрийг гаргасны дараа, адислал өгөхийг хүсэх хэрэгтэй гэсэн мэдрэмж төрсөн ах ариун сүмд орж ирлээ. Би тэр даруй энэ бол тохиолдлын зүйл биш буюу Тэнгэрлэг Эцэг намайг яг энэ ахаас асуугаасай гэж хүсэж байгаа гэдгийг ойлгоод, түүнтэй цуглааных нь дараа уулзаж болох эсэхийг зориг гарган асуув. Тэр зөвшөөрлөө.

Дараа нь би яагаад гэдгийг нь мэдэхгүй ч өөрөөс нь адислал авах хэрэгтэй гэсэн мэдрэмж төрснөө түүнд тайлбарлан хэлэв. Тэр туслахдаа баяртай байгаагаа хэллээ. Тэрээр өрөөнд өөр нэгэн ахыг урьж оруулаад, надад адислал өгч эхлэв. Түүнийг адислалаа өгч дуусахад надад эргэлзэх сэтгэл төрөв. Адислал сайхан байсан ч ямар нэгэн онцгой зүйл байсангүй.

Тэгээд би нүдээ нээлээ.

Нүдээ нээхэд өрөө надад бүхэлдээ маш тод харагдав. Би итгэж чадахгүй байлаа! Би тэр ахаас яагаад надад адислал өгөх хэрэгтэй хүн маань байсныг мэдэх эсэхийг асуухад түүний өгсөн хариулт намайг даруусгасан юм.

Тэрээр "Энэ адислал зөвхөн танд зориулагдсан гэж би бодохгүй байна. Энэ нь надад ч бас зориулагдсан байсан. Зээ дүү минь маргааш баптисм хүртэхэд би түүнд адислал өгөх гэж байгаа. Гэрийнхэн маань Сүмд идэвхгүй бөгөөд зээ дүү минь сүүлийн 20 жилд баптисм хүртэж буй гэр бүлийн маань анхны гишүүн байгаа юм л даа. Гэрийнхнээс маань олон хүн түүний баптисмд оролцоно. Би тэрхүү адислалыг өгөх хэмжээний хүчтэй итгэлтэй эсэхдээ эргэлзэж байсан юм. Одоо би хийж чадна гэдгээ мэдлээ" гэж хариулав.

Дараагийн өдрүүдэд миний хараа сайжирч, цагаан таяг минь хэрэггүй боллоо. Би таягаа бэлгийн цаасаар ороогоод, "Энэ Мосегийн таяг биш л дээ. Гэхдээ энэ таяг танд байгаа санваарын хүчийг сануулна гэдэгт би найдаж байна" гэж бичсэн захидлын хамт тэр ахад Христийн мэндэлсний баярын бэлэг болгон өгсөн юм.

Тэнгэрлэг Эцэг бидэнд хайртай бөгөөд биднийг адислахдаа баяртай байдаг. Христийн мэндэлсний баяраар авсан энэ адислал хараг минь сэргээхийн зэрэгцээ нэгэн даруухан санваартанд санваарын үйлчлэлдээ итгэх итгэлийг өгсөн билээ. ■

Анна Фингөрл, Германы Хэссэ

Мормоны Ном: Онцгой бэлэг

Би нөхөртэйгөө хамт Филиппинийн Манила ариун сүмийн номлогчоор үйлчилж байхдаа 2016 оны Христийн мэндэлсний баярын өмнөх орой хэн нэгэнд Мормоны Ном өгөхийг хүсэв. Би уг номын хавтасны дотор талд гэрчлэлээ бичээд, дотор нь Сүмийн талаар хаанаас илүү ихийг олж мэдэх тухай мэдээллийг оруулсан Манила ариун сүмийн ил захидлыг хийв. Тэгээд би өвдөг сөгдөн залбирч, Их Эзэнээс Өөрийн бэлтгэсэн хэн нэгэн рүү намайг хөтлөн аваачихыг гуйв.

Би байрнаасаа гараад, гудамж хөндлөн гарав. Ойролцоох номлогчдыг бэлтгэх төвийн харуул хоёр эрэгтэйтэй ярьж байлаа. Түүнийг "Христийн мэндэлсний баярын мэнд хүргэе!" гэж чанга хэлэхэд надад тэдэнтэй уулзах ёстой мэт мэдрэмж төрж, би тэдний зүг явлаа.

Намайг өөрийгөө танилцуулсны дараа тэр хоёр эрэгтэйн нэг нь номлогчдыг бэлтгэх төвийн цэцэрлэгч, нөгөө нь фермер болохыг би олж мэдэв. Тэд хоёулаа Сүмийн гишүүн байв.

Би тэднээс Мормоны Номыг Христийн мэндэлсний баярын бэлэг болгон авахыг сонирхож байж болох хэн нэгнийг мэдэх эсэхийг асуув. Фермер гайхсан байдалтай хараад, хэдхэн минутын дараа түүнтэй уулзахаар найз нь ариун сүмийн талбайд ирнэ гэдгийг хэлэв. Тэр найздаа Мормоны Ном өгөхийг хүссэн ч түүнд олдохгүй байжээ. Би ч сэтгэл хөдлөн Мормоны Номыг цүнхнээсээ гаргаж ирээд, тэдэнд залбирлынхаа талаар хэлж, фермерт номоо өгөв.

Бид бүгд Сүнсийг мэдэрсэн бөгөөд найз нь Мормоны Номыг уншиж, сайн мэдээг хүлээн авна гэдэгт найдаж байгаагаа фермер илэрхийллээ. Би байр руугаа буцаж явах замдаа Их Эзэнд талархаж, фермерийн найз нь ариун сүмийн талбайд ирнэ гэсэн амлалтаа биелүүлээсэй гэж залбирав.

Ойролцоогоор 15 минутын дараа би НБТ-ийн харуулын үүднээс дуудлага хүлээн авав. Фермерийн найз иржээ. Би түүнтэй уулзахаар тэр даруй явлаа. Тэр худалдааны онгоцны ахмад байсан бөгөөд хоёр хоногийн дараа далайд эргэн гарах гэж байгаа аж. Тэрээр Мормоны Ном өгсөнд надад талархаад, номыг онгоцондоо авч явна гэдгээ хэллээ. Би салах ёс хийхийнхээ өмнө түүний нүд рүү хараад, "Энэ ном үнэн" гэж хэлэв. Ийн хэлэхэд Сүнс надад үнэн болохыг баталж өгсөн юм.

Тухайн Христийн мэндэлсний баяраар би Мормоны Номыг уг ном үнэн гэсэн гэрчлэлийн хамт онцгой бэлэг болгон өгсөн билээ. Би ч бас онцгой бэлэг хүлээн авсан. Энэ нь Их Эзэн залбиралд минь хариулж, сайн мэдээг хуваалцах боломжоор намайг адисалсан явдал байсан юм. ■

Клодэт Байби Бөрт, АНУ-ын Вашингтон

Уг ахмад Мормоны Ном өгсөнд надад талархаад, номыг онгоцондоо авч явна гэдгээ хэллээ.

ЗУРАГ ЧИМЭГЛЭЛИЙГ ЭВА ВАСКУЭЗ

Залуу эрэгтэйчүүдийн ерөнхий ерөнхийлөгчиийн зөвлөлийн хоёрдугаар зөвлөх
М.Жозэф Браф

Том шийдвэрүүдийн дундах намуухан зөөлөн *дуу хоолой*

Хэрвээ та зохистой байх юм бол Тэнгэрлэг Эцэг том алдаа хийхээс тань өмнө сэрэмжлүүлэх болно.

2011 оны намар номлолын шинэ ерөнхийлөгчийн хувьд номлогчдын дунд байх гэж байгаадаа сэтгэл минь ихэд хөдөлж байлаа. Би эхнэр Эмилитэйгээ хамт байруудыг шалгахын зэрэгцээ номлол дахь номлолын хамтрагч бүр дээр зочлохоор шийдсэн юм.

Гватемала хотоос Золола гэгддэг хамгийн алслагдмал бүсүүдийн нэг рүү явж байхдаа бидний өмнөх замыг жагсаал хааж байгааг олж мэдэв. Гватемалад болдог жагсаалууд хэдэн цагаар үргэлжилдэг учраас дундуур нь өнгөрч гарах бараг боломжгүй байдаг байв. Харин бид тойрч гарах зам байгаа эсэхийг асуухад өөр нэг зам байдгийг олж мэдсэн юм. Гэхдээ тэр замын талаар зарим зүйлийг сэрэмжлүүлэв. Үүнд:

- Энэ бол сайн зам биш.
- Харанхуй болсны дараа энэ замаар явж болохгүй.
- Замаар нь дээрэмчдийн бүлэг тогтмол явдаг.

Номлолын ямар ч шинэ, идэвхтэй ерөнхийлөгч мөн түүний гэргийн адил Эмили бид хоёр явахаар болов. Хэсэг явсны дараа бидний өмнө огцом доош унаж байгаа хавцал адил шороон зам гарч ирэхийг харав. Эмили ирмэгээр нь явангаа зургийн аппаратаа гаргаж ирээд, зураг авах хэрэгтэй юм байна даа хэмээн хошигнож байлаа.

Олон жилийн өмнө, би Гватемалад залуу номлогч байхдаа жижигхэн мөчир зам дээр тавьсан байвал "сэрэмжтэй яваарай," бүр "зогс" ч гэсэн утгатай байж болно гэдгийг сурсан байсан. Би мөчир байхыг харсан ч утга нь санаанд орж ирсэнгүй.

Хормын дараа бид гүүр нь урсчихсан 6 метрийн өндөр ирмэгээс зүүгдэж байлаа. Би өөрийнхөө талаас гарч чадсан ч Эмили хаалгаа онгойлгож чадахгүй байв. Тэр суудал даваад миний талын хаалгаар гарч ирэх гэж оролдоход машин дайвалзаж эхлэв. Мэдээж, энэ нь биднийг маш их сандаргаж байлаа.

GETTY IMAGES-ИЙН ЗУРАГ

Толгойд олон бодол эргэлдэж байв. Надад бүр “Номлолын шинэ ерөнхийлөгч гүүргүй далан дээгүүр машинаа жолоодож явснаас болж эхнэр нь хүнд гэмтжээ” юм уу “Номлолын шинэ ерөнхийлөгч эхнэртэйгээ явах ёсгүй замаар явж байгаад, дээрэмдүүлсний дараа алга болжээ” гэсэн сонингийн гарчгууд хүртэл харагдав.

Юу хийхээ мэдэхгүй машиныхаа гадна түр зогсож байхдаа би “Болгоомжгүй байдлаасаа болж орсон энэ асуудлаас гарахад минь туслаач” гэж Тэнгэрлэг Эцэгээсээ гуйлаа. Гадил жимс зөөдөг ачааны том машин бидний ард гэнэт гараад ирсэн гэдэгт та итгэх үү? Жолооч болон зорчигчид нь биднийг хараад, бодлогогүй гадаадынхныг дооглож, инээлдэхээр бууж ирэв. Тэд зам дээр байгаа мөчрийг зааллаа. Үнэндээ зүгээр л нэг бургасан саваа байв.

Дараа нь тэд биднийг гайхалтайгаар адислан, Гватемалад гурван жил үйлчлэхдээ харсан цорын ганц гинжийг ачааныхаа машинаас гаргаж ирэх нь тэр. Тэд явахаасаа өмнө мод огтлоод зам хөндлөн тавьж

билээ. Хойд Америкаас ирсэн дараагийн хүн минийхтэй адил алдаа битгий гаргаасай гэсэндээ тэд ийнхүү хийсэн гэж надад бодогдсон.

Өдөөлт, сэрэмжлүүлгүүдийг анхааралтай сонс

Их Эзэний дуу хоолой хэр хүчтэй эсвэл сул байгаа гэдгээс үл хамааран Түүний өгсөн сэрэмжлүүлэг, өдөөлт, зааварчилгааг анхааралтай сонсох хэрэгтэй гэдгийг ойлгуулах нэгэн түүхийг би та нарт ярьж өгье. Тэр дуу хоолой судар, зарлиг, амьд бошиглогчдын үгс мөн эцэг эх, Сүмийн удирдагчид болон найз нөхдөөс ирэх зөвлөгөө гэх мэт олон хэлбэрээр ирдэг. Бид эдгээр өдөөлт, сэрэмжлүүлгийг сонсож, анхаарлаа хандуулдаг уу? Ингэх нь яагаад чухал вэ?

Бид Сургаалт үгс номноос:

"Бүх зүрхээрээ ЭЗЭНд итгэ. Өөрийн ойлголтод бүү түшиглэ.

Өөрийн бүх замаараа Түүнийг таньж мэд. Тэр чиний замыг шулуун болгоно.

Өөрийнхөө нүдний өмнө бүү мэргэн бай. ЭЗЭНээс эмээж, хорон муугаас эргэ" (Сургаалт үгс 3:5–7) гэж уншдаг.

Бид Их Эзэнд бүхий л зүрх сэтгэлээрээ найдах ёстой. Бусдад юу хамгийн сайн болох тухай бидний мэдлэг хангалтгүй гэдгийг бид ойлгох ёстой. Хэрэв бид Түүнд найдвал "Тэр чиний замыг шулуун болгоно" гэсэн нь ямар гайхамшигтай амлалт байна гээч.

Манай гэр бүлийнхний хэрэглэдэг нэг үг номлолын маань чухал хэсэг болсон юм. Ерөнхийлөгч Рассэлл М.Нэлсон энэ ойлголтыг заагаад, хэсэг хугацаа өнгөрч байгаа. Тэр үүнийг дараах байдлаар хэлсэн. "Дуулгавартай байдал амжилтыг авчирдаг; яг таг дуулгавартай байдал гайхамшгийг авчирдаг."[1]

Манай гэр бүлийн болон номлолын маань хувилбар бол "Дуулгавартай байдал адислалуудыг авчирдаг; харин яг таг дуулгавартай байх нь гайхамшгийг авчирдаг."

Яг таг дуулгавартай байна гэдэг нь юу гэсэн үг болохыг би бүрэн ойлгодоггүй ч ингэж ойлгодог. Энэ нь яг одоо бид бүх зүйлд төгс дуулгавартай байна гэсэн үг биш ч Их Эзэний олон зарлигийг дуулгавартай дагаснаар төгс байж чадна. Тиймээс наманчлал нь яг таг дуулгавартай байхын гол хэсэг юм. Яг таг дуулгавартай байдал нь Тэнгэрлэг Эцэгээс бидэнд өгдөг бүх сэрэмжлүүлэг, өдөөлт хийгээд зарлигийг дагах амлалтыг шаардаг.

Заримдаа Тэнгэрлэг Эцэг маань биднээс яагаад зарим зүйлийг хийхийг хүсдэгийг бид ойлгодоггүй. Энэ нь яг таг дуулгавартай байхад хамгийн хэцүү үеүдийн нэг юм. Бүхнээс агуу нэгэн болох Адамаас яагаад өргөл өгч байгааг асуудаг. "Мөн олон өдрийн дараа Их Эзэний тэнгэр элч Адам дээр хүрч ирэн хэлэв: Чи яагаад Их Эзэнд тахил өргөх болов? Мөн Адам түүнд хэлэв: Их Эзэн зарлигласнаас өөрийг би мэдэх нь үгүй" (Мосе 5:6) хэмээн хэлснийг сана.

Бошиглогчдыг дага

Эмили хэдийгээр ойлгодоггүй байсан ч яг таг дуулгавартай байхын гайхамшигт жишээ болсоор ирсэн. 2000 оны 10-р сарын Ерөнхий чуулганы үеэр тэр ерөнхийлөгч Гордон Б.Хинклигийн (1910–2008) "Бид шивээс хийлгэх болон 'эрүүл мэндийн зорилгоос өөрөөр биеийн эрхтнээ цоолохыг' дэмжихгүй. Гэхдээ бид 'эмэгтэйчүүдийг зөвхөн нэг хос ээмэг зүүхийн тулд чихээ хамгийн цөөн цоолох' талаар ямар нэгэн байр суурийг илэрхийлдэггүй"[2] гэсэн зөвлөгөөг сонсжээ.

Эхнэр маань гэртээ ирээд, манай хоёр дахь охинд юу ч болж байсан бошиглогчийн үгсийг

Сэдэв улирлаач, симон дуваей, хүмүүсийн дүр төрх, эйнрих хофманн



дагахын ач холбогдлыг тайлбарлав. Ярихынхаа хажуугаар эхнэр маань бас дуулгавартай дагасан юм. Тэр хоёр дахь хос ээмгээ сүүлийнх болгон, тайлж билээ. Одоо ч гэсэн яагаад гэдгийг нь ойлгоогүй гэдэгт би итгэлтэй байгаа ч түүний хувьд яагаад гэдэг нь хамаагүй.

Бидний заримын хувьд энэ нь өчүүхэн зүйл тул чухал биш гэж боддог байж болох юм. Энэ бол үнэн. Хэдий тийм ч би Аврагч "Хэрэв та нар намайг хайрладаг бол, чухал гэж санагдаж байгаа тушаалуудаа сахь" (Иохан 14:15-ыг үзнэ үү) гэж хэлснийг санахгүй байна.

Хүндэт ах, эгч нар аа, бидний ямар ч үед чих тавин сонсож байх ёстой тод томруун сэрэмжлүүлгийн дуу хоолой Их Эзэний сонгосон төлөөлөгчид болон бошиглогчдоос ирдэг. Энэ нь ерөнхийлөгч Хинклигийн хүссэн жижигхэн зүйлтэй адил дэлхийн жишгийн хувьд түгээмэл зүйл биш байж болно. Гэхдээ та нар үүнийг Тэнгэрлэг Эцэгээс ирсэн гэдэгт найдаж чадна, найдах ч ёстой. Энэ нь зөвхөн нэг жижиг бургасны мөчир, эсвэл зам хөндлөн тагласан бүхэл бүтэн мод ч байж болно. Би та нарыг дараах бодлыг оюун санаандаа тээн, Ерөнхий чуулганы үгсийг уншиж, сонсохыг уриалж байна. Их Эзэн миний зам дээр ямар бургасны мөчир эсвэл мод тавьсан байна вэ?

Их Эзэнд итгэх итгэл

Та нарын зарим нь "За, тийм байж. Гэхдээ та нарт Их Эзэнээс сүнслэг өдөөлт, зөвлөгөө, сэрэмжлүүлэг, удирдамж эрэлхийлсээр байхад хариулт авахгүй байх тохиолдолд яах вэ?" гэсэн бодол төрж байж болох юм.

Магадгүй амьдралын чухал шийдвэрүүдийг гаргахад тань ийм асуудал тулгарсан байж болно. Бүх зүрхээрээ Эзэнд итгэ, Тэр чиний замыг шулуун болгоно гэсэн амлалтыг санаарай.

Бид амьдралынхаа чухал үйл явдлуудын талаар тодорхой удирдамж авахыг хүсэж байгаа ч үүнийг олж авахад хэцүү байж болно. Гэхдээ би наманчилж, яг таг дуулгавартай байж, удирдагчдаа даган, өөр сайн сонголтуудыг хийдэг бол; өөрөөр хэлбэл, хэрэв би зохистой байх юм бол Тэнгэрлэг Эцэг том алдаа хийхээс минь өмнө сэрэмжлүүлэг өгнө гэдгийг ухаарсан. Тэр танд алдаа хийх боломж ч олгохгүй.

Залуу найзууд минь ээ, хэрэв бид Тэнгэрлэг Эцэгийн сэрэмжлүүлэг, сүнслэг өдөөлт, илчлэлтүүдийг бүхий л боломжит эх сурвалжаас эрэлхийлж мөн сонсож, тэдгээрийн дагуу үйлдэх юм бол Тэр энд биднийг асар том алдаа гаргахаас хамгаална. Бид Ариун Сүнсийг өөрсөдтэйгөө үргэлж, ялангуяа амьдралынхаа чухал цаг мөчүүдэд хамт байлгах эрхтэй.

Тэгснээр та Тэнгэрлэг Эцэгийн зам дээр тань сэрэмжлүүлэн байрлуулсан бургасны мөчир болон модыг амжилттай тодорхойлж чадна гэдэгт би итгэж байна.

Их Эзэний дуу хоолойг анхааралтай сонсож, үүнийг аль болох олон эх сурвалжаас хүлээн авч, яг таг дуулгавартай байхыг хичээх юм бол бид эцэст нь "амар сайхандаа жаргажээ" гэж хэлэхүйц амьдарна гэдгийг би гэрчилж байна. Зөвхөн Христийн сургаалын дагуу амьдарч, ариун нандин гэрээнүүдийг байгуулж, сахиж байж л ийм амьдралтай байх боломжтой. ■

2017 оны 10-р сарын 17-нд Айдахо дахь Бригам Янгийн Их Сургуулийн онцгой цугларалт дээр хэлсэн "Heeding the Voice of the Lord" үгээс авав.

ЭШЛЭЛҮҮД

1. Russell M. Nelson, in R. Scott Lloyd, "Elder Nelson Delivers Spiritual Thanksgiving Feast to MTCs," Church News section of LDS.org, Dec. 4, 2013, news.lds.org.
2. Gordon B. Hinckley, "Great Shall Be the Peace of Thy Children," *Liahona,* Jan. 2001, 68.

НЭГДМЭЛ БАЙ



Санваарын тухай 1978 оны илчлэлтийн 40 жилийн ойн "Нэгдмэл бай" баярт зориулан 2018 оны 6-р сарын 1-ний өдөр хэлсэн үгээс авав.

Тэргүүн Зөвлөлийн нэгдүгээр зөвлөх
Ерөнхийлөгч Даллин Х.Өүкс

БАЯР ТЭМДЭГЛЭХ ШАЛТГААН

ТУХАЙН ҮЕДЭЭ насанд хүрсэн байсан хожмын үеийн гэгээнтнүүдэд санваарын талаарх 1978 оны илчлэлт оюун ухаанд арилшгүй мөрөө үлдээсэн үйл явдал байсан юм.

I.

Энэ мэдээ хааяа нэг дуугардаг утасны дуудлагаар дамжин надад ирсэн билээ. Би Бригам Янгийн Их Сургуулийн ерөнхийлөгчийн хүнд үүрэг хариуцлагаасаа холдож амрахаар барьсан уулан дээрх гэрийнхээ хашаанд хоёр хүүтэйгээ ажиллаж байлаа. Над руу ярьсан хүн ахлагч Боид К.Пакэр байсан юм. Тэр надад дөнгөж зарлагдаад байсан санваарын талаарх илчлэлтийн тухай хэлэв. Бид хэчнээн их баярлан хөөрч байгаагаа харилцан илэрхийлсний дараа, би эргээд ажилдаа орлоо. Би зөөж байсан овоолсон шороон дээр суугаад, хөвгүүдээ дуудав. Би тэдэнд Сүмийн бүх зохистой эрэгтэй гишүүн одоо санваарт томилогдох боломжтой болсныг хэлээд, баярын нулимс дуслуулаа.

Санваарын талаарх илчлэлт яагаад ийм баяр хөөрт үйл явдал байсан бэ? Хуулийн мэргэжлээр сурч ажилладаг залуухан эр байхдаа би Нэгдсэн Улсын Баруун төв болон зүүн хэсгийн бүс нутгаар 17 жил амьдарсан юм. Би эдгээр хязгаарлалтыг өөрийн биеэр мэдэрч байсан төдийгүй тэдгээрийг дагаж мөрдөн, шүүмжилж, учир шалтгааныг олох гэсэн хүмүүсийн зовлон, мухардлыг өөрийн нүдээр харж бас хуваалцаж байсан. Би тухайн үед өгөгдсөн шалтгаануудыг судалсан ч аль ч үнэнийх нь баталгааг мэдрэхгүй байв. Би залбирч судалсныхаа үр дүнд Их Эзэн ерөнхийдөө Өөрийн үйлчлүүлэгчид өгдөг зарлиг, удирдамжуудынхаа шалтгааныг бараг өгдөггүй болохыг сурч мэдсэн. Би зөн билэгтэй удирдагчдадаа үнэнч үлдэж, эдгээр хязгаарлалтыг тавихад өгөгдсөн амлалтын дагуу бүх хүн санваар болон ариун сүмийн адислалаас хүртэх тэр өдөр ирэхийн төлөө залбирахаар шийдсэн билээ. Харин 1978 оны 6-р сарын 8-нд тэр

өдөр ирэхэд би баярын нулимс унагаан, мэлмэртэл уйлж байлаа.

II.

1978 оноос хойш Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмд болон гишүүдийнх нь амьдралд юу болж байгааг бодож үзэх юм бол бидэнд баярлан тэмдэглэх олон шалтгаан гарч ирэх болно.

Байгууллагын хувьд Сүм санваарын талаарх илчлэлтийг шууд ажил хэрэг болгосон. Санваар хүртээх ёслол болон ариун сүмийн эрхийн бичгийг тэр даруй өгч эхэлсэн. Тухайн хязгаарлалтыг яагаад тавьсныг тайлбарлах гэж оролдон, бүр Сүмийн нөлөө бүхий удирдагчдын өгсөн байсан шалтгаануудыг тэр даруй, олны өмнө үгүйсгэв. Их Эзэн бошиглогчоороо дамжуулан ярьсан бөгөөд Сүм ч дуулгавартай дагасан юм.

Үүнтэй харьцуулахад, энэ нь гишүүдийн зүрх сэтгэл, бодит амьдралд өөрчлөлтийг шууд, нийтэд нь авчирсангүй. Зарим нь илчлэлтийн үр нөлөөг тэр даруй талархан, элэгсэг найрсгаар хүлээн авч байхад, зарим нь бага багаар хүлээн авч, харин зарим нь бүр өнгөрсөн 40 жилийг оролцуулан хувийнхаа амьдралаас дэлхий даяарх олон хүнд зовлон шаналал авчирсан арьсны өнгөөр ялгаварлах хандлагаа хаяж чадаагүй юм. Зарим нь бүр эргэж харах, хүчингүй болсон хязгаарлалтуудын шалтгааныг эрэлхийлэх, өнгөрснийг дахин нэг шалгахад анхаарлаа хандуулахыг хүсэж байлаа. Гэхдээ ахмад удирдагчдыг оролцуулан Сүмийн дийлэнх хүн улирч өнгөрсөн зүйлд урам хугарахын оронд ирээдүйд нээгдэх боломж бололцоонд анхаарлаа төвлөрүүлсэн. Ихэнх нь Их Эзэний мэргэн ухаан, цаг хугацааны сонголтод итгэж, Түүний бошиглогчийн удирдамжийг хүлээн авсан. Ингэснээр бид Түүний "Мөн түүний хувьд нэг нь бусдын адил эрхэм болой" (Иаков 2:21) гэсэн зөнт сургаалын мөнхийн ач холбогдлыг ухааран ойлгосон билээ. Ингэснээр бид бас үүрдийн сайн мэдээг "бүх үндэстэн, ястан, хэлтнүүд хийгээд хүмүүст" (С ба Г 42:58) заах гэсэн Их Эзэн Есүс Христийн зарлигийг биелүүлэх шинэ хөшүүргийг хүлээн авсан.

"МӨН ТҮҮНИЙ ХУВЬД ХҮН БҮР ҮНЭ ЦЭНТЭЙ БОЛОЙ."

III.

Илчлэгдээгүй зүйлс юм уу өмнө нь өгөгдсөн тайлбаруудыг өөрсдийн хязгаарлагдмал ойлголтоор ойлгох гэж хичээх нь гагцхүү хоосон таамаглал, урам хугаралтад хүргэнэ. Ийм зүйлд санаа зовж байгаа хүмүүст бид хайраа мөн доорх онцгой урилгыг өргөн барья. Бүгдээрээ итгэлдээ нэгдмэл байж, урагш

“БИД . . . БҮХ ХҮНИЙГ . . . БҮХИЙ Л ТӨРЛИЙН ГАДУУРХАХ ҮЗЛЭЭС САЛЖ, ИЛҮҮ БОЛОВСОН АЖИЛЛАХАД УРЬЖ БАЙНА.”

харцгааж, “мөн тэрээр бүгд өөрт нь ирж мөн өөрийнх нь сайн сайхныг хүртэхийг урьдаг; мөн тэрээр хар ба цагаан, боол ба чөлөөт, эр болон эм, түүнд ирэх хэнээс боловч үл татгалздаг” (2 Нифай 26:33) хэмээх Их Эзэний амлалтад найдацгаая.

Биднийг ирээдүй рүү харахад санваарын илчлэлтийн үзүүлсэн хамгийн чухал нөлөөнүүдийн нэг бол Бурханы хүүхдүүдийн эсрэг аливаа гадуурхах хандлагыг үгүй хийх бурханлаг дуудлага юм. Өнөө үед арьс өнгөөр ялгаварлах нь гадуурхлын хамгийн түгээмэл эх сурвалж бөгөөд бид бүгд үүнд наманчлахаар дуудагдсан. Гэхдээ түүхийн туршид, Бурханы олон бүлэг хүүхэд яс үндэс, соёл, үндэстэн, боловсрол эсвэл санхүүгийн байдлаасаа болж гадуурхан хавчигдаж, хохирсоор ирсэн билээ.

Бид Бурханы авралын агуу төлөвлөгөөний талаар мэдлэгтэй, үүрэг хариуцлагыг нь үүрсэн Түүний үйлчлэгчдийн хувьд мөн байгууллага болон хувь хүнийхээ хувьд хувийн бүх гадуурхах үзлээсээ салахад өөрсдийн хандлага, үйлдлийг яаралтай бэлдэх ёстой. Ерөнхийлөгч Рассэлл М.Нэлсон Өнгөт Арьстан Хүмүүсийн Дэвшлийн Төлөөх Үндэсний Холбооны албаны хүмүүстэй саяхан хийсэн уулзалт дээр: “Бид хамтдаа бүх хүн, байгууллага, мөн засгийн газр[ууд]ыг бүх төрлийн гадуурхах үзлээс салж, илүү боловсон ажиллахад уриалж байна”[1] гэж хэлсэн.

Бид гадуурхах хандлага, үйлдлээс салахаар нэгдсэн ч ариун сүмд ороход зохистой байхад тавигддаг Их Эзэний шаардлагыг дагах дүрмүүдийг өгч байгаа нь Сүмийн хувьд гадуурхаж байгаа хэрэг биш гэдгийг санах ёстой. Их Эзэн гэрээ, зарлигуудад дуулгавартай байх нь ариун нандин адислалуудаас хүртэхэд зайлшгүй шаардлагатай гэдгийг тунхагласан. Мөнх амьдрал, мөнхийн гэр бүлд тавигддаг бурханлаг шаардлагуудыг арилгах гэсэн аливаа оролдлого бол Сатаны “бүгд аврагдах болно” гэсэн төлөвлөгөөг хэрэгжүүлэхийг хичээхтэй адил юм. Мөнх бус бид Сатаны төлөвлөгөөг мөнх бус байдлын өмнөх амьдралдаа аль хэдийн хүлээн зөвшөөрөөгүй. Бид бүгдэд адил тэгш үйлчилдэг сонгох эрхийг болон мөнхийн гэрээ, зарлигуудыг сахих боломж олгодог Тэнгэрлэг Эцэгийнхээ төлөвлөгөөг

сонгосон. Бурханы тэгш эрхийн үр дагавар бүгдэд адил байхгүй ч бүгдэд адил тэгш боломж олгоно гэсэн үг юм.

IV.

Энэ ойн хөтөлбөрийн зорилго бол санваарын тухай илчлэлт өгөгдсөний 40 жилийн ойг урагш харан тэмдэглэх явдал юм. Ингэхдээ бид африк гаралтай, ялангуяа гадуурхлыг үгүй хийх шилжилтийн хүнд хэцүү үед итгэлтэй, үнэнч хэвээр үлдсэн Америкийн африк гайхалтай гишүүддээ онцгой талархал илэрхийлж байна. Одоо бид хамтдаа дэлхий даяарх Бурханы хүүхдүүдийг адисалсан 1978 оны илчлэлтийн дараа үзүүлсэн гайхамшигт үр дагаварт анхаарлаа хандуулцгаая. Тухайн үед зөн билэгт удирдагчид маань ингэж тунхаглажээ.

"Их Эзэн эрх мэдэл бүхий үйлчлэгчдийнх нь дуу хоолойг анхааралтай сонсож, сайн мэдээний адислал бүрийг хүлээн авахад өөрсдийгөө бэлтгэх дэлхий даяарх бүх хүүхдээ адислах Өөрийн тааллыг [мэдүүллээ]."[2]

Одоо гивлүүрийн хоёр талд байгаа Бурханы хүүхдүүдийг адислах ариун сүм олон улс оронд баригдаж байна. Дэлхий дээр ч тэнгэрт ч бид хамтдаа баясан цэнгэх болно. Энэ бол Мормоны Номын бошиглогчоор дамжуулан "тэрээр хэнд ч өөрийн авралыг бүү хүрт хэмээн үл зарлигладаг билээ" (2 Нифай 26:24) хэмээн тунхагласан, мөн өнөө үеийн бошиглогчоор дамжуулан "хэрэв та нар нэг байхгүй аваас, та нар минийх биш болой" (С ба Г 38:27) гэж тунхагласан Түүний Хоёр дахь ирэлтийн бэлтгэлийн нэг хэсэг юм. ■

ЭШЛЭЛҮҮД

1. "First Presidency and NAACP Leaders Call for Greater Civility, Racial Harmony," May 17, 2018, mormonnewsroom.org.
2. Албан тунхаг 2.

БИД ... ХУВИЙН БҮХ ГАДУУРХАХ ҮЗЛЭЭ ХАЯХЫН ТУЛД ЯАРАВЧЛАХ ЁСТОЙ.

ГҮҮР БАРИХ НЬ

Ерөнхийлөгч Рассэлл М.Нэлсон

ОЛОН ЗУУНЫ өмнө Аврагчаас нэгэн хуульч:

"Багш аа, Хууль дахь агуу тушаал нь аль вэ?" хэмээн асуужээ.

"Есүс түүнд, Чи бүх зүрх, бүх сэтгэл, бүх оюун ухаанаараа өөрийн Бурхан Эзэнээ хайрла.

Энэ бол агуу нь бөгөөд хамгийн чухал тушаал мөн.

Удаах нь, Чи хөршөө өөрийн адил хайрла.

Энэ хоёр тушаал дээр бүх Хууль болоод Эш үзүүлэгчид тулгуурладаг юм гэлээ"[1] хэмээн хариулсан.

Мөн 1831 онд Их Эзэн Иосеф Смитэд "Мөн хүн бүр ах дүүсээ өөр шигээ хүндлэг, мөн ариун журам хийгээд цэвэр ариун байдлыг миний өмнө байнга үйлдэгтүн" гэж хэлэх замаар дээрх зааврыг илчилсэн юм.

Харин дараа нь Тэрээр тодотгох үүднээс "Мөн дахин би та нарт хэлж байна, хүн бүр ах дүүсээ өөр шигээ хүндлэг"[2] гэж нэмж хэлжээ.

Цаг хугацааны голчид мөн хожмын өдрүүдэд Их Эзэн ижил тэгш боломжийн талаарх нэн чухал сургаалаа Өөрийн бүх хүүхдүүдэд дахин нэг удаа онцлон хэлсэн юм. Ерөнхийлөгч Өүкс Мормоны Номын: "[Их Эзэн] хар ба цагаан, боол ба чөлөөт, эр болон эм, түүнд ирэх хэнээс боловч үл татгалздаг; . . . Бурханд бүгд адил"[3] гэсэн энэ сургаалыг бидэнд сануулсан билээ.

Тив бүрд мөн далайн арлуудаар итгэлтэй хүмүүс Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмд нэгдэн цугларч байна. Итгэлтэй хүмүүс гэрээт зам дээр гарч, бидний хайрт Гэтэлгэгч дээр ирэхэд соёл, хэл яриа, хүйс, яс үндэс зэргийн ялгаа чухал байхаа больдог.

Эцсийн дүнд бид жинхэнэ Бурхан Эцэг байх гэдэг нь юу болохыг зөвхөн ойлгосноор ахан дүүгийн холбоо, эгч дүүсийн харилцаа гэж юу болохыг бүрэн утгаар нь ойлгох юм. Гагцхүү энэ ойлголт тусгаарлах ханын оронд татан оролцуулах гүүр барихад биднийг урамшуулдаг.

Би үүнийг сонсож байгаа хүн бүрийг аливаа гадуурхлын ачаанаасаа салж, Бурхантай болон бие биетэйгээ төгс амар амгалан, эв нэгдэлд алхах болтугай хэмээн өөрийн залбирал болон адислалаа үлдээе. ■

ЭШЛЭЛҮҮД

1. Матай 22:36–40
2. Сургаал ба Гэрээ 38:24–25
3. 2 Нифай 26:33



"ХАР БА ЦАГААН, БООЛ БА ЧӨЛӨӨТ, ЭР БОЛОН ЭМ; . . . БУРХАНД БҮГД АДИЛ."

АВРАГЧИЙН АДИЛ

ТОХИНУУЛАХ НЬ

Таныг бусдад туслахын тулд чадах бүхнээ хийх үед Аврагч хайр, энэрлээр харахад тань тусалж, таны нүдийг нээх болно.

Эрик Б.Мөрдок
Сүмийн сэтгүүлүүд

Найзад нь хүнд өдөр тохиосон эсвэл хэн нэгнийг ганцаардаж, сургууль дээрээ шоглуулж байхыг бид бүгд харж байсан. Тойрог, салбарын тань хүнд хэцүү асуудал тулгарсныг та сонссон байж магадгүй. Ийм үед та юу хийж болох вэ?

Заримдаа хэрхэн туслахаа олж мэдэхэд амаргүй байдаг. Өөр хүнийг ямар нэг юм хийхийг хүлээн суух нь илүү амар хялбар мэт санагдаж болох ч *танд* ердөө эргэн тойрныхондоо санаа тавьдгаа мэдүүлэх гэх мэт хийж болох олон зүйл бий. Боломжууд бидний эргэн тойронд байдаг бөгөөд бусдад хайр, санаа тавьж, анхаарч байгаагаа үзүүлэх бүрдээ та *тохинуулдаг*.

Хувийн тохинуулал

Тохинуулах нь. Та энэ үгийг сүүлийн үед Сүм дээр олон сонссон байх. Урьд нь бид ихэвчлэн Аврагчийн эсвэл бошиглогч, төлөөлөгчдийн тохинууллын талаар ярьдаг байсан ч *та* хувийн тохинууллын талаар бодож байсан уу?

Тохинуулах гэдэг нь бусдыг хайрлан халамжилж, Аврагч өнөөдөр бидний дунд амьдарч байсан бол хийх байсан зүйлсийг хийхийг хэлнэ. Тохинуулал нь бусдад Тэнгэрлэг Эцэгийн хайрыг мэдрэхэд тусалж, тэдний сүнслэг болоод материаллаг хэрэгцээг хангах арга зам юм.

Есүс "үйлчлүүлэхийн тулд бус, харин үйлчлэхийн тулд ирсэн" (Матай 20:28). Тэр "сайныг үйлдэж [явахдаа]" тохинуулсан (Үйлс 10:38).

> **Тохинуулах**
> гэдэг нь бусдыг хайрлаж, халамжлах гэсэн утгатай.

Христийн шавь нарын хувьд биднээс Түүний үлгэр жишээг дагахыг хүссэн. Бидэнд хувийн тохинуулал *бий*!

Гэхдээ та тохинуулахын тулд үйлчлэлийн том төсөл зохион байгуулах шаардлагагүй. Арван хоёр Төлөөлөгчийн Чуулгын ерөнхийлөгчийн үүрэг гүйцэтгэгч, ерөнхийлөгч М.Рассэлл Баллард "Гэр бүлдээ болон Сүмийн дуудлагат ажлыг хийх, түүнчлэн олон нийтийн байгууллагын ажилд оролцох гэх мэт зарим үйлчлэх боломж албан ёсных байдаг. . . .

[Гэхдээ] үйлчлэх олон боломж албан ёсны бус буюу ямар нэг томилгоогүй байдаг бөгөөд амьдралынхаа аяллын явцад уулзаж, тусламжийн гараа сунгах үед гарч ирдэг"[1] гэж хэлсэн.

Ихэнхдээ Христийнхтэй адил тохинууллыг та өдөр тутмын жижигхэн, чин сэтгэлийн үйлдлүүдээрээ хийдэг.

Нэг нэгээр нь

Аврагч нифайчууд дээр айлчлан ирэхдээ хүн бүрийг ирж, Түүний хавирган талын мөн Түүний мутар болон хөлөн дэх сорвиудад хүр гэж хэлсэн. "Мөн тэд үүнийг үйлдэж, *бүгд* очих хүртлээ *нэг нэгээрээ* очих хүртлээ [явсан]" (3 Нифай 11:15; тодотгол нэмэгдсэн).

Тэгээд Тэр тэднийг өвдсөн, гэмтсэн, “ямар нэгэн байдалд зовж зүдэрсэн [хүн бүрийг авчрахад урьж] . . . мөн тэрбээр тэднийг түүнд авчрагдахад *нэг бүрчлэн* эдгээ[сэн]” (3 Нифай 17:7, 9; тодотгол нэмэгдсэн). Үүний дараа Тэрээр “тэдний бяцхан хүүхдүүдийг *нэг нэгээр нь* авч, мөн тэднийг адислав, мөн тэдний төлөө Эцэгт хандан залбирав” (3 Нифай 17:21; тодотгол нэмэгдсэн).

Энэ нь жижигхэн бүлэг хүн байсангүй. Тэнд 2500 орчим хүн байсан гэж сударт цэдэглэсэн байдаг (3 Нифай 17:25). Гэсэн *хэдий ч* Аврагч цаг гарган хүн тус бүрийг эдгээж, тайтгаруулж, урамшуулж, тэдэнд хайраа үзүүлсэн.

Арван хоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Роналд А.Расбанд “Хувь хүнд зориулсан үнэхээр гүн гүнзгий бөгөөд сайхан сэтгэлийн захиас энд агуулагддаг. Есүс Христ бид бүгдэд нэг нэгээр нь тохинуулж, хайрладаг” гэж заасан байдаг.[2] Хувь хүнд Есүсийн үзүүлдэг хайр бол тохинууллын зорилго юм.

> *Хувь хүнд Есүсийн үзүүлдэг **хайр** бол тохинууллын зорилго юм.*

Харах нүд

Аврагч эргэн тойрныхоо хүмүүст тусалдаг байсан. Халамжийн нийгэмлэгийн ерөнхий ерөнхийлөгч Жийн Б.Бингам “Аврагч инээмсэглэж, ярьж, хамт алхаж мөн сонсож, цаг гаргаж, урамшуулан дэмжиж бас зааж, хооллож, уучилж байсан. Тэр гэр бүл, найз нөхөд, хөршүүд болон танихгүй хүмүүст ч мөн адил үйлчилж, танилуудаа болон хайртай хүмүүсээ Өөрийн сайн мэдээний гайхамшигт адислалуудын баяр хөөрийг хүлээн авахад урьсан”[3] гэж хэлсэн.

Есүс Христ эргэн тойрныхоо хүн нэг бүрийн хэрэгцээг харах нүдтэй байсан бөгөөд тэдгээр хүнд бүгдэд нь хүрч тусалдаг байсан юм. Бид ч бас Түүний жишээг дагаж, тусламж хэрэгтэй хүмүүст хүрч тусалж чадна.

Гэхдээ Аврагч төгс билээ. Бид хэрхэн Түүний адил бусдын хэрэгцээг харж, тохинуулж чадах вэ? Ерөнхийлөгч Баллард “Өглөө бүр залбирахдаа, Тэнгэрлэг Эцэгээс Түүний хайртай хүүхдүүдийн нэгэнд үйлчлэх боломжийг таньж мэдэхэд удирдахыг залбиран гуй. Тэгээд өдрийн турш хайр, итгэлээр дүүрэн зүрх сэтгэлтэйгээр тусламж хэрэгтэй хэн нэгнийг олохоор яв. . . . Хэрэв та нар үүнийг хийх юм бол сүнслэг мэдрэмжүүд тань өсөж, урьд нь хэзээ ч боломжгүй мэт байсан үйлчлэх боломжуудыг олж нээх болно”[4] гэж хэлсэн билээ.

Сүнслэг өдөөлтийн дагуу үйлд

Дараах үйл явдлыг ургуулан бод. Чи найзаа сургууль дээр харсан бөгөөд тэр жоохон гунигтай байгаа мэт харагдав. Чамд түүнд зориулан ямар нэгэн зүйл хийх хэрэгтэй гэж бодогдсон ч түүнийг зовоож эсвэл түүнийг болон өөрийгөө эвгүй байдалд оруулж магадгүй гэж санаа зовлоо. Харин дараа нь энэ нь сүнслэг өдөөлт байсан уу эсвэл зөвхөн өөрийн тань бодол байв уу гэдэгт санаа зовох болов.

Заримдаа та тохинуулах сүнслэг өдөөлт авч байна уу эсвэл зөвхөн өөрөө бодож байна уу гэдгээ мэдэхэд хэцүү. Гэвч Мормон сүнслэг өдөөлтийг хэрхэн таних талаар: “Бурханых болох тэр нь үргэлж сайныг үйлдэхэд урьж мөн татдаг; иймийн тул, сайныг үйлдэхэд мөн Бурханыг хайрлахад, мөн түүнд

СЭРЭЛ ЗУРГИЙГ ВОНЭНИА КАРСВЭЛЛ/UNSPLASH

үйлчлэхэд урьж мөн татдаг тэрхүү юм бүр, Бурханаар нөлөөлөгддөг" (Моронай 7:13) гэж заасан.

Ерөнхийлөгч Томас С.Монсон (1927–2018) "Хэрэв бид сонор соргог, ажигламтгай байж, өөртөө ирдэг сүнсний өдөөлтүүдийн дагуу үйлдэх юм бол сайн сайхан үйлс олныг бүтээж чадна"[5] хэмээн хэлсэн байдаг.

Тохинуулал хүн бүрд зориулагдсан

2018 оны 4-р сарын Ерөнхий чуулганы үеэр ерөнхийлөгч Рассэлл М.Нэлсон "Их Эзэн бидний нэг нэгнээ халамжилдаг арга замд чухал өөрчлөлтүүдийг хийлээ. Ахимаг насны болон залуу ах, эгч нар нэг нэгэндээ шинэ бөгөөд илүү ариун нандин арга замаар үйлчлэх болно"[6] гэж зарласан. Үүнд тохинууллын хамтрагчаар үйлчлэх боломж ордог ч тохинуулал нь бид зөвхөн ням гарагт эсвэл Мючелийн үйл ажиллагааны үеэр хийдэг зүйл биш юм. Энэ нь тодорхой дуудлагын хамт ирдэг үүрэг хариуцлагын нэг биш ээ. Тохинуулал хүн бүрд зориулагдсан. Үүнийг цаг үргэлж хийх ёстой.

Бид баптисм хүртэхдээ, "нэг нэгнийхээ ачааг хөнгөн байж болохын тулд үүрэлцэхэд; мөн гашуудах тэдний хамт гашуудахад; тийм ээ, тайтгарал хэрэгтэй тэднийг тайтгаруулахад бэлэн [байхаа]" амладаг (Мозая 18:8–9). Бусдад тохинуулах гэдэг нь бидний хийхээр амласан зүйлийн нэг хэсэг юм.

> *Хэрэв бид* *өөртөө ирдэг сүнсний өдөөлтүүдийн дагуу үйлдэх юм бол сайн сайхан үйлс олныг бүтээж чадна.*

Залуу эмэгтэйчүүдийн ерөнхий ерөнхийлөгч байсан Бонни Л.Оскарсон "Их Эзэн танаас үеийнхэн дундаасаа тусалж болох хүнийг олж харж, дараа нь Өөрийнх нь адил үйлчлэхэй хэмээн хүсдэг"[7] гэж хэлжээ. Та үүнийг хийх юм бол Тэрээр хайр болон энэрлээр бусдад хэрхэн үйлчилж болохыг олж харахад тань тусалж, таны нүдийг нээх болно. Тэрээр таныг юу хийхээ өөрөө тааж мэд хэмээн орхихгүй. Тэр тэдэнд хэрхэн хамгийн сайнаараа тохинуулж болохыг тань удирдан чиглүүлэх болно.

Тохинуулал адислалуудыг авчирдаг

Ерөнхийлөгч Нэлсон "Бид [Их Эзэний] үйлчлэгчдийн хувиар Түүний хийсэнчлэн тэрхүү нэгэнд тохинуулах болно"[8] гэж хэлсэн. Энэ нь бусдыг адислаад зогсохгүй, биднийг ч мөн адил адисалдаг.

Арван хоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Дийтр Ф.Угдорф "Бид Христийнхтэй адил хайраар бусдад гар, зүрх сэтгэлээрээ тусалсан үед бидэнд гайхамшиг тохиодог. Бидний сүнс илааршиж, илүү цэвэр, бат бөх болно. Бид улам аз жаргалтай, амар амгалан болж, Ариун Сүнсний шивнээг хүлээн авах илүү чадвартай болно"[9] гэж хэлсэн.

Есүс Христ илүү баялаг, утга учиртай амьдралд хүргэх арга замыг харуулсан билээ. Түүний нэгэн адил тохинуулах нь таны амьдралд жинхэнэ аз жаргал, амар амгалан, баяр баясгаланг авчирна. ■

ЭШЛЭЛҮҮД

1. М.Рассэлл Баллард, "Бурханы үнэ цэнтэй бэлгүүд," *2018 оны 4-р сарын Ерөнхий чуулган,* 7.
2. Ronald A. Rasband, "One by One," *Liahona,* Nov. 2000, 29.
3. Жийн Б.Бингам, "Аврагчийн адил тохинуулах нь," *2018 оны 4-р сарын Ерөнхий чуулган,* 130.
4. М.Рассэл Баллард, "Санаа сэтгэлээ бүрэн зориулсан байх нь," *2012 оны 11-р сарын Ерөнхий чуулган,* 37.
5. Thomas S. Monson, "Three Goals to Guide You," *Liahona,* Nov. 2007, 121.
6. Ерөнхийлөгч Рассэлл М.Нэлсон, "Үргэлжлүүлцгээе хамтдаа," *2018 оны 4-р сарын Ерөнхий чуулган,* 147.
7. Бонни Л.Оскарсон, "Тусламж хэрэгтэй хүмүүс бидний өмнө байна," *2017 оны 10-р сарын Ерөнхий чуулган,* 10.
8. Рассэлл М.Нэлсон, "Бурханы хүч, эрх мэдлээр тохинуулах нь," *2018 оны 4-р сарын Ерөнхий чуулган,* 88.
9. Дийтр Ф.Угдорф, "Та нар миний гар," *2010 оны 4-р сарын Ерөнхий чуулган,* 83.

ХРИСТИЙН МЭНДЭЛСНИЙ БАЯРЫН

сүнсийг МЭДРЭХ долоон

АРГА ЗАМ

БЯЛХСАН ЗООГ БОЛОН НАЙР НААДАМ ЗУГААТАЙ Ч БАЯР ХӨӨРТЭЙ ТОХИНУУЛАХ НЬ ХРИСТИЙН МЭНДЭЛСНИЙ БАЯРЫН СҮНСТЭЙ БАЙХ ТҮЛХҮҮР ЮМ.

Шарлотт Ларкэбэл
Сүмийн сэтгүүлүүд

ЗУРАГ ЧИМЭГЛЭЛИЙГ МАЙКЛ МУЛЛАН

“Христийн мэндэлсний баяр шиг санагдахгүй байна.” Танд ийм бодол төрж байсан уу? Танд яг одоо ийм мэдрэмж төрж байж болно. Та Христийн мэндэлсний баярын дуут хэчнээн чанга тоглож, хэчнээн олон Христийн мэндэлсний баярын жигнэмэг идээд ч Христийн мэндэлсний баярын сүнсийг мэдрэхгүй байж магадгүй.

Хэрэв энэ нь танд танил сонсогдож байвал, эсвэл та энэ жил Христийн мэндэлсний баярын гялбааг арай илүү мэдрэхийг хүсэж байвал цааш нь уншаарай!

Ерөнхийлөгч Дэвид О.Маккэй (1873–1970) үүнийг “Христийн мэндэлсний Баярын сүнс бол Христийн сүнс юм. Эл сүнс ах дүүгийн ёсны хайр, нөхөрлөлөөр бидний зүрх сэтгэлийг дүүргэж, үйлчлэлийн нигүүлсэнгүй үйлсэд биднийг өдөөдөг билээ”[1] хэмээн маш энгийн болгож хэлсэн. Залуу эмэгтэйчүүдийн ерөнхий ерөнхийлөгч асан Бонни Л.Оскарсон “Өөрийн эргэн тойрон дахь хүмүүст өгөөмрөөр гараа сунгаж, өөрсдийнхөөсөө өгөх нь Христийн мэндэлсний баярын сүнсийг өргөх арга юм”[2] гэдгийг хүлээн зөвшөөрсөн.

Сүлд мод чимэглэж, бэлэг өгөх нь Христийн мэндэлсний баярыг тэмдэглэх арга ч Христийн мэндэлсний баярын сүнсийг мэдрэх түлхүүр бол бусдад тохинуулах явдал юм. (Тохинууллын талаар илүү ихийг сурахын тулд өмнөх “Аврагчийн адил тохинуулах нь” өгүүллийг үзнэ үү.)

Бас сайн мэдээ! Христийн мэндэлсний баярын үеэр бусдад тохинуулах олон арга зам бий. Эдгээрийн заримаас нь хийж үзэх юм бол та Сүнсний дулаан уур амьсгалыг мэдэрч, Христийн мэндэлсний баярын жинхэнэ сүнс болох Аврагчид илүү ойртсоноо мэдрэх болно.

1. Ганцаардсан хүнийг эргэж оч.

Баярын өдрүүдийг хамт өнгөрүүлэх гэр бүл, найз нөхөдгүй таньдаг хүмүүсийнхээ тухай бод. Ахмад настай юм уу айл хөрш болон дөнгөж нүүж ирсэн хэн нэгэн дээр зочлон очих талаар бодож үз. Ганцаардсан ганц хүнд тусламжийн гараа сунгаснаар хүчтэй нөлөө үзүүлж болно. Арван хоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Дэвид А.Бэднарын цохон тэмдэглэснээр “хүмүүст нэг нэгээр нь тусалснаар ‘нэгүүдэд’ тохинуул.”[3] Бид бас ингэж чадна.

2. Христийн мэндэлсний баярын магтуут дуул.

Бошиглогч маань Христийн мэндэлсний баярын магтуунд дуртай гэдгийг та нар мэдэх үү? “Сантагийн тухай этгээд явган дуут” хоолойгоо шахан дуулж байна уу, эсвэл Аврагчийн тухай дуртай дууллаа хүндэтгэлтэйгээр дуулж байна уу гэдгээс үл хамааран бусадтай дуу хөгжим хуваалцах нь Христийн мэндэлсний баярын жинхэнэ сүнсийг бодитоор нь мэдрэх[4] гайхалтай сайхан арга зам гэдэгт ерөнхийлөгч Рассэлл М.Нэлсон итгэдэг.

3. Утсаа харахаасаа өмнө эргэн тойрноо хар.

Та утсаа бүхэл өдрийн турш халаасандаа байлгах албагүй ч байх газраа байж, эргэн тойрныхоо хүмүүст анхаарлаа хандуулах нь Христийн мэндэлсний баярын сүнстэй эргэн холбогдох гайхалтай арга зам юм.

“Найзууд тань юу хийж байгааг харахын тулд утсаа авахын оронд хэсэг азнаж, эргэн тойрноо хараад, ‘Өнөөдөр би хэнд хэрэгтэй вэ?’ гэж өөрөө өөрөөсөө асуугаарай. “Та нар үеийнхээ хэн нэгэнд тусламжийн гараа сунган, амьдралд нь нөлөөлөх эсвэл дотроо зовж шаналж яваа найздаа урмын үг хэлэх түлхүүр нь байж магадгүй.”[5]

4. Нэмэлт гэрийн ажил хий.

Гэр цэвэрлэх, хүүхэд харах эсвэл гэрийн бусад ажлыг нэмж хийх нь танд Христийн мэндэлсний баярын сүнсийг мэдрэхэд үнэхээр туслах болов уу? Хэрэв та үүнийг зөв хандлагаар хийвэл туслах нь гарцаагүй! Зүлгэж юм уу цэвэрлэж байхдаа үйлчилж байгаа хүнийхээ тухай бодоорой. Гэр бүл, найз нөхөд тань таны хичээнгүйлэн хөдөлмөрлөж хийсэн бэлэгт ямар их баярлахыг бодоод үз.

5. Христийн мэндэлсний баярын амттанг тарааж өг.

Христийн мэндэлсний баярын жигнэмгийг идэх тухай өмнө нь дурдсанчлан, яагаад Христийн мэндэлсний баярын амттанаа бөөн бөөнөөр нь хийж болохгүй гэж? Та өөрөө хэдийг (эсвэл олныг) амсаж болох ч Христийн мэндэлсний баярын сүнсийг мэдрэх гол түлхүүр маань бусдад өгөх явдал юм.

6. Христийн мэндэлсний баярын видео бичлэгийг хуваалц.

Христийн мэндэлсний баярын захиасыг олон нийтийн сүлжээн дээр тавь. Христийн мэндэлсний баярт зориулсан Мормон захиасыг үзэж, санаа ав. Та бас Mormon.org дээрх Сүмийн Христийн мэндэлсний баярын видео бичлэгийг хуваалцсанаар хэн нэгний өдрийг гэрэлтүүлж чадна. Та үүнийг найздаа илгээх юм уу өөрийн хуудсан дээр тавьж хуваалцаж болно.

7. Үүнийгээ нууцаар хий.

Та баригдалгүйгээр хэр олон нууц үйлчлэл хийж чадах бол? Та хүнсний зүйлс, бэлэг зэргийг хэн нэгний үүдэнд үлдээн, хүрэмнийх нь халаасанд сайхан үгтэй зурвас хийж, цас арилгаж, навчийг нь цэвэрлэж болно. Гэхдээ өөрийгөө хэнд ч бүү мэдүүл! Өглөг чинь нууц байг (Матай 6:4-ийг үзнэ үү) гэснийг сана.

Христийн мэндэлсний баяраар тохинуулах нь

Гялалзсан чимэглэл, найрын ширээ нь баярыг гайхалтай сайхан, хөөр баяслаар дүүргэж болох ч Христийн мэндэлсний баярын сүнстэй байх түлхүүр бол тохинуулал юм.

Арван хоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Дийтр Ф.Угдорф "Бид Түүний дэлхийд ирсэн явдлыг үнэхээр хүндлэхийн тулд Түүний хийснийг хийж, найз нөхдөдөө энэрэл хайр, нинжин сэтгэлээр туслах ёстой. Бид үүнийг өдөр бүр, үг хэл, үйлдлээрээ хийж болно. Бүгдээрээ Христийн мэндэлсний баярыг хаана байгаагаасаа үл хамааран арай илүү эелдэг, илүү өршөөнгүй мөн шүүлгүйгээр, талархалтай байж, элбэг дэлбэг байгаа зүйлээсээ хэрэгтэй хүмүүст нь өгөөмрөөр өгөхийг уламжлал болгоцгооё"[6] гэж хэлсэн. ■

ЭШЛЭЛҮҮД

1. David O. McKay, *Gospel Ideals* (1953), 551.
2. Bonnie L. Oscarson, "Christmas Is Christlike Love" (First Presidency Christmas Devotional, Dec. 7, 2014), broadcasts.lds.org.
3. David A. Bednar's Facebook page, video posted on Jan. 22, 2017, facebook.com/lds.david.a.bednar/videos.
4. Russell M. Nelson, in "Christmas Memories from Prophets and Apostles," *New Era,* Dec. 2015, 10.
5. Бонни Л.Оскарсон, "Тусламж хэрэгтэй хүмүүс бидний өмнө байна," *2017 оны 10-р сарын Ерөнхий чуулган,* 8.
6. Дийтр Ф.Угдорф, "Үйрмэгээ цац" (Тэргүүн Зөвлөлийн Христийн мэндэлсний баярын онцгой цугларалт, 2017 оны 12-р сарын 3), broadcasts.lds.org.

ХРИСТИЙН МЭНДЭЛСНИЙ БАЯРЫН БЭЛГИЙН ЖАГСААЛТДАА

СҮНСНИЙ БЭЛГҮҮДИЙГ НЭМЭХ НЬ

Дэвид Диксон
Сүмийн сэтгүүлүүд

Би үргэлж гайхалтай сайхан бяслагтай жигнэсэн хачиртай талх хийдэг. Энэ сайхан хоол болон цөөн тооны бусад жороор хийсэн хоолны хамт би өөрийгөө номлолынхоо турш эрийн цээнд хүртлээ амьд сэрүүн, эрүүл саруул байлгаж чадсан юм. Харин дараа нь би гэрлэж, бүгд өөр өөрийн гэсэн амттанд дуртай хүүхдүүдтэй болов. Би хоолныхоо цэсийг баяжуулах хэрэгтэй болж билээ!

Гэсэн хэдий ч оройн хоол хийх ээлжтэй үедээ шинэ хоол хийж туршиж үзэх нь миний хувьд үнэхээр хэцүү байлаа. Юуны өмнө, орой надад цаг бага байдаг байв. Хэдийгээр би олон төрлийн хоол хийхийг хүссэн ч дандаа асуудал гарч ирдэг байлаа. Орцонд ордог зүйлсээ олохгүй эсвэл зарим нь бүр байдаггүй байв. Би ихэнхдээ төлөвлөсөн оройн хоолоо болиод, оронд нь хурдан, амархан хоол хийчихдэг байлаа.

Тэгэхдээ л би энэ тал дээрээ ажиллаж, сайжруулахыг хүсдэг байв. Тиймээс би урьд нь хэзээ ч хийж байгаагүй зүйлээ хийхээр шийдэв. Би сүнслэг бэлгээ нэрээр нь дуудан хэлж, залбирсан юм.

ГЭРЭЛ ЗУРГИЙГ ЖОШ ТАЛБОТ

Нэг бэлэг, олон хэрэглээ

Ялангуяа би эмх цэгцтэй байх бэлгийн төлөө залбирав. Тийм ээ, эмх цэгцтэй байх! Бидэнд амтлагчийн тавиур байдаг байсан. Бидэнд мөн халбага сэрээгээ хийдэг шургуулга ч байдаг байлаа. Тийм зүйлс байсаар байхад яагаад ч юм би хоол хийхээсээ илүү хэрэгтэй зүйлээ хайхад хавьгүй их цаг зарцуулж байв.

Би энэ бэлгийн төлөө уйгагүй залбирснаар надад тодорхой санаанууд орж ирэх болсон. Хананд өлгөдөг амтлагчийн тавиур амтлагчуудыг эмх цэгцтэй, гарын доор байлгана. Соронзтой тогтоогчинд (мөн хананд өлгөдөг) хутга болон бусад төмөр халбага, шанагыг тогтоож болно. Эдгээр болон бусад санаагаа хэрэгжүүлснээр хоол хийх ажил маань ихэд хөнгөрөв. Ганга хэрэгтэй юү? Сармистай давс уу? Нунтаг *сармис* хэрэг болсон уу? Би олоод өгч чадна шүү!

Гэтэл нэгэн хөгжилтэй явдал тохиолдов. Амьдралынхаа өөр хэсгийг бага багаар илүү эмх цэгцэнд оруулах энгийн арга замууд санаанд минь орж ирэх боллоо. Жишээлбэл, гараараа хийсэн гурван давхар угаалгын тавцан маань гэр бүлийг маань амлагдсан нутагт аваачихгүй ч Нифай хүртэл үүнийг барьсан арга замыг үнэлэх байсан. Би үүнийг бага багаар надад орж ирсэн өдөөлтүүдээ даган хийж билээ.

Эмхлэн цэгцлэх сүнслэг бэлэг миний болон гэр бүлийнхний маань амьдралыг төсөөлж байснаас минь хавьгүй ихээр сайжруулсан.

Би асуусан учраас л энэ бүхэн надад ирсэн юм.

Олон бэлэг байгаа ч асуудаг нь цөөн

Төлөөлөгч Паул итгэл, эдгээх бэлэг зэрэг сүнсний олон бэлгийн заримынх нь тухай коринтчуудад заасан (1 Коринт 12:5–11-ийг үзнэ үү). Дараа нь тэрээр “үлэмж агуу бэлгүүдийг хүсэн тэмүүлэхийг” (1 Коринт 12:31) тэдэнд зааварласан.

Хүсэн тэмүүлэх санаа нь яагаад *сайн* зүйл болох талаар ойлгоход хэцүү байж болох ч энэ тохиолдолд бол хүсэн тэмүүлэх нь зөв зүйтэй зүйл юм. Бусдаас харж болох сүнслэг бэлгүүдийг олж харан, мөн адил бэлгээр адислахыг Бурханаас хүсэж болох тухай бидэнд зааварласан. Үүнийг хийж байгаа бидний итгэл найдвар бол бусдад илүү сайн үйлчилж мөн Бурханы хаант улсыг барих явдал юм (С ба Г 46:26–29-ийг үзнэ үү).

Маш олон бэлэг, бүр сударт цэдэглэгдсэнээс ч хавьгүй олон бэлэг байгаа. Тэвчээртэй байх нь сүнслэг бэлэг юм. Өөдрөг үзэл ч мөн адил. Эр зориг, амар тайвныг тогтоогч байх бэлэг ч бас бий. Далын ахлагч Ларри Р.Лорэнс “Заримдаа би тэнгэрт сүнсний бэлгүүдээр дүүрэн маш том агуулах байгаа бөгөөд асуух итгэлтэй бүх гэгээнтэн хүлээн авах боломжтой гэж төсөөлөн боддог. Харамсалтай нь, ихэнх нь асуудаггүй тул агуулах үргэлж илүүдэл нөөцтэй байдаг”[1] хэмээн зааж билээ.

Ахлагч Лорэнс энэрлийн бэлгийн төлөө залбирахаар шийдсэн найзынхаа талаар ярьсан. Тэрээр найзад нь тохиолдсон явдлыг: “Найз маань ‘Би хэдэн сарын турш энэрлээ өсгөн нэмэгдүүлэхийн төлөө онцгойлон залбирсан юм. . . . Аажмаар, бусдын талаарх миний ойлголт өөрчлөгдсөн. . . . Би эргэн тойрныхоо хүмүүсийг зүгээр нэг хайрлаад зогсохгүй тэдэнтэй хамт цагийг сайхан өнгөрүүлэх болсон. Өмнө нь би хүмүүсээс зайгаа барьдаг байсан бол одоо хүн бүрийг үнэн сэтгэлээсээ сонирхох болсон’ гэж бичсэн байсан”[2] гэж ярив.

Бэлгүүд тань бэлэн, таныг хүлээж байна

Сүнслэг бэлгүүд нь материаллаг бэлгүүдээ бодвол илүү үнэ цэнтэй. Тэдгээр нь үнэндээ *хамгийн сайн* бэлгүүд юм. Бидэнд судар дээр “хамгийн шилдэг бэлгүүдийг хичээнгүйлэн эрэлхийл” (С ба Г 46:8) хэмээн зарлигласан байдаг.

Христийн мэндэлсний баярын өглөө онгойлгохыг хүсэж байгаа бэлгээс тань гадна хэдэн “хамгийн сайн бэлгийг” онгойлгохыг танаас хүлээж байна гэж төсөөлөн бодно уу. Тэдгээрийг аль хэдийн боож, таныг болон таны эргэн тойрон дахь хүмүүсийг адислахад бэлэн болсон байгаа.

Тиймээс цаг алдалгүй, гуй. ■

ЭШЛЭЛҮҮД

1. Larry R. Lawrence, “Why Not Ask?” (Brigham Young University–Idaho devotional, June 13, 2017), byui.edu/devotionalsandspeeches.
2. Larry R. Lawrence, “Why Not Ask?”

“Би Аврагчийн хайрыг хүртэх эрхгүй мэт надад санагддаг. Би хэрхэн энэ мэдрэмжээсээ салж, өөрийнхөө үнэ цэнийг мэдэрч болох вэ?”



“Хайрлуулах зохистой байгаа эсэхээс үл хамааран Бурхан та бүхнийг хайрладаг. Тэр ямар ч тохиолдолд үргэлж хайрладаг билээ.

Бид чин сэтгэлийн залбирлаар Тэнгэрлэг Эцэгтээ хандаж, зорилготойгоор судраас судалбал гэрчлэл маань хүчирхэгжиж, гүн гүнзгий суурьтай болно. Бид Бурханы биднийг гэсэн хайрыг мэдрэх болно.”

Ерөнхийлөгч Томас С.Монсон (1927-2018), “Бид хэзээ ч ганцаараа алхдаггүй,” *2013 оны 10-р сарын Ерөнхий чуулган*, 144.

Түүний хайрыг мэдрэхийн төлөө залбир

Бид бүгд Тэнгэрлэг Эцэгийн охид, хөвгүүд. Түүний биднийг гэсэн хайр хэмжээлшгүй. Хэрэв бидэнд Бурханы хайраас хүртэх эрхгүй гэсэн мэдрэмж төрвөл Түүнд хандан залбирах ёстой. Түүний хайрыг мэдрэхийн төлөө залбир. Бурханы хайраас хүртэх зохистой гэдгээ мэдрэхийн тулд мөн өөрийгөө Түүний мэлмийгээр харахын төлөө залбир. Тэрээр бидний залбиралд Өөрийн цаг хугацаа болон арга замаар, төгс хайраа батлан үргэлж хариулах болно. Сэтгэл санаагаар унах юм уу ганцаардах болгондоо Түүний хайраас хүртэхийн төлөө залбирах нь сэтгэлийг минь үргэлж сэргээдэг.

Жулиа М., 16 настай, АНУ-ын Виржиниа



Аврагчид илүү ойрт

Саяхан, номлолд бэлтгэх ангид бид Бурханы биднийг гэсэн хайрыг олж харахын тулд хэрхэн нүдээ нээж болох талаар ярилцсан. Өөрсдийн үнэ цэнийг илүү сайн мэдрэхэд туслах янз бүрийн зүйлсийн талаар бид ярилцсан юм. Тэдгээрийн зарим нь хөршдөө үйлчлэх, өөрт хамаатай зүйлдээ тусламж хүсэн залбирах, судраас суралцах, номлогч байх зэрэг сэдэв байв. Энэ бүх зүйл биднийг Есүс Христэд илүү ойртуулан, Түүнтэй адилхан болох чадвартай гэдгээ олж мэдэхэд чиглүүлсэн.

Сантиаго З., 17 настай, АНУ-ын Аризона

Зарлигуудыг сахь

Заримдаа надад Их Эзэний зарлигуудыг бүрэн дуулгавартай дагадаггүй тул Аврагчийн хайраас хүртэх эрхгүй юм шиг санагддаг. Би эдгээр мэдрэмжийг наманчилснаар, заримдаа Их Эзэн Өөрийн бүх хүүхдэд хайртай гэдгийг заадаг бишопынхоо тусламжтайгаар даван гарч чадна.

Жак Д., 15 настай, Кот-Дивуарын Абиджан

Наманчлал бол түлхүүр

Бид бүгд нүгэл үйлддэг бөгөөд үүнээсээ болж Аврагчийн хайрыг хүртэх эрхгүй гэдгээ мэдэрдэг. Гэвч Тэр Өөрийн амийг бидний төлөө өгсөн буюу бидний төлөө золиослол хийсэн. Тэрээр хайртай болохоор амь бие үл хайрлан энэ үйлдлийг хийсэн юм. Түүний хайрыг хүртэх эрхтэйгээ мэдрэхийн тулд бидний хийж болох цорын ганц зүйл бол гэм нүглээ наманчлан, Түүний Цагаатгалын хүчийг ашиглах явдал. Наманчлал бол зохистой гэдгээ болон Аврагчийн хайрыг хүлээн зөвшөөрөх түлхүүр билээ.

Кустан эгч, 23 настай, Филиппинийн Себу номлол

Бусдыг хайрла

Өөрсдийн үнэ цэнийг мэдэх нэг арга зам бол эргэн тойрон дахь хүмүүсийнхээ үнэ цэнийг ойлгох явдал юм. Бусдыг өргөн дэмжихийн тулд тэдэнд анхаарлаа төвлөрүүлэх нь бидэнд өөрсдийгөө сайн талаас нь харахад тусалдаг. Ингэснээр хоёр тал хоёулаа хожно! Миний өөртөө итгэх итгэл гуйваад ирмэгц би эргэн тойрныхоо тусламж хэрэгтэй байгаа хэн нэгэнд үйлчлэхээр шийддэг. Би хэцүү нөхцөлд байгаа найздаа бүтэн сарын турш өдөр бүр магтаалын үг хэлсэн. Бусдад анхаарлаа төвлөрүүлэх нь надад өөрийгөө зохистой бөгөөд бусдад хэрэгтэй гэдгээ мэдрэхэд тусалсан. Бусдыг байгаагаар нь хайрлахыг хичээх үед Бурхан бидэнд хэчнээн их хайртай болохыг илүү амархан олж хардаг. Хайрлуулах эрхтэй гэдгээ мэдрэхэд нь бусдад туслах нь өөрсдийгөө хайрлуулах эрхтэй гэдгээ мэдрэхэд тусалдаг.

Жэйми В., 15 настай, АНУ-ын Миннесота

Эдгээр хариулт тусламж, ойлголт өгөх зориулгатой бөгөөд Сүмийн сургаалын албан ёсны мэдэгдэл биш юм.

ЗУРГИЙГ БРАЙАН МИНЭАР-316499/UNSPLASH

Би наманчилсан хэдий ч туйлын гэм буруутай гэсэн мэдрэмж төрсөн хэвээр. Би хэрхэн амар амгаланг олох вэ?

Хэрвээ та бүрэн наманчилбал таны гэм буруу Есүс Христийн хязгааргүй Цагаатгалын улмаас арчигдах болно. Гэвч заримдаа хүмүүс наманчилсан мөртлөө нүглийн ой санамжийнхаа улмаас гэм буруугаа мэдэрсээр байдаг.

Гэм буруу буюу "бурханлаг гэмшил" (2 Коринт 7:10) тус болох нь бий. Энэ нь бидний бодлыг Есүс Христ дээр төвлөрүүлж, жинхэнээсээ наманчилж, өөрчлөгдөхөд хүргэдэг. Нөгөөтээгүүр, ичгүүр нь бидний бодол санааг өөрсөд дээр маань төвлөрүүлж, өсөлт хөгжилд маань саад учруулдаг.

Мормоны Ном бидэнд хэрхэн наманчлах болон дараа нь Есүс Христэд амар амгаланг мэдрэхийн сайн жишээнүүдийг өгсөн байдаг.

- Аммон өнгөрсөн нүглээ санаснаар Аврагчийг болон Түүний нигүүлслийг магтан дуулахад хүрсэн бөгөөд энэ нь зовлон шаналлын оронд баяр хөөрийг авчирсан юм (Алма 26:17-20).[1]
- Алмагийн "оюун" Есүс Христийн болон Түүний Цагаатгалын "бодол дээр тогтож [тунгаасны]" дараа, тэр "нүглүүдийнхээ санамжинд цаашид тарчлагдахгүй бол[дог]" (Алма 36:17-19). Хэдийгээр ой санамж нь байсан ч тэрээр нүглүүдийнхээ улмаас зовж тарчлахаа больсон юм.[2]

ЭШЛЭЛҮҮД

1. Richard G. Scott, "Peace of Conscience and Peace of Mind," *Liahona,* Nov. 2004, 18-ыг үзнэ үү.
2. Dieter F. Uchtdorf, "Point of Safe Return," *Liahona,* May 2007, 101-ийг үзнэ үү.

Та юу гэж бодож байна вэ?

"Би номлолд үйлчлэх шийдвэрээ хэрхэн гаргах вэ?"

Хэрэв хүсвэл хариултаа өндөр нягтралтай зургийн хамт liahona.lds.org хаягаар ("Submit an Article or Feedback" дээр дар) 2019 оны 1-р сарын 15-ны дотор ирүүлнэ үү.

Хариултын хэмжээг тохируулах эсвэл тодорхой болгохын тулд хянан засварлаж магадгүй.

АВРАГЧИЙН ТӨРӨЛТ

бол

ЭЦЭГИЙГ

"энэ дэлхий дээр амар амгалан болон ирэх дэлхийд мөнх амьдралыг" [С ба Г 59:23] бидэнд өгөх боломжтой болгодог бэлэг юм.

Тэргүүн Зөвлөлийн хоёрдугаар зөвлөх,
ерөнхийлөгч Хэнри Б.Айринг "Амар амгалангийн бэлэг"
(Христийн мэндэлсний баярт зориулсан Тэргүүн Зөвлөлийн онцгой цугларалт, 2016 оны 12-р сарын 4)

© GETTY IMAGES-ИЙН ГЭРЭЛ ЗУРАГ

ИЗРАИЛИЙГ ЦУГЛУУЛАХАД ТУСЛАХЫН ТУЛД **ИХ ЭЗЭНИЙ ӨСВӨР ҮЕИЙНХНИЙ БАТАЛЬОНД** ЭЛС

Би та нарыг өөрийгөө болон дэлхийг өөрчлөхөд тус болох **таван зүйлийг** . . . хийж, өөрийгөө бэлтгэхэд урьж байна.

1. СОШИАЛ МЕДИАГИЙН **ДОЛОО ХОНОГИЙН МАЦАГ** БАРЬ.

2. **ИХ ЭЗЭНД ЗОРИУЛАН** ДОЛОО ХОНОГ ТУТАМ **ЦАГ ЗАВАА ЗОЛИОСОЛ.**

3. **ГЭРЭЭНИЙ ЗАМ** ДЭЭРЭЭ ҮЛД.

4. БҮХ ХҮН САЙН МЭДЭЭНИЙ АДИСЛАЛААС ХҮРТЭЭСЭЙ ХЭМЭЭН **ӨДӨР БҮР ЗАЛБИР.**

5. БУСДААС ЯЛГАР. ТЭДНЭЭС ӨӨР БАЙ. **ГЭРЭЛ НЬ БОЛ.**

ЗУРАГ ЧИМЭГЛЭЛИЙГ GETTY IMAGES

Ерөнхийлөгч Рассэлл М.Нэлсон, “Израилийн итгэл найдвар” (Өсвөр үеийнхний дэлхий даяарх онцгой цугларалт, 2018 оны 6-р сарын 3), 17, 20.

Карлын Христийн мэндэлсний баярын бэлэг

Жулиан Тэннэй Домэн
Бодит түүхээс сэдэвлэв

*"Хийх ажил байвал түүнийгээ инээмсэглэн хийг-түн. Хийхийг хүссэнээс нь илүүг хийгээд хоёр дахь бээрээ явааарай" (*Children's Songbook, *167).*

Карл чичирсээр салхи сөрөн дугуйгаа жийлээ. "Би гэртээ хариад, дулаацмаар байна. Бас Христийн мэндэлсний баярын бэлгүүдээ хурдхан нээж үзэх юмсан!" гэж тэр бодов.

Тэр сонин тараахаар өглөө урьд өмнөхөөсөө ч эрт боссон юм. Тэрээр гэр рүүгээ уул өгсөн дугуйгаа жийхдээ, ээжийнхээ хийдэг Христийн мэндэлсний баярын шанцайтай хуймгийг бодов. Үнэхээр сайхан амттай байна байх. Тэр цөцгийн тостой амтлаг түрхлэгийг нь бараг амтлах шиг болов.

Цөцгийн тос! Карл дахиад л сэтгэлээр уналаа. Тэр үнээгээ сааж, хийх ёстой байсан бусад гэрийн ажлаа хийхээ мартчихаж. Христийн мэндэлсний баяраар хүртэл шүү.

Карл дугуйгаа гэрийнхээ урд тавив. Тэр ахтайгаа сонин тараах ажлаа хэн нь түрүүлж дуусгахыг үзэхээр уралджээ. Карлд ахынх нь дугуй харагдаагүй болохоор тэр ялсан байлаа!

Түрүүлэхийн цорын ганц асуудал бол бэлгээ задлахын тулд ахыгаа ирэхийг хүлээх хэрэгтэй болсон явдал байв. Дараа нь хамтдаа гадагшаа гарч, үлдсэн ажлаа хийх хэрэгтэй. Карл гэртээ үлдэж, Христийн мэндэлсний баяраа тэмдэглэдэг ч болоосой гэж хүсэж байлаа.

"Би гэрийн ажлуудаа одоо хийчих юм бол, дараа нь хүйтэнд эргэж гарах шаардлагагүй болно" гэж Карл бодлоо. Тэгээд тэр малынхаа хашаа руу яаравчиллаа.

Тэр хувин аваад, үнээгээ саахаар суухдаа эргэн тойрноо ажиглав. Өөр хийх хэрэгтэй ажил зөндөө байлаа. Тэгтэл түүнд нэгэн санаа төрөв. Хэрэв тэр гэрийн бүх ажлыг өөрөө хийчихвэл гэр бүлийнхнээ гайхуулаад зогсохгүй, Христийн мэндэлсний баярын өглөө үлдсэн цагаа тэдэнтэйгээ хамт өнгөрөөж болох байв. Энэ бол Христийн мэндэлсний баярын хамгийн сайхан бэлэг болно!

Карл үнээгээ яаравчлан саалаа. Дараа нь тэр малынхаа хашааг цэвэрлэж, тахианууудаа хооллож, өндөгнүүдээ цуглуулав. Гэрийнхэн нь ямар их гайхах бол гэж бодохоор л инээд нь хүрч байлаа.

Тэр байшиндаа эргэж оров. Тэр хүн байгаа эсэхийг харахаар хаалгаараа сэмхэн шагайв. Тэгээд тэр гал тогооны өрөө рүүгээ гэтэж оров. Түүнийг сүү болон өндгөө хөргөгчиндөө хийж дуусангуут ээж нь орж ирлээ.

"Ашгүй дээ, чи ирчихэж" гээд ээж маань намайг тэврэв. "Бид чамайг хаана байгаа юм бол гэж гайхаж байлаа шүү" гэлээ.

Ээж нь түүнд хүрмээ тайлахад нь туслав. Карлын ах, эгч дүүс түүнийг хараад, "Карл гэртээ ирчихлээ. Бэлгээ задалцгаая!" гэж хашгиралдав. Бүгд Христийн мэндэлсний баярын сүлд модыг тойрон цуглаад, аавынхаа бэлэг өгөхийг хүлээлээ. Карл хүн бүрийг эрдэнэсээ хуваалцаж байхыг харах дуртай байв.

"За!" гэсээр аав нь "Одоо гэрийн ажлаа хийцгээе. Гэхдээ эхлээд шанцайтай хуймгаа идээд, жимсний шүүс уух хэрэгтэй гэж бодож байна" гэв.

Аав гал тогооны өрөөнд ороод, хөргөгч онгойлгов. Тэр зогсоод, удаан ширтэв.

"Үүнийг хараач ээ!" гээд, аав "Сүүний шилэн сав аль хэдийн дүүрч, бас өндөгнүүдийг цуглуулчихаж! Эдгээрийг хэн хийчих нь энэ вэ?" гэлээ.

Аав зочны өрөөнд эргэж орж ирэв. Карл инээмсэглэлээ нуух гэж чадлаараа хичээв.

"Карл, чи энэ талаар ямар нэгэн зүйл мэдэх үү?" гэсээр аав инээмсэглээд, "Гэрийн ажлыг маань хийчихсэн бололтой" гэж хэллээ.

"Христийн мэндэлсний баярын мэнд хүргэе!" хэмээн Карл чангаар хашхирав.

Аав нь Карлыг тэвэрч, "Баярлалаа, хүү минь. Үнэхээр сэтгэсэн байна шүү. Энэ бидний хамгийн гайхалтай Христийн мэндэлсний баярын бэлэг байх!" гэлээ.

Карл инээмсэглэв. Энэ бол *түүний* хувьд хамгийн шилдэг Христийн мэндэлсний баяр гэдгийг тэр аль хэдийн мэдэж байлаа. ■

Зохиогч нь АНУ-ын Колорадод амьдардаг.

ЗУРАГ ЧИМЭГЛЭЛИЙГ ГРЭГ НЬЮБОЛД

Кэйти, Квинси хоёр

Эван Валентайн, Марисса Виддисон
Бодит түүхээс сэдэвлэв

“Анд найзууд ямар ч үед бие биеэ хайрладаг” (Сургаалт үгс 17:17).

Кэйти дуулах, бас бүжиглэх дуртай байлаа. Гэвч тэр ням гаргуудад юу юунаас ч илүү дуртай байв. Тэр энэ л үед найз Квинситэйгээ уулздаг байлаа.

Кэйти Дауны синдромтой. Заримдаа сүм дээр байхдаа тэр эргэлзэж, юу хийхээ мэдэхээ больдог. Гэхдээ Квинси өөрт нь туслахаар тэнд байгаа гэдгийг тэр мэддэг байв.

Квинси Кэйтигийн гараас хөтлөн, түүнийг Хүүхдийн хэсэгт аваачдаг байлаа. Кэйти заримдаа хуваалцах цагаар сандрахад нь Квинси түүнийг тэвэрдэг. Энэ нь Кэйтийг тайвшрахад нь дандаа тус болдог. Хуваалцах цагийн дараа Квинси Кэйтийг ангиа олоход нь тусалдаг байлаа. Кэйти Квинсид хайртай байв.

Нэгэн өдөр Кэйти Квинсигийн гэр бүлд гунигтай зүйл тохиолдсоныг олж мэдлээ. Квинсигийн ах Кори нас барсан байлаа! Кэйти найзыгаа маш их гунигтай байгааг мэдэж байв. Тэр Квинсиг том ахдаа маш их хайртай байсныг мэднэ.

Ээж нь Кэйтид хүмүүс өнөө орой Квинсигийн гэр бүлд хайраа үзүүлэхээр сүмийн байранд цугларна гэж хэлсэн байлаа. Харин маргааш нь Коригийн оршуулга болох байв.

“Чи өнөө орой аав бид хоёртойгоо сүм рүү явахыг хүсэж байна уу?” гэж ээж нь Кэйтигээс асуулаа.

Кэйти толгой дохив. Тэр Квинсид хайртай гэдгээ хэлэхийг хүсэж байлаа.

Ээж нь Кэйтид сайхан хувцас өмсөхөд нь туслав. Дараа нь тэд сүм рүү машинаараа явлаа.

Тэднийг тэнд очиход Кэйти олон хүн ирснийг харав. Тэдний зарим нь сүмийнх гэдгийг тэр мэдэж байв. Тэр бишопоо, Хүүхдийн хэсгийн ерөнхийлөгчөө харав. Гэвч тэр найзыгаа олж харсангүй.

“Ээж ээ, Квинси хаана байна вэ?” гэж Кэйти асуулаа.

Ээж нь мэдэхгүй байв.

“Бид яагаад өөр хэн нэгнээс асууж болохгүй гэж?” хэмээн ээж нь хэлэв.

Кэйти ер нь олон хүнтэй ярих дургүй байлаа. Гэхдээ өнөө орой тэр Квинсийг олох хэрэгтэй. Кэйтид зориг орох шиг болов. Тэр бишоп руугаа алхан очоод,

“Квинси сэтгэлээр унасан байгаа. Би Квинсиг олох хэрэгтэй!” гэж хэллээ.

ЗУРАГ ЧИМЭГЛЭЛИЙГ КАТИ ПЭЙН

Бишоп инээмсэглээд, түүний гараас хөтөлж, “Тэгвэл Квинсиг хайхаар явцгаая” гэв.

Кэйти бишоп, ээж хоёртойгоо хамт сүмийн байрыг тойрон явлаа. Эцэст нь тэд түүнийг олов. Квинси буланд сууж байлаа. Тэр үнэхээр гунигтай харагдаж байв.

Кэйти найз дээрээ алхаж очин, гараа алдлан тэвэрлээ. Квинси ахыгаа хэчнээн их санаж байгаа бол гэж тэр бодов.

“Зүгээр дээ, Квинси. Есүс Корид санаа тавих болно” гэж Кэйти хэлээд, Квинсигийн үсийг болгоомжтой, маш зөөлөн иллээ.

Квинси ч уйлж эхлэв. Кэйти түүнийг улам чанга тэврэв.

“Зүгээр дээ. Есүс Корид санаа тавих болно” гэж Кэйти хэлэв.

Квинси уйлсаар л байлаа. Кэйти ч найзаа тэвэрсээр л. Хэсэг хугацааны дараа Квинси арай тайвшрав. Тэр шуухитнаж байсан ч айхавтар сүрхий уйлахаа больсон байлаа. Тэр Кэйти рүү харж,

“Баярлалаа, Кэйти. Чиний зөв. Есүс ахад минь санаа тавих болно” гэж хэлэв.

Кэйти найзаа тайвшруулж чадсандаа баяртай байлаа. Тэр Квинсид хайртай байв! ■

Зохиогчид нь АНУ-ын Юта мужид амьдардаг.

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ НАЙЗУУД

Зарим хөгжлийн бэрхшээл биеийн ажиллагаанд саад болдог. Зарим хөгжлийн бэрхшээл тархины ажиллагаанд нөлөөлдөг. Харин зарим хүний хөгжлийн бэрхшээл тархи болон биеийнх нь аль алинд нөлөөлдөг. Ямартай ч, хүүхэд бүр Бурханы чухал бөгөөд хайртай хүүхэд нь билээ!

Хэрэв та хөгжлийн бэрхшээлтэй хүнтэй тааралдвал:

Хийж болохгүй зүйлс . . .

- Гөлрөх, гар хуруугаараа заах, тэдний талаар шивнэлдэх
- Тэднийг тоохгүй орхих
- Тэднээр тохуурхах
- Гоочилсон нэрээр тэднийг дуудах

Хийж болох зүйлс . . .

- Мэндэлж, найрсаг хандах
- Боловсон байдлаар асуух
- Бусад хүн гоочилбол тэднийг өмөөрөх
- Тэд бол яг тантай адил Бурханы хүүхэд гэдгийг санах!

Хүндэтгэл бол хайр

Луайпоу В., 10 настай, Австралийн Викториа

Баасан гарагт манай багш надаас бичсэн шүлгээ сургуулийн цуглаан дээр бүх сурагч, багш, эцэг эхийн өмнө уншихыг хүсэв. Би маш их баярлаж, “За!” гэж хариулсан. Гэхдээ би үнэхээр их сандарч байлаа.

Шүлгээ уншихаа хүлээн, тайзан дээр сууж байхад зүрх минь түг түг цохилж эхлэв. Би бичсэн зүйлээ олон хүний өмнө хуваалцана гэхээс их санаа зовж байлаа.

Тэгтэл надад нэг санаа төрөв. Би сургуульд ирэхээсээ өмнө өглөө бүр гэр бүлийнхэнтэйгээ хамт Мормоны Номоос хэрхэн уншдаг талаараа бодов. Гэрийнхэнтэйгээ хамт судар унших тухай бодол намайг Тэнгэрлэг Эцэгийг бодоход хүргэсэн. Тэр намайг хэр их хайрладаг талаар бас бодов. Би тайвширч, ганцаардахаа больсон байв. Зүрх минь түргэн цохилохоо больж, надад хүндэтгэл бишрэл л мэдрэгдэж байлаа.

Хүүхдийн дууны номны 31-р хуудсанд байх дууны шүлэгт,

Хүндэтгэл бол чимээгүй суухаас илүү зүйл
Хайрт Бурхан Эцэгээ санаж бодохыг,
Түүний олон адислалыг мэдрэхийг хэлнэ.
Би бишрэл хүндэтгэлтэй байна.
Би үүнийгээ өөрийн үйлсээр харуулна.
Дагах зам маань тодорхой юм.
Бишрэл хүндэтгэлээ харуулахад Есүс,
Бурхан хоёр ойр гэдгийг мэддэг.

Би сургуулийн цугларалт дээр сандарч байхдаа, Тэнгэрлэг Эцэгийн хайрыг мэдэрсэндээ ихэд талархдаг. Тэр надад маш их хайртай гэдгийг олж мэдсэндээ би баярлаж байна.

Хүнд хэцүү нөхцөлд би бишрэл хүндэтгэлтэй байж, Бурханыг бодож болно гэдгийг мэднэ. ■

ГЭРЭЛ ЗУРГИЙГ ЛАУРА ЗАРИИН

Далын
Ахлагч Адилсон дэ Паула Паррэлла

Шавар шавхайнаас аварсан нь

"Би Аврагчийн хайрыг мэдэрдэг" (Хүүхдийн дууны ном, *42–43).*

Манай гэр бүл Бразилын Сан Паулод амьдардаг байлаа. Гудамжны нөгөө талд мангро модны ой байдаг байв. Мангро модны ойн дундуур гол урсан өнгөрдөг байлаа. Хөрс нь их намгархаг байдаг байв.

Олон хүн тэр намгархаг хөрсөн дээр байшин барьцгаасан. Тэд намагт маш том гуалингууд тавиад, дээр нь байшингуудаа барьцгаасан юм. Харин бороо ороход гол үерлэж, ус байшин руу нь орох үед хүмүүс шөнөдөө унтах газаргүй болдог байв.

Ийм зүйл тохиолдоход аав тэднийг бүгдийг нь гэртээ урьдаг байлаа. Заримдаа манайд бүр 15-аас ч олон хүн байдаг байв! Аав тэднийг зочны өрөөндөө оруулаад, хөнжил өгч, ээж тэдэнд ямар нэг идэх зүйл хийж өгдөг байсан юм. Дараа нь тэд дараагийн өдөр хүртэл манай байшинд унтдаг байв.

Ийм тохиолдол дор хаяж гурваас дөрвөн удаа болж билээ. "Гадны хүмүүсийг гэртээ оруулдаг хүн ч цөөхөн дөө" гэж боддог байснаа би санадаг. Аав маань зүс таних төдий хүмүүсийг байшиндаа оруулан хонуулдаг байсан гээч! Гэвч би "тэдэнд өөр очих газар байхгүй шүү дээ" гэж боддог байв.

Эцэг эх маань хүмүүст ямар нэг зүйлээр үргэлж тусалдаг байв. Гэхдээ тэдний үйлчлэл зүгээр нэг тусалж мөн өгөхөөс илүү зүйл байсан юм. Энэ нь хөрш маань сайн танихгүй хүн байсан ч гэсэн хөршөө хэрхэн хайрлахыг харуулдаг байв.

Бид тусламж хэрэгтэй хүмүүст тусламжийн гараа сунгах ёстой. Бид тэдэнд чадах чинээгээрээ туслах хэрэгтэй. Хүмүүст туслахын тулд хийж болох зүйлдээ бид хязгаар тавих ёсгүй. Бид орогнох байр болон нөөц боломжоосоо хуваалцаж болно. Бид мөн цаг заваа хуваалцаж болно. Эцэст нь бид Христийн мэндэлсний энэ баярын үеэр, ялангуяа Тэнгэрлэг Эцэгийн болон Есүс Христийн талаарх өөрсдийн мэдлэгийг хуваалцаж болно. ■

ЗУРАГ ЧИМЭГЛЭЛИЙГ АДАМ КОФОРД

ЗУРАГ ЧИМЭГЛЭЛИЙГ ОБРИ БЛАКХАМ

“Есүс Христ амьд бөгөөд дэлхийн Аврагч, Гэтэлгэгч. Тэрээр жинхэнэ аз жаргалд хүргэх замыг өгсөн.”

Арван хоёр Төлөөлөгчийн Чуулга
Ахлагч Квинтин Л.Кук

“Бид Есүс Христийг дагадаг,” Liahona, *May 2010, 86.*

БИДНИЙ ХУУДАС

Би баптисмын ус руу орж, Есүс Христийн Сүмийн гишүүнээр батлуулахдаа маш их баярлаж байсан. Хэрвээ би цэвэр ариун хэвээр үлдэж, зарлигуудыг дагавал Ариун Сүнс миний итгэлт хамтрагч байх болно. Би Бурхан амьд, намайг хайрладаг, Сүм үнэн мөн Мормоны Ном үнэн гэдгийг мэднэ.

Хуан О., 8 настай, Колумбын Кали



"Би Тэнгэрлэг Эцэгийн төлөвлөгөөнд хайртай," Ирреантум Д. мөн "Би хүн бүртэй хуваалцмаар байна," Вөрланн Т., Филиппинийн Лузон

***"Их Эзэний номлогчид,"* Эмилио А., 9 настай, Аргентины Формоза**

Төрсөн өдөр бүр онцгой байдаг. Гэхдээ би жаахан байхаасаа баптисмдаа бэлтгэсээр ирсэн. Би одоо баптисм хүртэж, үнэхээр аз жаргалтай байна. Тэнгэрлэг Эцэг надад баярлаж байгаа бөгөөд намайг хайрладаг гэдгийг би мэднэ.

Данна М., 9 настай, Гватемалагийн Чималтинанго

Дэлхийг гэрэлтүүлдэг ах нар

Сайн уу!

Биднийг Хюбэрт болон Жэйдэн гэдэг.

1

Жэйдэн: Христийн мэндэлсний баярын дуу

Манай ангийнхан Христийн төрөлтийн тухай жүжиг тоглосон бөгөөд би хөгжмийг нь төгөлдөр хуур дээр тоглосон. Би хүн бүрд "Ариун шөнө" дууг зааж өгсөн.

2

Жэйдэн: Хөршүүддээ заах

Би хөршүүддээ үйлчлэхийг хүсдэг тул тоглож байхдаа тэдэнд заах дуртай. Матай 5:16-д Есүс бидэнд өөрсдийнхөө гэрлийг гэрэлтүүл гэж заасан. Би үүнийг хийхдээ их баяртай байдаг.

3

Хюбэрт: Өлссөн хүмүүст туслах

Хичээлийнхээ завсарлагаанаар би өлссөн, идэх юм юу ч байхгүй хүмүүсийг хардаг. Би идэх юмнаасаа хуваалцаж, тэднийг өлсөхөө болиход нь тусалдаг. Хуваалцсаны дараа надад сайхан байдаг.



4

Хюбэрт: Төгөлдөр хуур тоглох

Би сүм дээр гишүүдийг дуулахад төгөлдөр хуур тоглодог. Би үүндээ их баяртай байдаг.

Бид Гана улсад амьдардаг. Манай Аккра хот Атлантын далайн ойролцоо байдаг. Энд бас маш үзэсгэлэнтэй ариун сүм бий.

5

Дэлхийг гэрэлтүүлцгээе

Есүс Христ бол энэ дэлхийн гэрэл бөгөөд амьдрал гэж сударт хэлсэн. Тиймээс дэлхийг гэрэлтүүлцгээе!

***Лиахона* руу оддоо илгээсэнд тань баярлалаа.**

Энэ жил та нар хайрын үйлчлэлийнхээ мянга мянган од, түүхээр тэнгэрийг маань дүүргэлээ. Та нар гэрлээ үнэхээр гэрэлтүүлсэн байна!

Иона ба халим

Ким Вэбб Рэйд

Бурхан Ионад номлолд яв гэж хэлжээ. Тэр Ниневе гэдэг хот руу очиж, хүмүүсийг наманчлалд дуудах ёстой байв. Гэвч Иона тийшээ явахыг хүссэнгүй. Тэр усан онгоцонд суугаад, өөр хот руу явав.

Их хүчтэй шуурга боллоо. Усан онгоцоо живэх нь хэмээн далайчид айж эхлэв!

ЗУРАГ ЧИМЭГЛЭЛИЙГ АПРИЛ СТОТТ

Иона зугтсан болохоор өөрөөс нь болж Бурхан шуурга дэгдээснийг мэдэж байлаа. Тэр далайчдад өөрийг нь онгоцноос авч шидвэл шуурга зогсоно гэж хэлэв.



Харин Бурхан Ионаг аврахаар халим явуулав. Халимны гэдсэнд тэр гурав хоногийн турш байв. Иона залбирсан. Тэр наманчилж, Бурханыг дагахаар шийдэв. Бурхан халимд Ионаг хуурай газарт гарга гэж хэллээ.

Иона Ниневе рүү явав. Тэр тэндхийн хүмүүст заажээ. Ниневегийн хүмүүс түүнийг сонсов! Тэд Бурханыг дахин дагаж эхлэв.

Би буруу сонголт хийсэн үедээ наманчилж, дахиад сонголт хийж чадна. Бурхан Ионаг хайрласан ба намайг ч гэсэн хайрладаг! ■

Иона 1–4-р бүлгээс.

“Би үлэмж баярлуулах сайн мэдээг та нарт авчирлаа.”

—Лук 2:10

ЗУРАГ ЧИМЭГЛЭЛИЙГ АПРИЛ СТОТТ

Арван хоёр
Төлөөлөгчийн Чуулгын
Ахлагч Брүс Р.Макконки (1915–1985)

Иосеф Смитээр дамжуулан Христийг таньж мэдэх нь

Христийн болон авралын талаарх мэдлэг нэг л хүнээр дамжин энэ цаг үед ирсэн.

Бид Христэд аврал байдаг хэмээн зааж, гэрчилдэг. Тэр бол бидний Их Эзэн, бидний Бурхан, бидний Хаан. Бид бүх ариун бошиглогч, мөн бүхий л цаг үеийн бүх гэгээнтний адил Түүний нэрээр Эцэгийг бишрэн шүтдэг.

Бид Түүнд болон Түүний цагаатгагч золиослолд баяздаг. Түүний нэр бүх нэрээс илүү чухал бөгөөд Түүний өмнө өвдөг бүхэн сөхөрч, Түүнийг бүхний Их Эзэн гэдгийг хэл бүхэн хүлээн зөвшөөрөх болно. Түүнгүйгээр үхэшгүй байдал ч, мөнх амьдрал ч байх нь үгүй.

Гэвч би одоо өөр нэгний тухай, Христийн тухай мэдлэг болон авралын талаарх мэдлэг энэ цаг үед дамжин ирсэн тэр хүний тухай ярья. . . .

Би Сэргээлтийн агуу бошиглогч, энэ эрин үед тэнгэрлэг дуу хоолойг анх сонссон, арга хэрэгслээр нь дамжуулан Бурханы хаант улс хүмүүний дунд дахин байгуулагдсан Бага Иосеф Смитийн тухай ярьж байна. . . .

1820 оны хавар [Бурхан Эцэг, Өөрийн Хүү Есүс Христийн хамт] олон зууны турш дэлхийг бүрхсэн байсан харанхуйн хөшгийг урж тасдсан. . . . Тэд Нью-Йоркийн Палмирагийн ойролцоох ойн төгөлд Өөрсдийн селестиел гэрээсээ доош буун ирж, залуу Иосефыг нэрээр нь дуудан, . . . Тэдний үүрдийн сайн мэдээний бүрэн байдлыг сэргээхэд мутар дахь зэмсэг нь байх болно гэдгийг түүнд хэлжээ. . . .

Бүх хүн өөрсдөөсөө Иосеф Смит болон түүний тэнгэрлэг зорилгын талаар юу мэддэгээ асуух нь зүйтэй. Тэд түүний нэрийг асууж сураглан, зөвхөн Түүний хожмын үеийн бошиглогчид илчлэгдсэн Христийн сайн мэдээнээс олдог тэрхүү авралыг эрэлхийлдэг үү . . . ? Энэ цаг үеийн бүх хүн өөрсдийн авралыг алдах аюулд орохгүйн тулд, Иосеф Смит Бурханаар дуудагдсан байсан уу? гэсэн агуу асуултад хариулах ёстой. . . .

. . . Буруу ойлголт байх ёсгүй. Бид Христийн гэрчүүд. Тэр бол Аврагч. . . . Гэхдээ бид ч бас Иосеф Смитийн гэрчүүд бөгөөд түүгээр дамжуулан Христийг таньж мэддэг. Тэрээр амьдарч байсан үеэс нь хойших бүх хүнийг авралын өвлөгчид болгохоор дэлхий дээр холбож, тэнгэрт лацдах хүчийг хүлээн авсан хууль ёсны удирдагч юм. ■

"Joseph Smith—The Mighty Prophet of the Restoration," Ensign, *May 1976, 94–96-аас авав. Том үсгийн бичилтийг стандартын дагуу болгов.*

© GETTY IMAGES-ИЙН ГЭРЭЛ ЗУРАГ

ЖЮДИ ВАНГЭМАН,
ХРИСТИЙН ТӨРӨЛТИЙГ
ХАРУУЛСАН ХАВЖ
ОЁСОН БҮТЭЭЛЭГ

“Өнөөдөр Давидын хотод Аврагч, Эзэн Христ та нарын төлөө мэндэллээ.

“Тэжээлийн тэвшинд байх даавуунд өлгийдсөн нялх хүүхдийг та нар олж харна. Энэ нь та нарт тэмдэг болно гэлээ . . . .

“Дээр өндөрт алдар нь Бурханд байх болтугай, доор газарт амар тайван нь Түүний тааллыг олсон хүмүүст байх болтугай гэцгээв” (Лук 2:11–12, 14).

ЗАЛУУЧУУДАД ЗОРИУЛАВ

ТОМ ШИЙДВЭР ГАРГАХ ГЭЖ БАЙНА УУ?

Төгс удирдагч таныг удирдан залж тусална гэдэгт та найдаж болно.

42

"НЭГ БАЙ" БАЯРЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

ЭВ НЭГДЭЛТЭЙГЭЭР УРАГШИЛ

46, 51

ӨСВӨР ҮЕИЙНХЭНД ЗОРИУЛАВ

ХУВИЙН ТОХИНУУЛЛАА ХИЙХ НЬ

52

ХРИСТИЙН МЭНДЭЛСНИЙ БАЯР

БАЯР БАЯСГАЛАНГАА ХУВААЛЦАХ 7 АРГА ЗАМ

56

ҮҮНИЙГ ХРИСТИЙН МЭНДЭЛСНИЙ БАЯРЫН БЭЛГИЙН ЖАГСААЛТДАА НЭМ

60

ЕСҮС ХРИСТИЙН
ХОЖМЫН ҮЕИЙН
ГЭГЭЭНТНҮҮДИЙН СҮМ

MONGOLIAN
4 021497363 4